

Монгол улсын хөдөө орон нутгийн ард
иргэдийн дасан зохицох чадвар болон
эрсдлийн менежментийн чадавхийг
сайжруулах нь

Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх
нөлөөллийн менежментийн
бүтэц, хамрах хүрээ

21 May 2020



**Хавсралт 6 – Байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохион байгуулах бүтэц, хамрах хүрээ**
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖҮҮЛЭЛТИЙН САНАЛ



АГУУЛГА

Агуулга	2
Удиртгал	4
1 Танилцуулга	Error! Bookmark not defined.
1.1 Оршил	Error! Bookmark not defined.
1.2 Төслийн тойм.....	Error! Bookmark not defined.
1.2.1 Үйл ажиллагааны товч хураангуй.....	Error! Bookmark not defined.
1.3 Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх эрсдлийн нөлөөлөл	Error! Bookmark not defined.
1.3.1 Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохион байгуулах бүтэц, хамрах хүрээний хөгжлийн үндсэн ойлголтууд	Error! Bookmark not defined.
1.3.2 Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохион байгуулах бүтэц, хамрах хүрээний зорилго болон зорилтууд	Error! Bookmark not defined.
1.3.3 Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохион байгуулах бүтэц, хамрах хүрээний хурдавчилсан үнэлгээний журам.....	Error! Bookmark not defined.
1.3.4 Газартай холбоотой асуудлууд.....	Error! Bookmark not defined.
1.3.5 Нутгийн уугуул ард иргэд	Error! Bookmark not defined.
1.4 Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохион байгуулах бүтэц, хамрах хүрээний төлөвлөгөөнд чиглэсэн институтын зохицуулалтын тухай тойм	Error! Bookmark not defined.
1.4.1 Удирдлага	Error! Bookmark not defined.
1.4.2 Чадавхи бэхжүүлэх	Error! Bookmark not defined.
2 Байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөллийн асуудлын эрх зүйн болон институтын бүтэц, хамрах хүрээ	Error! Bookmark not defined.
2.1 Хууль тогтоомж, бодлого, эрх зүйн зохицуулалтууд.....	Error! Bookmark not defined.
2.2 Монгол улс дахь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ.....	Error! Bookmark not defined.
2.3 Олон талт хэлэлцээрүүд болон Биологийн олон янз байдлын тухай протоколууд	Error! Bookmark not defined.
2.4 Эрх зүйн зохицуулалтын бүтэц, хамрах хүрээ болон бодлогод оруулсан хувьд нэмэр ...	Error! Bookmark not defined.
2.4.1 Уур амьсгалын ногоон сангийн Хамгаалалтын стандарт хэм хэмжээтэй Монгол улсын хууль тогтоомж болон бодлогыг уялдуулан нийцүүлэх	Error! Bookmark not defined.
3 Хэрэгжилт болон ашиглалтын үйл ажиллагаа	Error! Bookmark not defined.
3.1 Менежментийн ерөнхий бүтэц, тогтолцоо болон үүрэг хариуцлага	Error! Bookmark not defined.
3.1.1 Төслийн удирдах хороо болон дэд хороод	Error! Bookmark not defined.
3.1.2 Төслийн удирдлага, зохион байгуулалтын (менежментийн) үндэсний нэгж	Error! Bookmark not defined.
3.2 Төслийн хүрээнд гүйцэтгэх ажил ба удирдлага	Error! Bookmark not defined.
3.2.1 Төслийн хүрээнд гүйцэтгэх ажил	Error! Bookmark not defined.
3.2.2 Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохион байгуулах бүтэц, хамрах хүрээний (EMSF) удирлага.....	Error! Bookmark not defined.
3.2.3 Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохион байгуулах төлөвлөгөө (ESMPs), Байгаль орчны журам, тухайн газар ба үйл ажиллагаанд чиглэсэн ажлын төлөвлөгөө/зааварчилгаа.....	Error! Bookmark not defined.
3.2.4 Байгаль орчинд учирсан хэрэг, ослын талаарх тайлагнал ..	Error! Bookmark not defined.
3.2.5 Байгаль орчны хяналт шалгалтын өдөр тутмын ба долоо хоног тутам шалгах зүйлсийн жагсаалт	Error! Bookmark not defined.
3.2.6 Залруулж, сайжруулах арга хэмжээ	Error! Bookmark not defined.
3.2.7 Нягтлан шалгаж, аудит хийх тухай.....	Error! Bookmark not defined.
3.2.8 Хяналт, шинжилгээ, үнэлэлт дүгнэлт ба тайлагнал.....	Error! Bookmark not defined.
3.3 Сургалт	Error! Bookmark not defined.
4 Харилцаа холбоо	Error! Bookmark not defined.
4.1 Олон нийтийн зөвлөгөөн болон Байгаль орчин ба нийгэмд үзүүлсэн нөлөөллийн талаарх мэдээллийг ил тод болгох	Error! Bookmark not defined.
4.2 Өргөдөл, гомдлын бүртгэл, Гомдол барагдуулах механизм.....	Error! Bookmark not defined.
4.2.1 Өргөдөл гомдлын бүртгэл	Error! Bookmark not defined.
4.2.2 Гомдол барагдуулах механизм.....	Error! Bookmark not defined.

5	Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийн гол хэмжүүр үзүүлэлтүүд	Error! Bookmark not defined.
	defined.	
5.1	Уур амьсгал	Error! Bookmark not defined.
5.2	Экологи	Error! Bookmark not defined.
5.2.1	Үндсэн суурь үзүүлэлтүүд	Error! Bookmark not defined.
5.2.2	Уулархаг, өндөрлөг газрын экосистемийн төрлүүд – Тал хээрийн өвст тал, бэлчээрийн газар	Error! Bookmark not defined.
5.2.3	Уулархаг, өндөрлөг газрын экосистемийн бусад төрлүүд....	Error! Bookmark not defined.
5.2.4	Нуур болон чийглэг, намагшсан газрын экосистемийн төрлүүд	Error! Bookmark not defined.
	defined.	
5.2.5	Рамсарын конвенцоор хамгаалагдсан чийглэг, намагшсан газар	Error! Bookmark not defined.
	defined.	
5.2.6	Тусгай хамгаалалттай газар.....	Error! Bookmark not defined.
5.2.7	Ургамлын болон амьтны аймаг	Error! Bookmark not defined.
5.2.8	Устах аюулд өртөөд буй нэн ховор төрөл зүйл.....	Error! Bookmark not defined.
5.2.9	Гүйцэтгэлийн шалгуур	Error! Bookmark not defined.
5.2.10	Хяналт, шинжилгээ	Error! Bookmark not defined.
5.2.11	Тайлагнах.....	Error! Bookmark not defined.
5.3	Газрын хэвлийн ус, гүний доорх ус.....	Error! Bookmark not defined.
5.3.1	Үндсэн суурь үзүүлэлтүүд	Error! Bookmark not defined.
5.3.1	Гүйцэтгэлийн шалгуур	68
5.3.2	Хяналт, шинжилгээ	Error! Bookmark not defined.
5.3.3	Тайлагнал	Error! Bookmark not defined.
5.4	Газрын гадаргын ус.....	Error! Bookmark not defined.
5.4.1	Үндсэн суурь үзүүлэлтүүд	Error! Bookmark not defined.
5.4.2	Зорилтот хэсгүүд	Error! Bookmark not defined.
5.4.3	Гүйцэтгэлийн шалгуур	Error! Bookmark not defined.
5.4.4	Хяналт, шинжилгээ	Error! Bookmark not defined.
5.4.5	Тайлагнал	Error! Bookmark not defined.
5.5	Хөрсний элэгдэл, ус хурах сав газар/дренаж, тунадас, хуримтлалын хяналт	Error! Bookmark not defined.
	not defined.	
5.5.1	Үндсэн суурь үзүүлэлтүүд	Error! Bookmark not defined.
5.5.2	Хөрс.....	76
5.5.3	Гүйцэтгэлийн шалгуур	Error! Bookmark not defined.
5.5.4	Хяналт, шинжилгээ	Error! Bookmark not defined.
5.5.5	Тайлагнал	Error! Bookmark not defined.
5.6	Хог, хаягдлыг зохион байгуулах	Error! Bookmark not defined.
5.6.1	Үндсэн суурь үзүүлэлтүүд	Error! Bookmark not defined.
5.6.2	Гүйцэтгэлийн шалгуур	Error! Bookmark not defined.
5.6.3	Хяналт, шинжилгээ	Error! Bookmark not defined.
5.6.4	Тайлагнал	Error! Bookmark not defined.
5.7	Дуу чимээ болон чичирхийлэл	Error! Bookmark not defined.
5.7.1	Үндсэн суурь үзүүлэлтүүд	Error! Bookmark not defined.
5.7.2	Гүйцэтгэлийн шалгуур	Error! Bookmark not defined.
5.7.3	Хяналт, шинжилгээ	Error! Bookmark not defined.
5.7.4	Тайлагнал	Error! Bookmark not defined.
5.8	Агаарын чанар	Error! Bookmark not defined.
5.8.1	Үндсэн суурь үзүүлэлтүүд	Error! Bookmark not defined.
5.8.2	Гүйцэтгэлийн шалгуур	Error! Bookmark not defined.
5.8.3	Хяналт, шинжилгээ	Error! Bookmark not defined.
5.8.4	Тайлагнал	Error! Bookmark not defined.
5.9	Нийгэмд үзүүлэх нөлөөллийн удирлага, зохион байгуулалт	Error! Bookmark not defined.
5.9.1	Үндсэн суурь үзүүлэлтүүд	Error! Bookmark not defined.
5.9.2	Хүйсийн тэгш байдал	Error! Bookmark not defined.
5.9.3	Соёлын өв хөрөнгө.....	Error! Bookmark not defined.
5.9.4	Гүйцэтгэлийн шалгуур	Error! Bookmark not defined.
5.9.5	Тайлагнал	Error! Bookmark not defined.
5.10	Онцгой байдлын удирлага, зохион байгуулалтын арга хэмжээ...	Error! Bookmark not defined.
5.10.1	Гүйцэтгэлийн шалгуур	Error! Bookmark not defined.



Хавсралт 6 – Байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохион байгуулах бүтэц, хамрах хүрээ

УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН САНХҮҮЖҮҮЛЭЛТИЙН САНАЛ

5.10.2	Хяналт, шинжилгээ	Error! Bookmark not defined.
5.10.3	Тайлагнал	Error! Bookmark not defined.
6	Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохион байгуулах бүтэц, хамрах хүрээг хэрэгжүүлэх төсөв хөрөнгө.....	Error! Bookmark not defined.

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Figure 1 Төслийн хүрээнд хамруулж ажиллах газрыг харуулсан газрын зураг **Error! Bookmark not defined.**

Figure 2 Төслийн зохион байгуулалтын бүтэц, тогтолцоо **Error! Bookmark not defined.**

Figure 3 Цельсээр илэрхийлсэн °C жилийн температур болон мм-ээр илэрхийлсэн жилийн хур тунадасны хэмжээг газар зүйн байршлаар харуулсан зураг **Error! Bookmark not defined.**

Figure 4 Монгол орны байгалийн бүс нутгууд..... **Error! Bookmark not defined.**

Figure 5 Монгол орон дахь Рамсарын конвенцоор хамгаалагдсан газрууд **Error! Bookmark not defined.**

Figure 6 Монгол орон дахь тусгай хамгаалалттай газрууд..... **Error! Bookmark not defined.**

Figure 7 Монгол орны геологи..... **Error! Bookmark not defined.**

Figure 8 Монгол орны гадаргын усны нөөцийн сүлжээ **Error! Bookmark not defined.**

Figure 9 Монгол орны хөрс..... **Error! Bookmark not defined.**

УДИРТГАЛ

Агаарын температур нэмэгдэж, хур тунадас багасч, хатаж хуурайших хандлагатай болж байгаа нь бэлчээр, усны эх үүсвэрт нөлөөлж, улмаар Монгол орны байгалийн бүс нутгуудын хил хязгаар өөрчлөгдөхөд хүргэж байна. Өвлийн эрс тэс гамшиг (зуд), ган, цасан болон шороон шуурга, шар усны үер, хэт хүйтрэл болон хэт халалтын давалгаа зэрэг эрс тэс үйл явдлын давтамж болон эрчим нэмэгдэж байгаатай холбоотой өөрчлөлтүүд ажиглагдаж байна. Уур амьсгалын нөлөөнд хариу арга хэмжээ авах тухай эсвэл тэдгээр хариу арга хэмжээ авснаар газар нутаг болон усны нөөц баялагт үзүүлж болох үр нөлөөтэй холбогдуулсан уур амьсгалын тухай мэдээллээр малчдыг сайн хангаж өгөөгүй байдаг байна. Малчны тогтвортой бус арга дадал болон малын тоо толгой нь улам эмзэг болж буй экосистем ба түүнтэй холбогдох экосистемийн үйлчилгээнд улам бүр дарамж болсоор байна.

Малчин өрхүүд Монгол улсын хүн амын гуравны нэгийг бүрдүүлдэг бөгөөд тэд уур амьсгалын эрсдэлд хамгийн их өртдөгийн зэрэгцээ уур амьсгалын эрсдэл ба түүний цар хэмжээнд малчин өрхүүд хамгийн ихээр эрсдэл үүрэх магадлалтай байдаг тул, тухайн нөхцөл байдалд нь нийцүүлэн хөндлөнгийн оролцоотойгоор нөлөөлөл үзүүлэх нь амьжиргаа, тухайн салбар, эдийн засаг болон байгаль орчныг өөрчлөн шинэчлэхэд дэмжлэг болж болохуйц нөлөөлөл үзүүлэх бас боломжтой гэсэн үг юм.

Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохион байгуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээг (ESMF), Монгол улсын засгийн газраас гаргасан Уур амьсгалын ногоон санд (GCF) хандаж гаргасан “Монгол улсын хөдөө орон нутгийн ард иргэдийн дасан зохицох чадвар болон эрдслийн удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах нь” нэртэй төслийн саналыг дэмжиж, боловсруулсан болно.

Төслийн зорилтот бүс нутаг нь дөрвөн аймагт төвлөрч байгаа болно: Ховд, Завхан, Дорнод, Сүхбаатар аймгууд. (Эдгээр аймгууд нь өвст хээр тал, цөлөрхөг хээр тал, уулархаг, уулархаг хээр тал, ойт хээр тал гэсэн бүс нутгуудыг хамарч байдаг. Энэ төслийн зорилго нь уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг эдгээр дөрвөн аймагт амьдарч буй, байгалийн нөөцөөс хамааралтай байдаг нутгийн малчин ард иргэдийн хувьд тэсвэртэй уян хатан чанарыг нь бэхжүүлэх явдал юм. Энэхүү зорилтондоо хүрэхийн тулд өөр хоорондоо уялдаа холбоотой гурван гарц бүтээгдэхүүнийг хэрэгжүүлэх болно, үүнд:

- Уур амьсгалын талаарх мэдээллийг газар болон усны нөөцийн ашиглалтын төлөвлөлтөнд уялдуулан, үндэсний болон аймаг, орон нутгийн түвшинд нэгтгэх
- Уур амьсгалд тэсвэртэй уян хатан, ус ба хөрсний зохицуулалтын арга туршлагыг малчдын түвшинд байгалийн нөөцийг удирдан, зохицуулах бага оврын бүтэц, тогтолцоо болгон өргөжүүлэх



GREEN
CLIMATE
FUND

Хавсралт 6 – Байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохион байгуулах бүтэц, хамрах хүрээ

УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖҮҮЛЭЛТИЙН САНАЛ

- Тогтвортой замаар бэлтгэн нийлүүлсэн, уур амьсгалын нөлөөлөлд тэсвэртэй уян хатан чанартай мал аж ахуйн бүтээгдэхүүнд чиглэсэн зах зээлд нэвтрэх малчдын чадавхийг буй болгох

Төсөлд тооцоолж үзсэний дагуу 800,000 хүнд (ойролцоогоор 130,000 хүмүүст шууд, 800,000 хүмүүст шууд бус замаар) үр ашигаа өгнө гэж үзэж байгаа бөгөөд тэдний 50% нь эмэгтэйчүүд байх юм. Уг төслийг Үндэсний агентлагууд, аймаг, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын төлөөллүүд, мөн ТББ-ууд, ИНБ-ууд болон нутгийн ард иргэдийн төлөөлөлтэй уулзаж, зөвлөлдсөний үр дүнд боловсруулсан болно. Хамтрагч талуудтай зөвлөлдөх замаар төслийн гарц бүтээгдэхүүн болон санал болгож буй үйл ажиллагаануудыг зохих түвшинд баталгаажуулж, нутгийн ард иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлсэн болно.

Энэхүү Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан зохион байгуулах бүтэц, хамрах хүрээ (ESMF) төслийн санал болон түүний хэрэгжүүлэлтэнд дэмжлэг үзүүлэхээр бэлтгэсэн болно. ESMF-ийг НҮБ-ын Нийгэм ба байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаарх стандарт журмыг ашиглан [санал болгож буй] үйл ажиллагаануудыг нь хурдавчилсан байдлаар дүн шинжлэх замаар олж тогтоосон эрсдлүүдэд тулгуурлан бэлтгэн боловсруулсан болно. Төслийн эрсдлийн төлөв байдлыг дунд зэргийн (Б Ангилал) гэж тодорхойлсон болно. Эрсдлүүдийг хүлээн зөвшөөрч болохуйц бөгөөд [сөрөг] нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх замаар удирдан, зохицуулах боломжтой гэж үзсэн.

Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан зохион байгуулах бүтэц, хамрах хүрээ нь (ESMF) төслийг хэрэгжүүлэх явцад шаардагдах магадлалтай, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төрлүүдийг товч тоймлон гаргасан болно. Шаардлагатай тохиолдолд тухайн газар нутагтай холбогдолтой, байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан зохион байгуулах төлөвлөгөөг (ESMPs), эсвэл тухайн газарт хэрхэн ажиллах тухай зааварчилгааг, тодорхой асуудлыг шийдэх хүрээнд боловсруулан бэлдэж болно.

ESMF-ийг ашиглах замаар төслийн зүгээс үзүүлэх үр нөлөөг тодорхой түвшинд хүртэл нь удирдан зохион байгуулах боломжтой гэж үзэж байна.

1 Танилцуулга

1. Энэхүү Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохион байгуулах бүтэц, хамрах хүрээг (EMSF) Монгол улсын засгийн газраас Уур амьсгалын ногоон санд (GCF) санал болгож буй “Монгол улсын хөдөө орон нутгийн ард иргэдийн дасан зохицох чадвар болон эрсдлийг удирдан, зохицуулах чадварыг сайжруулах нь” төслийн саналыг дэмжих үүднээс бэлтгэн боловсруулсан болно. GCF-ийн Итгэмжлэгдсэн байгууллагын үүрэг гүйцэтгэгдийн хувьд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP) уг төслийг дэмжиж байгаа бөгөөд уг төслийг НҮБХХ-ийн Нийгэм ба байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаарх стандарт журмын дагуу хурдавчилсан байдлаар дүн шинжилж үзээд, Дунд зэргийн (Б Ангилал) эрсдэлтэй төсөл гэж үзсэн байгаа. Ийнхүү Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохион байгуулах бүтэц, хамрах хүрээг (EMSF) уг төсөлд зориулан бэлтгэн боловсруулсан болно.

1.1 Оршил

2. НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр Монгол улсын Засгийн газар нь Уур амьсгалын ногоон санд (GCF) өргөн барихаар хөдөө орон нутгийн ард иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийг боловсруулж байна. Уг төсөл нь дөрвөн аймагт оршин суудаг, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд эмзэг, байгалийн нөөцөөс хамааралтай байдаг малчин ард иргэдийн хувьд тэсвэртэй, уян хатан чанарыг бэхжүүлэхийг эрэлхийлэх болно.
3. Монгол улс бол Зүүн Азийн бүс нутагт оршдог далайд гарцгүй орон бөгөөд БНХАУ болон ОХУ хоёрын хооронд байрладаг. Монгол орны нийт газар нутаг нь 1,564,116 хавтгай дөрвөлжин км бөгөөд газар нутгийнхаа хэмжээгээр дэлхийд 18-д оршдог, хамгийн тархай сийрэг оршин амьдардаг, 3 сая орчим хүн амтай орон юм (хүн амын нягтрал 1.9)
4. Тус улс газар тариалангийн зориулалттай газар маш бага, газар нутгийн ихэнх нь өвст хээр талаар хучигдсан, хойд ба баруун хэсгээрээ уулархаг, өмнөд хэсгээрээ Говь, цөлөрхөг бүс нутагтай (2015 онд нэг хавтгай дөрвөлжин км талбайд оногдох байдлаар нь тооцсон дүнгээр).
5. Уур амьсгалын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай, улирлуудын ялгаа илт хурцаар илэрдэг, жилийн болон өдрийн агаарын температурын хэлбэлзэл ихтэй, хур тунадас унах нь бага байдаг. Жилийн агаарын дундаж температур -80С-аас 80С, зуных нь дунджаар 100С-260С, өвлийнх нь дундажаар -150С-аас -300С байдаг. Жилийн хур тунадас нь 50-400 мм орчим бөгөөд үүнээс 85% нь дулааны улиралд унадаг.
6. Монгол улсад удаан хугацаанд үргэлжилдэг цаг агаар/уур амьсгалын томоохон эрс тэс үзэгдэл бол хавар-зуны цагт ган болон өвөл-хаврын улиралд зуд (цаг агаарын маш хүнд нөхцөл) байдаг. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн үнэлгээнээс үзвэл, тус улсын дундаж хур тунадас бага зэрэг нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд ирээдүйд ууршилт эрс нэмэгдэх хандлагатай байна. Энэ нь аль хэдийнээ эрс тэс болоод байгаа цаг агаарын хувьсах чанар, байгалийн нөөц баялгаас ихээхэн хамааралтай амьдардаг ард иргэдийг заналхийлэх болсон ган, зуд, газрын доройтол, цөлжилт, усны хомсдол, үерийн нөлөөллийг улам бүр нэмэгдүүлэх болно.
7. Монголын малчид бол нүүдэлчид байдаг. Өвөлжөө болон хаваржааг нөмөр газарт, өвс тэжээл, усны нөөцийн хүртээмжийг харж байж сонгодог. Зун болон намрын бэлчээрийн хувьд өвөлжөөг бодвол өрсөлдөөн үүсээд байх нь бага байдаг ба уламжлалт заншлын дагуу гол төлөв айл саахалтаараа, сум ба багийн хил хязгаарын хүрээнд ашиглаж байдаг. Шилжиж нүүдэллэх цар хүрээ нь усны нөөц болон хангалттай хэмжээний бэлчээрлэх талбайгаас хамаардаг. Өнгөрсөн хугацаанд усны нөөцийн хүртээмж боломжийн, малын тоо толгой цөөн байсан гэдэг нь бэлчээрийг сэлгэн нүүдэллэдэг байсан тул бэлчээр нь нөхөн сэргээхэд хангалттай цаг хугацаа байсантай холбоотой гэсэн үг юм. Гэхдээ одоо усны эх үүсвэр хязгаарлагдмал байгаа тул малчдын нүүдэл усны эх үүсвэртэй газар нутгаар л хязгаарлагдаж байна.
8. Монгол мал жилийн тэжээлийнхээ 90% гаруй хувийг байгалийн бэлчээрээс авдаг. Бэлчээрийн гарц нь ургац уур амьсгал болон цаг агаарын нөхцөл байдлын хүчтэй нөлөөнд байдаг. Бэлчээрийн биомассын оргил цэг нь өнгөрсөн 40 жилийн хугацаанд 20%-30%-иар буурсан байгаа




ба энэ нь уур амьсгалын нөхцөл байдал өөрчлөгдөхийн хэрээр цаашид үргэлжлүүлэн буурахаар төлөвтэй байна.

- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл нь Монгол улсын мал аж ахуйн салбарын одоо байгаа эмзэг байдлыг улам нэмэгдүүлж, мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтолцоонд нөлөөлж буй одоо байгаа хүчин зүйлсийг улам бэхжүүлэх шинжтэй байна. Хөдөө орон нутгийн ард иргэдийн хувьд мал хөрөнгөө алдах нь угжирсан ядуурал руу түлхэгдэж, энэ нь амьжиргаанд урт хугацаанд нөлөөлж, нийгмийн хөгжилд нөлөө үзүүлж, хотын шилжилт хөдөлгөөнийг дэмжих болно.

1.2 Төслийн тойм

- Төсөл нь дөрвөн аймгийг хамарна: Завхан, Ховд, Дорнод, Сүхбаатар аймаг (Зураг 1). Эдгээр аймгийн газар нутаг нь өвст тал хээр, цөлөрхөг өвст тал хээр, уулархаг, уулархаг өвст тал хээр, ойт тал хээр гэсэн бүсүүдийг хамарч байдаг.



Зураг 1 Төслийн хүрээнд хамруулах газар нутгийн уг газрын зурагт харуулсан байна.

- Эдгээр дөрвөн аймгийг дараах шалтгааны улмаас сонгосон:
 - Уур амьсгалын өөрчлөлт болон удаашралтай үргэлжилж буй гамшигт туйлын эмзэг
 - Ус хурах сав газрууд нь эмзэг тул хамгаалалтанд авч/нөхөн сэргээх шаардлагатай
 - Экологийн олон янзын бүс нутгуудын төлөөлөл байдаг учраас, төслийн зүгээс хэрэгжүүлэх хөндлөнгийн оролцооны үр дүнг илүү өргөн хүрээтэй болгоно
 - Экологийн хувьд ижил төстэй бүс нутгуудад өмнө нь дасан зохицох шилдэг арга туршлагыг хэрэгжүүлсэн нь бэлэн байдаг
 - Төвлөрсөн бүс нутаг болон дэмжлэг тусалцаанаас тусгаарлагдсан эсвэл алслагдсан байршилтай

1.2.1 Үйл ажиллагааны товч хураангуй

- Санал болгож буй төсөл нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:
- Гарц бүтээгдэхүүн 1: Уур амьсгалын талаарх мэдээллийг газар болон усны нөөц ашиглалтын төлөвлөлттэй хамт үндэсний болон аймаг, орон нутгийн түвшинд уялдуулан нэгтгэнэ.
- Гарц бүтээгдэхүүн 1 нь Монгол улсын Засгийн газрыг онцгой байдлын бэлэн байдал болон хохирлыг арилгах хариу арга хэмжээнээс цаашид хөгжүүлэн, уур амьсгалын талаарх мэдээлэлд

тулгуурласан төлөвлөлт рүү чиглүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхэд төвлөрч ажиллах болно. Үүнд дунд хугацааны болон урт хугацааны уур амьсгалын өөрчлөлтийг урьдчилан таамаглах техникийн ур чадварыг хөгжүүлэх ажил багтана, дараа нь уг мэдээллээ ашиглан усны нөөц болон газрын нөөц баялагт үзүүлж болох холбогдох өөрчлөлтүүдийг урьдчилан таамаглахад ашиглах болно. Энэхүү уур амьсгалын өөрчлөлт болон холбогдох нөлөөллийн мэдээллийг уур амьсгалд тэсвэртэй уян хатан чадвартай төлөвлөлтөнд үр дүнтэйгээр нэгтгэн уялдуулахдаа, үндэсний болон аймаг, орон нутгийн түвшинд дэмжлэг үзүүлж ажиллах болно.

15. Үйл ажиллагаа 1.1. Уур амьсгалын өөрчлөлтөнд урт хугацаанд тэсвэртэй уян хатан хөгжлийн төлөвлөлтөнд зориулж, мөн дунд хугацаанд хохирлыг бууруулах хариу арга хэмжээ авах төлөвлөлтийн техникийн ур чадварыг сайжруулна.
16. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд, GCF-ийн төсөл нь Ус цаг уур, орчны шинжилгээний газрыг (УЦУОШГ-NAMEM) дунд болон урт хугацаанд цаг агаарын болон урт хугацаанд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг нарийвчлалтайгаар урьдчилан таамаглах чиглэлээр, тооцооллын техник болон хүний нөөцийн ур чадварыг хөгжүүлэхэд хөрөнгө оруулах болно. Дараа нь уг төсөл нь төв болон аймаг орон нутгийн түвшинд энэхүү мэдээллийг ашиглан гамшгийн хор уршгийг арилгах зохион байгуулалтын арга хэмжээ болон урт хугацааны төлөвлөлтөнд ашиглаж, бие бүрэлдэхүүнийг сургах болно.
 - 1.1.1. УЦУОШГ -ын техникийн хүчин чадал, тооцоолох төхөөрөмжийн техникийн үзүүлэлтүүдийг баталгаажуулах
 - 1.1.2. Улирлын болон урт хугацааны уур амьсгалын загварчлал боловсруулан гаргах УЦУОШГ -ын техникийн болон хүний нөөцийн чадавхийг бэхжүүлнэ
 - 1.1.3. Уур амьсгалын эрсдлийн талаар мэдээлэлд тулгуурласан газар, усны нөөц, мал аж ахуйн салбарыг төлөвлөх удирдамж боловсруулахад дэмжлэг үзүүлэх
 - 1.1.4. ХХААХҮЯ-нд (MoFALI) уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, уян хатан урт хугацааны хөгжлийн төлөвлөлтийг нэгтгэн боловсруулахад нь дэмжлэг үзүүлж ажиллана (Хөгжлийн төлөвлөлтийн хуулийн дагуу түгээж, хэрэгжүүлэх).
 - 1.1.5. УЦУОШГ-ын төлөвлөлтийн үйл ажиллагааг дэмжиж, урьдчилан таамагласан улирлал тутмын цаг агаарын ноцтой үйл явдлын мэдээллийг ашиглах
 - 1.1.6. Улирал тутмын цаг агаарын урьдчилсан мэдээллийг аймаг орон нутгийн системүүд болон онцгой байдлын хор уршгийг арилгах хариу арга хэмжээнд зориулан төлөвлөлт хийхэд уялдуулан нэгтгэнэ.
17. Үйл ажиллагаа 1.2. Уур амьсгалын өөрчлөлт болон уур амьсгалын талаарх мэдээлэлд тулгуурласан [бэлчээрийн даацын] талаарх мэдээллийг, аймаг, сум орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд уялдуулан нэгтгэнэ. (үүнд Голын сав газруудын нэгдсэн удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөнүүд (IRBMPs- ГСГНУЗБТ-үүд)
18. Энэхүү төсөлд хамрагдах болж буй 12 гол/нуурын сав газруудад зориулсан Голын сав газруудын нэгдсэн удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөнүүдийг боловсруулж дууссан буюу боловсруулж байгаа болно. Төлөвлөлтийн үйл явц нь эдгээр ГСГНУЗБТ-үүдээс эхлэх ба, Голын сав газруудад үзүүлэх уур амьсгалын нөлөөллийн эрсдэл, дасан зохицох төлөв байдал, бусад сонголтуудыг боловсруулж, дараа нь үүнийгээ Сумын түвшний хөгжлийн төлөвлөгөө болон малчдын түвшинд бол Байгалийн нөөц ашиглалтын гэрээнүүдтэй багасгасан хэлбэрээр уялдуулна.
19. Энэхүү үйл ажиллагааны дагуу дараах орц ажлуудыг хийнэ:
 - 1.2.1. Голын сав газарт нөлөөлөх уур амьсгалын нөлөөллийн эрсдэл болон дасан зохицох төлөв байдал мөн бусад сонголтын хувилбаруудыг боловсруулна
 - 1.2.2. Сумын түвшинд тэсвэртэй уян хатан чанар бүхий, газар болон усны нөөц ашиглалт, удирдан зохион байгуулалтын төлөвлөгөөнүүдийг боловсруулна
20. Үйл ажиллагаа 1.3. Бодлогын болон эрх зүйн шинэчлэлийг хөхиүлэн дэмжсэн, газар болон усны нөөцийн тогтвортой удирдлага, зохион байгуулалт болон даван туулан уян хатан малчдын амьжиргаа байна.

21. Энэхүү үйл ажиллагаанд Уур амьсгалын ногоон санг (УАНС-GCF), уур амьсгалын өөрчлөлтөд зохистой түвшинд дасан зохицож чадахгүй байгаа мал аж ахуйн салбарын бодлогыг өөрчлөн шинэчлэхэд нь бодлого боловсруулагч нарыг мэдээллээр хангаж, нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэхэд ашиглах болно. Энэхүү төсөл нь УИХ-ын шинэ гишүүн, яамны гол ажилтнуудад зориулан, уур амьсгалын өөрчлөлтийн хөдөө аж ахуйд үзүүлж буй нөлөөллийн талаархи мэдлэгийг дээшлүүлэх, шинэ бодлого, журам боловсруулахад шаардлагатай тохиолдолд техникийн дэмжлэг үзүүлэх зорилгоор арга хэмжээнүүдийг ивээн тэтгэж, бодлогын товч танилцуулгыг гаргана.
22. Үйл ажиллагаа 1.3-ийн дагуу дөрвөн орц арга хэмжээг хэрэгжүүлэх болно:
 - 1.3.1. Их хэмжээний мал сүргийг өсгөж үржүүлэхийг урамшуулах замаар газрын доройтолд сөргөөр нөлөөлж байж болзошгүй өнөөгийн мал аж ахуйн бодлого, хөрөнгө оруулалт, холбогдох төр/хувийн хэвшлийн хөтөлбөрүүдийг нягтлан авч үзнэ (ж нь, зудын тусламжийн хөтөлбөр, даатгалын схем гэх мэт).
 - 1.3.2. Үйл ажиллагаа 1.1-ийн үр дүнд түшиглэн цагийн байдлын дүн шинжилгээ хийх
 - 1.3.3. Байгалийн нөөцийн тогтвортой ашиглалт болон мал аж ахуйн салбарын хувьд уур амьсгалд тэсвэртэй уян хатан чанарыг дэмжихийн тулд бодлогын баримт бичгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл боловсруулж, зохих Сайд нарын түвшинд батлуулахаар өргөн барих болно.
 - 1.3.4. Шийдвэр гаргагч нар шаардлагатай шинэчлэл хийх боломжийг бий болгохын тулд, уур амьсгалын өөрчлөлтийн зүгээс байгалийн нөөц болон мал аж ахуйн салбарт үзүүлэх нөлөөллийн талаар мэдрэмжтэй болгох.
23. Гарц бүтээгдэхүүн 2: Уур амьсгалд тэсвэртэй уян хатан, ус ба хөрсний зохицуулалтын арга туршлагыг малчдын түвшинд байгалийн нөөцийг удирдан, зохицуулах бага оврын бүтэц, тогтолцоог бий болгоход зориулан өргөжүүлэх
24. Нутгийн ард иргэдэд түшиглэсэн Байгалийн нөөц ашиглагчдын бүлгүүд (БНАБ-RUGs) энэхүү гарц бүтээгдэхүүний хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны гол анхаарлын цэг байх болно. Ногоон Алт төсөл нь Ховд, Завхан аймгуудад Бэлчээр ашиглагчдын бүлгийг (БАХ) байгуулж, чадавхижуулж, 2016 онд Дорнод аймагт мөн хэрэгжүүлэх санаачлагыг эхлүүлсэн бөгөөд эдгээр нь энэ төслийн зорилтот дөрвөн аймгийн гурав нь юм. Энэхүү санал болгож буй УАНС-гийн төсөл нь хамрах хүрээг өргөжүүлж, нөлөөллийг гүнзгийрүүлэх зорилгоор энэ төслийн шилдэг аргачлал болон арга туршлагыг стратегийн хүрээнд өргөжүүлэх болно.
25. Газар дээр нь хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд нь Байгалийн нөөц ашиглалтын гэрээнд тулгуурлан төлөвлөж, хэрэгжүүлэх болно. Ногоон Алт төсөл нь улирлын дагуу сэлгэн бэлчээрлүүлж, өнжөөж амрах хуваарийг баримтлуулах замаар бэлчээрийн тогтвортой менежментэд зориулсан Бэлчээр ашиглалтын гэрээ, мөн бэлчээрийн эрүүл төлөв байдлыг хэвийн түвшинд хангаж ажиллахад зориулсан урт хугацааны гэрээ, мөн БАХ-ууд болон сумын засаг захиргаа хоёрын хооронд байгуулсан бэлчээрийн даацад тохируулан малын тоо толгойг бууруулах төлөвлөгөө зэргийг дэмжиж ажилласан болно. Энэхүү санал болгож буй УАНС-ийн төсөл нь дараах зүйлсийг эдгээр гэрээнүүдэд тулгуурлан хөгжүүлж болно:
 - Ган, зуд гэх мэт улирлын онц байдлын үеэр малын хорогдлыг бууруулахад хөрөнгө оруулалт шаардлагатай болно. Үүнд тэжээл тариалах төсөл, тэжээл хадгалах агуулах байгууламж орно.
 - Малын тууврын зам болон хашаа хороо зэргийг хамруулсан бэлчээрийн тогтвортой ашиглалтыг хөхиүлэн дэмжихэд хөрөнгө оруулалт шаардалагтай,
 - Нэн чухал ус цуглуулах газрыг зориуд байгуулж, хамгаалах, ус ялгах цэгүүдийг байгуулж, хамгаалж, Байгалийн нөөц ашиглагч нарын (БНА) дунд одоогоор байгаа уст цэгүүдийг хуваарилан олгох зэрэг үйл ажиллагааг хамруулсан усны сав газрын тогтвортой менежментийг хэрэгжүүлэх
 - Усны шинэ дэд бүтэц (ж нь, малын худаг, гар худаг)
26. Тийм учраас дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг иж бүрэн Байгалийн нөөц ашиглалтын гэрээнд хамруулах болно;
 - Бэлчээр ашиглалтын гэрээ,
 - Усны сав газрын ашиглалт ба менежментийн гэрээ, мөн



- Нутгийн ард иргэдийн дэд бүтцийг хөгжүүлж, ашиглалтын үйл ажиллагаа ба засвар үйлчилгээний гэрээ
27. Ногоон алт төслийн зүгээс бүх сумдуудад нь Бэлчээр ашиглалтын гэрээг байгуулах замаар аль хэдийнээ дэмжиж ажилласан Завхан болон Ховд аймгуудад, санал болгож буй УАНС-гийн төсөл нь усны нөөц болон дэд бүтцийн гэрээг хамруулан уг Гэрээнд нэмэлт оруулан өөрчлөх болно. Ногоон алт төслийн дараагийн үе шатанд Бэлчээр ашиглалтын гэрээг Дорнод аймгийн дөрвөн сумдуудад дэмжиж ажиллах бөгөөд санал болгож буй УАНС-ийн төсөл нь дахин хэлэхэд усны нөөц болон дэд бүтцийн гэрээг хамруулан, уялдуулах замаар Бэлчээр ашиглалтын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж өөрчлөхөд нь техник туслалцаа үзүүлж ажиллах болно. Дорнод аймаг болон Сүхбаатар аймгийн үлдсэн хэсэгт нь санал болгож буй УАНС-ийн төсөл нь Байгалийн нөөц ашиглалтын иж бүрэн гэрээг дэмжиж ажиллах болно.
 28. Байгалийн нөөц ашиглалтын гэрээнд мөн Ашиглалтын үйл ажиллагаа ба засвар үйлчилгээний гэрээг хамруулах болно. Үүнд уг дэд бүтцийн засвар үйлчилгээг хэвийн авч явахад зориулан малчдын бүлэг болон сумын засаг захиргаа хоёрын зүгээс Чанарын менежментийн хүрээнд үүрэг амлалт авахуулах асуудлыг хамрах болно.
 29. Үйл ажиллагаа 2.1. Байгалийн нөөц ашиглалтын гэрээгээр албажуулах замаар, нийтийн эзэмшлийн газар болон усны нөөцийн тогтвортой хэрэглээ болон хяналт, хамгааллын чиглэлээр малчдын дунд хамтын ажиллагааг сайжруулах
 30. Нутгийн ард иргэдэд түшиглэсэн Байгалийн нөөц ашиглагчдын бүлгүүд (БНАБ) нь энэхүү Гарц бүтээгдэхүүний хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд анхаарал хандуулах гол цэг нь байх болно. Газар дээр нь хэрэгжүүлэх төслийн үйл ажиллагааг БНАБ-үүдийн боловсруулсан Байгалийн нөөц ашиглалтын гэрээнд тулгуурлан төлөвлөж, хэрэгжүүлэх бөгөөд энэ нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдтэй Дэд бүтцийг хөгжүүлэх ба чанарын менежментийн гэрээ зэрэг байх болно.
 31. Төсөл нь орон нутгийн захиргааны эрх бүхий байгууллагуудад БНАБ-үүдийг бүртгүүлж, тэдний үйл ажиллагааны журмыг тодорхойлж, тэдний зүгээс шаардагдах ашиглалтынх нь эрх үүргийг хууль ёсны болгох тал дээр нь тусалж, дэмжиж ажиллах болно. БНАБ-үүд нь Байгалийн нөөц ашиглалтын гэрээнд заасны дагуу, газар болон усны нөөцийг хөгжүүлж, удирдан зохион байгуулах ажлыг манлайлах болно.
 32. Орц бүтээгдэхүүн:
 - Орц бүтээгдэхүүн 2.1.1: Байгалийн нөөц ашиглагч бүлгүүдийг албан ёсны болгож/эсвэл бэхжүүлэх
 - Орц бүтээгдэхүүн 2.1.2: БНАБ-үүдийн тэсвэртэй, уян хатан чанарт тулгуурласан Байгалийн нөөц ашиглалтын гэрээнүүдийг боловсруулж, нэгтгэж, бүртгүүлэх
 33. Үйл ажиллагаа 2.2: Усны нөөц эх үүсвэрүүд болон экосистемийн үйлчилгээг хамгаалахын тулд онцгой ач холбогдолтой ус хурах сав газрыг дахин ойжуулах
 34. Уур амьсгалын талаарх мэлээллээр хангагдсан, газар болон усны нөөц ашиглалт ба менежментийг хөхиүлэн дэмжихийн тулд уг төсөл нь экосистемд тулгуурласан арга хэмжээг дэмжиж ажиллах болно. Төсөл нь ус хурах сав газрыг дахин ойжуулж, газрын доройтлыг бууруулж, хөрсний ус чийг барьж агуулах чадамж болон бэлчээрийн гарцыг нэмэгдүүлэхийн тулд, голын эрэг дагуу болон доройтсон газар нутгийн дагуу нутгийн уугуул өвс ургамлыг дахин тариалахад хөрөнгө оруулах болно. Шаардлагатай тохиолдолд усны сав газрын эрүүл төлөв байдлыг сайжруулж, сэргээн тогтоохын тулд голын эрэг хавийн дагуу хашлага барих болно. Хашилтуудыг зориуд чийглэг, намгархаг газруудыг хамруулсан биологийн өндөр үнэ цэнэтэй бүсийн голын эрэг хавийн ноцтой доройтсон газруудын үйл ажиллагааг нөхөн сэргээх зорилгоор бодлоготойгоор байршуулах болно.
 35. Үйл ажиллагаа 2.2-ын дагуух орц үйл ажиллагаанууд:
 - Орц 2.2.1. БНАБ-үүдээр дамжуулан тогтоосон хөрөнгө оруулалтуудыг баталгаажуулна
 - Орц 2.2.2. Бэлчээр ашиглалтын гэрээнүүдийг хэрэгжүүлнэ
 - 1,598 га ус хураах сав газрыг дахин ойжуулна
 - Зааварчилгаа бүхий материалуудыг боловсруулж, ус хурах сав газруудад үр дүнтэйгээр, дээд зэргийн менежмент хийх талаар малчдад сургалт явуулна

36. Орц 2.2.3. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй ноцтой тохиолдлуудтай холбоотой амьдрах орчны тогтворгүй байдлыг бууруулахын тулд хадлан болон бэлчээрийн нөөц газруудыг тогтоож, онцгой үед туслах хадлан тэжээл агуулах байгууламжийг байгуулна.
37. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн даван туулж, бэлчээрийн эрсдлийг зохицуулах малчдын чадавхи, тэсвэртэй уян хатан байдлыг нэмэгдүүлэхийн тулд, ашиглалт болон эс хамаарах зүйлсийг агуулсан гэрээнүүдийг хамруулаад, хадлан авах болон бэлчээрийн нөөцтэй холбоотой БНАБ-үүдийн бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэхэд нь төслийн зүгээс дэмжлэг үзүүлж ажиллана. Дэд бүтцийн хөрөнгө оруулалтын хувьд, өвөлжөөний бэлчээрийг хадгалан хамгаалах болон малын тэжээл бэлтгэхэд зориулан хадлангийн талбайг хаших, мал сүрэгт зориулсан өвөлжөөний хашаа, саравч барих, хадлан тэжээл агуулах байгууламж зэргийг хамруулсан хамтын үйл ажиллагааг хамруулах болно.
38. Хадлан авах, бэлчээрийг хадгалан нөөцлөх зэрэг үйл ажиллагаа нь Бэлчээр ашиглалтын гэрээнд (БАГ) багтсан байдаг бөгөөд дэд үйл ажиллагаанууд нь төстэй бөгөөд дээрх Үйл ажиллагаатай холбогдсон байгаа.
39. Үйл ажиллагаа 2.3-ын дагуу орц үйл ажиллагаа:
- Орц 2.3.1. БАГ-ээр дамжуулан тогтоосон хөрөнгө оруулалтуудыг баталгаажуулах
 - Орц 2.3.2. Бэлчээр ашиглалтын гэрээг хэрэгжүүлэх
 - 3,720 га хадлангийн эсвэл бэлчээрийн нөөц талбай
 - 48 ширхэг онцгой байдалд зориулсан өвс хадлан агуулах байгууламжууд
 - Бэлчээрийн нөөцийг үр дүнтэй, оновчтой зохион байгуулах талаар удирдамжийн материал боловсруулж, малчдад сургалт явуулах
40. Үйл ажиллагаа 2.4. Байгалийн булаг шандыг хамгаалах, шинэ худаг барих, одоо байгаа худгийг сэргээн засварлах, ус хураах арга замаар усны хүртээмжийг сайжруулах
41. Үйл ажиллагаа 2.3-ийн дагуу орц:
- Орц 2.3.1. Гарц 1-д үндэслэн, хөрөнгө оруулалт хийхэд тохиромжтой, уур амьсгалын мэдээллээр хангагдсан газрыг сонгох нөхцлийг бүрдүүлэх
 - Орц 2.3.2. Төр, хувийн хэвшил, нутгийн ард иргэдийн түншлэлийн замаар, тэсвэр, уян хатан чанартай Усны сав газрын гэрээнүүдийг хэрэгжүүлэх
 - 88 ширхэг байгалийн булаг шандыг хамгаалах
 - 290 худгийг нөхөн сэргээж эсвэл барьж байгуулах
 - 18 ус цуглуулах бүтэц байгууламж барих
42. Гарц бүтээгдэхүүн 3. Тогтвортой зарчмаар ханган нийлүүлсэн, уур амьсгалд тэсвэртэй уян хатан мал аж ахуйн бүтээгдэхүүнд чиглэсэн зах зээлд нэвтрэх малчдын чадавхийг бий болгох
43. Үйл ажиллагаа 3.1: Тогтвортой зарчмын дагуу ханган нийлүүлсэн, уур амьсгалд тэсвэртэй, уян хатан мал аж ахуйн бүтээгдэхүүнд чиглэсэн төр-хувийн хэвшил-нутгийн ард иргэдийн түншлэлийн хэлбэрийг олж тодорхойлох
44. Энэхүү үйл ажиллагаагаар дамжуулан, хувийн хэвшлийн салбарын тоглогчид болон [МАА-н бүтээгдэхүүн] үйлдвэрлэгч малчдын бүлэг болон малчдын нэгдсэн бүлгүүдийн хамтын ажиллагааны хүрээнд мал аж ахуйн салбарт томоохон хэмжээнд уялдуулж нэгтгэсэн байдлаар, уур амьсгалын нөлөөллийг ухаалаг хэлбэрээр даван туулахад чиглэсэн төслүүдийг дэмжиж мөн гол сонгосон нэмүү өртгийн сүлжээний хүрээнд сүлжээний эцсийн үе шатнаас эргээд эхний үе шат руугаа илүү сайн уялдуулах зорилгыг хөхиүлэн дэмжих үүднээс, УАНС-гийн санхүүжилтийг хувийн хэвшлийн салбарын хөрөнгө оруулалтад шаардагдах хэмжээг багасгахын тулд хөшүүрэгдэн (leverage) ашиглах болно. УАНС-гийн нөөц эх үүсвэрийг малчдын бүлгүүдийг хувийн хэвшлийн салбарын гол тоглогч нартай хамтран тогтвортой, эрх тэгш түншлэл байгуулан ажиллах чадавхиа бэхжүүлэхэд нь зориулж техникийн туслалцаа үзүүлэхэд ашиглах болно. Төсөл нь хувийн хэвшлийн салбарынхныг малчдын бүлгүүдтэй холбох үйл хэргийг дэмжих үүднээс арбитрын үүрэг гүйцэтгэх бөгөөд техникийн болон эдийн засгийн хувьд хэрэгжих боломжтой ба эрх тэгш хүртээмжтэй, төр-хувийн хэвшил-нутгийн иргэдийн түншлэл (PPCP) – (Уур амьсгалд тэсвэртэй хөдөө аж ахуйн хөгжил - Climate Resilient Agricultural Development CRADs)-ийг дэмжиж ажиллах юм.
45. Дараах орцуудыг Үйл ажиллагаа 3.1-д багтаасан болно:



- 3.1.1. Цаашид уур амьсгалд тэсвэртэй мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлд оролцож, хөрөнгө оруулахад шаардлагатай мэдээллийн төрөл болон түвшинг үнэлж дүгнэхийн тулд хувийн хэвшлийн салбарынхантай зөвлөлдөх
 - 3.1.2. Төр, хувийн хэвшил, нутгийн ард иргэдийн түншлэлийн (ТХХНАИТ) нөөц боломжийг тогтоох зорилгоор мал аж ахуйн хөрөнгө оруулалтын үзэсгэлэн худалдааг дэмжиж, зохион байгуулах
 - 3.1.3. Олж тодорхойлсон боломжид тулгуурлан ТХХНАИТ-ийн гэрээг дэмжиж, эцэслэн боловсруулна.
46. Үйл ажиллагаа 3.2: Малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэгч малчдын байгууллагуудыг байгуулж, тэднийг сургах:
47. Дээр тохиролцсон ТХХНАИТ-ийн гэрээ байгуулах эрэлт хэрэгцээнд тулгуурлан төслийн зүгээс Малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэгч малчдын байгууллагуудыг (ҮМБ-НРОs) дэмжиж, тэднийг байгуулна. Энэхүү дэмжлэгт борлуулалт маркетинг, түүхий эд хураасны дараах боловсруулалт, нэмүү өртөг шингээх, мөн түүхий эдийн нэмүү өртөг шингээхэд зориулсан тухайн газрынх нь агуулах байгууламж зэрэгт чиглэсэн үйлдвэрлэл явуулах ерөнхий болон бизнесийн тодорхой сургалтуудыг хамруулах болно.
48. Энэхүү Үйл ажиллагааны орцын хувьд:
- Орц 3.2.1. ҮБА-уудад оролцох нутгийн ард иргэдийн бүх сонирхсон гишүүдийг шударга, эрх тэгш хамруулах урьдчилсан нөхцөл болгож, одоо байгаа шийдвэр гаргах үйл явц болон нутгийн ард иргэдийн засаглалын механизмыг шалгах үүднээс бэлэн байдлын үнэлгээ явуулна.
 - Орц 3.2.2. Үйлдвэрлэл, түүхий эд хурааж авсны дараах боловсруулалт, нэмүү өртөг шингээлт, тухайн газар дээр нь агуулах байгууламжид чиглэсэн борлуулалтын тодорхой сургалтууд
 - Орц 3.2.3. Бизнесийн эрэлт хэрэгцээг дэмжих, жижиг хэмжээний хөрөнгө оруулалт (ж нь, ноос, ноолуурын микроныг хэмжих тохон төхөөрөмж)
 - Орц 3.2.4. Малчин өрх бүлд төслийн зүгээс хөндлөнгөөс оролцсон нөлөөллийг үнэлэх
49. Үйл ажиллагаа 3.3. Тогтвортой зарчмын дагуу ханган нийлүүлсэн, уур амьсгалд тэсвэртэй малын гаралтай бүтээгдэхүүнд зориулсан мөшгих тогтолцоог сайжруулах
50. Мөшгих тогтолцоог сайжруулахад чиглэсэн орц үйл ажиллагаа:
- 3.3.1. Тогтвортой зарчмын дагуу ханган нийлүүлсэн, уур амьсгалд тэсвэртэй малын гаралтай бүтээгдэхүүний мөшгих тогтолцоонд судалгаа, дүн шинжилгээ хийх
 - Орц 3.3.2. Уур амьсгалт тэсвэртэй бүтээгдэхүүнүүдийг баталгаажуулах үйл явцад зориулсан стандарт хэм хэмжээг боловсруулж, хянан нягтлах
 - Орц бүтээгдэхүүн 3.3.3. Мөшгих боломжтой бүтээгдэхүүнийг боловсруулахыг дэмжсэн ТХХНАИТ-ийн гэрээний төслийг боловсруулах (Үйл ажиллагаа 3.1.3-тай холбогдсон)
 - Орц
 - Орц 3.3.4. Мөшгих боломжтой малын гаралтай загвар бүтээгдэхүүнийг хөгжүүлэх (3.3.1-д энэ талаар мэдээлсэн)
 - Орц 3.3.5. Мөшгих тогтолцооны үр дүнд дүнд шинжилгээ хийж, баримтжуулан, мэдлэгээ хуваалцах үүднээс түгээн тараах
51. Үйл ажиллагаа 3.4: Монгол улсад хувийн хэвшлийн орлцоог дэмжиж, уур амьсгалд тэсвэртэй, тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд малчдын [иргэний болон улстөрийн] эрхийг олгохыг дэмжих үүднээс мэдлэгийн бүтээгдэхүүнийг бүтээж, түгээн тараах
52. Төсөл нь мэдлэг, мэдээллийг цаашид өргөжүүлэн түгээж, хуулбарлах мөн түүнчлэн санхүүгийн зах зээлээс нөлөөлөл үзүүлэхүйц санхүүжилт болон арилжааны санхүүжилтийг хурдавчилан шинэчлэх үүднээс, уур амьсгалд дасан зохицоход чиглэсэн зах зээлийн чиг баримжаатай бүтээлч санхүүгийн механизмуудыг дэмжиж ажиллах болно.
53. Үйл ажиллагаа 3.4-ийн дагуу хэрэгжүүлэх орц:
- Орц 3.4.1. Бүтээлч санхүүжилтийн механизмд чиглэсэн (ж нь, тогтвортойгоор ханган нийлүүлэх платформ, нөлөөлөл үзүүлэхүйц хөрөнгө оруулалтын сан) хамгийн шилдэг туршлага бүхий мэдлэгийн бүтээгдэхүүнүүдийг бий болгоно



GREEN
CLIMATE
FUND

Хавсралт 6 – Байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохион байгуулах бүтэц, хамрах хүрээ

УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖҮҮЛЭЛТИЙН САНАЛ

- Орц 3.4.2. Тогтвортой арга туршлагын эрэлт хэрэгцээний талаарх хувийн хэвшлийн салбар ба/эсвэл байж болох хөрөнгө оруулагчид мөн хэрэглэгчид/олон нийтийн ойлголтыг дээшлүүлэхэд чиглэсэн төслийн амжилттай үйл ажиллагааг дэмжих болно.

1.3 БАЙГАЛЬ ОРЧИН БОЛОН НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭ

54. УАНС-гийн итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн хувьд үүрэг гүйцэтгэж байгаа НҮБХХ-ийн зүгээс энэхүү төслийн дэмжиж байгаа тул, энэ төслийг НҮБХХ-ийн Нийгэм ба байгаль орчны тогтсон стандарт хэм хэмжээний дагуу хурдавчилсан байдлаар дүн шинжилгээ хийж үзсэн болно. Нийгэм ба байгаль орчинд үзүүлэх нөлөөлөлд хурдавчилсан байдлаар дүн шинжилгээ хийх маягтыг бэлтгэж, төсөл нь дунд зэргийн (Ангилал Б) эрсдэлтэй төсөл байна гэж үзсэн. Нөлөөллийн үнэлгээний талаар хэлэлцэж ярилцсан зүйлсийг Нийгэм ба байгаль орчинд үзүүлэх нөлөөлөлд хурдавчилсан байдлаар дүн шинжилгээ хийх маягтан дээр тусгасан бөгөөд уг төслийг дунд зэргийн эрсдэлтэй гэж ангилсан байгаа. Энэхүү Байгаль орчин, нийгмийн хүрээний удирлага, зохион байгуулалтын (менежментийн) бүтэц, хамрах хүрээ нь (БОНМБХХ-ESMF) дараах хэлэлцүүлэгт хүргээд байна.
55. Үр нөлөөллийг үнэлж (Хүснэгт 1) мөн үр нөлөө тус бүрийн магадлалыг (Хүснэгт 2) үнэлэхийн тулд НҮБХХ-ийн Нийгэм ба байгаль орчны тогтсон стандарт хэм хэмжээний дагуу хурдавчилсан байдлаар дүн шинжилгээ хийх журмыг ашиглан нөлөөллийн эрсдлийн үнэлгээг хийсэн. Үүнээс үзэхэд ач холбогдлын утгыг НҮБХХ-ийн эрсдлийн матрицыг ашиглан (бага, дунд, өндөр) байж болохуйц нөлөөлөлд ангилан хамаатуулсан болно (Хүснэгт 3).

Хүснэгт 1 Эрсдлийн “нөлөөллийн” үнэлгээ

Оноо	Үнэлгээ	Нийгэм болон байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл
5	Маш ноцтой	Хүн амын популяци ба / эсвэл хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөө. Хэмжээ ба/эсвэл орон зайн (ж нь, томоохон газар зүйн бүс, их хэмжээний хүн ард, хил дамнасан нөлөөлөл, хуримтлагдсан нөлөөлөл), үргэлжлэх хугацааны (ж нь, урт хугацааны, байнгын ба/эсвэл залруулж болшгүй) хувьд өндөр сөрөг нөлөөлөл; нөлөөнд өртсөн бүс нутагт өндөр үнэ цэнэ бүхий эмзэг байдал хамрагдсан (ж нь, үнэ цэнэтэй экосистем, онцгой ач холбогдолтой амьдрах таатай орчин); нутгийн уугуул ард иргэдийн эрх, газар нутаг, байгалийн нөөц, хил хязгаарт үзүүлэх сөрөг нөлөөлөл; томоохон хэмжээний нүүлгэн шилжүүлэх/дахин суурьшуулах үйл ажиллагаа орсон; хүлэмжийн хийн ихээхэн хэмжээний ялгарлыг бий болгож буй; үзүүлэх нөлөөлөл нь нийгмийн ихээхэн хэмжээний зөрчилд хүргэж болзошгүй.
4	Ноцтой	Ард иргэд ба/эсвэл байгаль орчинд дунд зэргээс эхлээд томоохон цар хэмжээнд сөрөг нөлөөлөл үзүүлэх, орон зай болон үргэлжлэх хугацааны хувьд ноцтой түвшинтэй харьцуулахад илүү хязгаарлагдмал (ж нь, урьдчилан таамаглахуйц, ихэвчлэн түр зуурын, залруулах боломжтой). Төслийн зүгээс байж болзошгүй эрсдлийн үнэлгээ нь хүний эрх, газар, байгалийн нөөц, нутгийн уугуул ард иргэдийн уламжлалт амьжиргаанд нөлөөлж болзошгүй байдлыг, байж болзошгүй ноцтой хэмжээний хамгийн бага түвшинд гэж үзэх хэрэгтэй.
3	Дунд зэргийн	Хэмжээ болон үргэлжлэх хугацааны (түр зуурын) хувьд хязгаарлагдмал бага хэмжээний нөлөөллөөс (тухайн газартай хамаатай) зайлсхийж, зохицуулж мөн/эсвэл харьцангуй түвэгтэй биш, хүлээн зөвшөөрөхүйц арга хэмжээг хэрэгжүүлэх замаар бууруулах боломжтой.
2	Бага	Цар хэмжээний хувьд (ж нь, бага хэмжээнд өртсөн газар, маш бага тооны хүмүүс өртсөн) болон үргэлжлэх хугацааны (богино) хувьд маш бага нөлөөллөөс хялбархан зайлсхийж, удирдан зохицуулж, бууруулж болно.
1	Ялихгүй	Нутгийн ард иргэд, хувь хүмүүс, мөн/эсвэл байгаль орчинд ялихгүй хэмжээний эсвэл ямар ч сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.

Хүснэгт 2 Эрсдлийн “Магадлалын” үнэлгээ

Оноо	Үнэлгээ
5	Хүлээж байсан
4	Маш их магадлалтай
3	Дунд зэргийн магадлалтай



2	Тийм зүйл болохгүй байх
1	Бага зэрэг

Хүснэгт 3 Эрсдлийн матрикс

Нөлөөлөл	5	Н	Н	Н	Н	Н
	4	М	М	Н	Н	Н
	3	Л	М	М	М	М
	2	Л	Л	М	М	М
	1	Л	Л	Л	Л	Л
		1	2	3	4	5

Магадлал

56. Эрсдлийн үнэлгээ хийж байхад бүх үйл ажиллагааг үнэлж дүгнэнэ, үүнд хатуу/зөөлөн дэд бүтэц мөн амьжиргаанд үзүүлэх хөндлөнгийн арга хэмжээ (Хүснэгт 4). Тухайн асуудал бүр эсвэл ус, хөрсний элэгдэл, дуу чимээ зэрэг сэдэв тус бүрт чиглэсэн тусгайлсан арга хэмжээг энэхүү ESMF баримт бичгийн хойно нь сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний дагуу авч хэлэлцсэн байгаа (5-р хэсгийн үзнэ үү).

Хүснэгт 4 Нөлөөлөл болон нөлөөллийг бууруулах эрсдлийн үнэлгээ

Үйл ажиллагаа	Бууруулаагүй нөлөөлөл	Нөлөөлөл үзүүлж, үр дагавар үүсэх магадлалтай	Сөрөг нөлөөллөөс зайлсхийж, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг бууруулсны дараа гарах магадлалтай нөлөөлөл болон үр дагавар
---------------	-----------------------	---	---	---

Гарц бүтээгдэхүүн 1: Уур амьсгалын мэдээллийг үндэсний болон аймаг, орон нутгийн түвшинд газар болон усны нөөц ашиглалтын төлөвлөлтэй уялдуулах

Үйл ажиллагаа 1.1: Уур амьсгалд тэсвэртэй урт хугацааны хөгжлийн төлөвлөлт болон дунд хугацаанд авах хариу арга хэмжээний төлөвлөлтөнд чиглэсэн техникийн үр чадварыг сайжруулах

Орц 1.1.1: УЦУОШГ-ын техникийн хүчин чадал, тооцоолох төхөөрөмжийн техникийн үзүүлэлтүүдийн баталгаажуулалт	Уг үйл ажиллагаанд чадавхи болон эрэлт хэрэгцээг нягтлан үнэлэх арга хэмжээг багтаасан. Ямар ч сөрөг нөлөөлөл гарахааргүй байна.	Магадлал: 1 Үр дагавар: 1 Эрсдэл: Бага	Сөрөг нөлөөллийг бууруулах ямар ч арга хэмжээ авах шаардлагагүй	Магадлал: 1 Үр дагавар: 1 Эрсдэл: Бага
Орц 1.1.2: Улирлын болон урт хугацааны уур амьсгалын загварчлал боловсруулж гаргах УСУОШГ-ын техникийн болон хүний нөөцийн	Энэ үйл ажиллагаанд үндсэндээ тооцоолох тоног төхөөрөмж худалдан авах, суурилуулах, сургалт явуулах үйл ажиллагааг хамруулна. Энэхүү үйл ажиллагаа нь чадавхи бэхжүүлэх, сургалт явуулах үйл ажиллагаа. Иймээс ямар нэгэн томоохон эсвэл бүр ялимгүй нөлөөлөл үзүүлэх магадлал багатай. Байж болох эрсдлийн хувьд:	Магадлал: 2 Үр дагавар: 3 Эрсдэл: Дунд зэрэг	Супер компьютерийн техникийн үзүүлэлтүүдийн талаар сайн ойлголттой бөгөөд дэлхийн бусад оронд хэрэглэгддэгтэй төстэй юм. Компьютер байрлуулах тоног төхөөрөмж аль хэдийн бий болсон. Янз бүрийн түвшинд олон ажилчдыг сургах. Ур чадварыг бусад ажилтнуудад шилжүүлэх.	Магадлал: 1 Үр дагавар: 1 Эрсдэл: Бага



Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ

чадавхийг бэхжүүлэх

- Сургагч багш нар нь зохисгүй байх эсвэл чанар муутай сургалт явагдах
- Ажилтнуудын ирц/эргэлтийн хэмжээ нь сургалтын үр ашгийг үгүйсгэх магадлалтай

Орц 1.1.3:

Уур амьсгалын эрсдлийн талаарх мэдээллээр хангагдсан, газар, усны нөөц болон мал аж ахуйн төлөвлөлтөд зориулсан зааварчилгаа боловсруулахад нь дэмжлэг үзүүлэх

Боловсруулсан бүтээгдэхүүн нь зохисгүй байх, ж нь, өгч байгаа гол мэдээлэл нь эцсийн хэрэглэгч нарт ойлгомжгүй байх эсвэл эцсийн хэрэглэгчдэд бэлэн байдаггүй технологид найдах

Эцсийн хэрэглэгчид цаг агаарын урьдчилсан мэдээ болон Эрт сэрэмжлүүлэх систем (Early Warning System –EWS) мэдээлэлд үл итгэсэн хэвээр байх

Магадлал: 2

Үр дагавар: 3

Эрсдэл: Дунд зэрэг

Оролцооны аргаар зохион бүтээсэн бүтээгдэхүүн ба хүлээн авч буй/үр ашигтай байдлынх нь үнэлгээ дүгнэлт

Ойлголт мэдээллийг дээшлүүлж, цаг агаарын урьдчилсан мэдээллийг баталгаажуулах

Малчид, фермерүүд аль хэдийн өргөн ашигладаг гар утасны технологид суурилсан арилжааны хувьд ашигтай загвар.

Магадлал: 1

Үр дагавар: 2

Эрсдэл: Бага

Орц 1.1.4: Уур амьсгалын өөрчлөлт, эрсдлийг нэгтгэх, уур амьсгалын тэсвэртэй байдлыг урт хугацаанд хөгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ХХААХҮЯ-нд дэмжлэг үзүүлэх (Хөгжлийн төлөвлөлтийн тухай хуулийг таниулж, мөрдөн хэрэгжүүлэх)

Энэхүү үйл ажиллагаа нь засгийн газар төлөвлөгөө, хууль боловсруулахад туслах үйл ажиллагааг хамруулсан. Бодит дэд бүтцийн ажил ороогүй. Байгаль орчин, нийгэмд үзүүлэх эрсдлийг хамгийн бага гэж үзсэн. Бүх холбогдох оролцогч талуудыг оруулахгүй байх эрсдэлтэй.

Магадлал: 1

Үр дагавар: 3

Эрсдэл: Бага зэрэг

Төлөвлөлтийн үйл явц аль хэдийн бий болсон байгаа ба, энэ үйл ажиллагаа нь одоогийн үйл явцыг сайжруулна.

Төлөвлөлтийн үйл явц нь оролцоог хангаж, засгийн газар болон нутгийн ард иргэдийг зохих түвшинд хамруулж байгаа эсэхийг баталгаажуулах

Магадлал: 1

Үр дагавар: 1

Эрсдэл:Бага зэрэг



**Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ**

<p>Орц 1.1.5. Таамаглаж буй цаг агаарын эрс тэс үйл явдлыг ОБЕГ төлөвлөлдөндөө ашиглахыг нь дэмжих</p>	<p>Техникийн ур чадвар бага эсвэл зохисгүй түвшинд байх</p>	<p>Магадлал: 2 Үр дагавар: 3 Эрсдэл: Дунд зэрэг</p>	<p>Уур амьсгалын мэдээллийг уялдуулан хэрэглэх зохих түвшний техникийн ур чадварыг хангаж өгөх</p>	<p>Магадлал: 2 Үр дагавар: 2 Эрсдэл:Бага зэрэг</p>
<p>Орц 1.1.6: Улирлын чанартай урьдчилсан мэдээг аймгийн түвшний систем болон төлөвлөлтөнд нэгтгэж, онцгой байдлын үед (жишээ нь ган, зуд) хариу арга хэмжээ авахаар төлөвлөж байна</p>	<p>Энэ үйл ажиллагаа нь цаг уурын талаарх мэдээллээр хангагдсан төлөвлөлт, онцгой байдлын төлөвлөлтөд дэмжлэг үзүүлэх нөхцлүүдийг хамруулсан. Энэ нь одоо байгаа чадавхийг бий болгож, одоо байгаа үйл ажиллагаанд тулгуурлана. Энэ нь эрсдэл багатай үйл ажиллагаа юм.</p>	<p>Магадлал: 1 Үр дагавар: 3 Эрсдэл:Бага зэрэг</p>	<p>Уур амьсгалын мэдээллийг нэгтгэх, хэрэглэхэд шаардлагатай техникийн мэдлэг олгох</p>	<p>Магадлал: 1 Үр дагавар: 2 Эрсдэл:Бага зэрэг</p>

Үйл ажиллагаа 1.2: Уур амьсгалын талаарх урт хугацааны асуудлуудыг Сумын түвшний хөгжлийн төлөвлөлтөнд уялдуулан тусгана.

<p>Орц 1.2.1: Гол мөрний сав газрын цаг уурын эрсдэл, дасан зохицох төлөв байдал, хувилбаруудыг боловсруулах</p>	<p>Үндэсний болон бүс нутгийн стратеги, төлөвлөгөөнүүдийг аймаг болон сумын түвшинд багасган нэвтрүүлэх үйл ажиллагааг хамарна</p>	<p>Магадлал: 2 Үр дагавар: 3 Эрсдэл: Дунд зэрэг</p>	<p>Аймаг, сум орон нутгийн түвшинд зохих мэдээллийг хүргэж ажиллах нөхцлийг хангах Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулах үед хэрэглэгчдийг дэмжихийн тулд “хэрэглэхэд бэлэн лавлагаа”-нд тохиромжтой гарц үйл ажиллагаа байх.</p>	<p>Магадлал: 1 Үр дагавар: 2 Эрсдэл:Бага зэрэг</p>
--	--	---	--	--



GREEN
CLIMATE
FUND

Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ

<p>Орц 1.2.2: Сумын түвшний тэсвэртэй чанарт тулгуурласан газар ба усны нөөц ашиглалт болон менежментийн төлөвлөгөөг боловсруулах</p>	<p>Усны сав газрын төлөвлөгөө нь усны сав газрын гидрологийн болон газрын өмчийн ашиглалт ба менежментийн үндсэн суурийг үр дүнтэй тогтоож өгөх бөгөөд, төслийн дараагийн үйл ажиллагаа ба хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх замын зураглалын үүрэг гүйцэтгэнэ.</p> <p>Суурь мэдээлэл муутай байх эсвэл эрх мэдэлтэний ашиг сонирхлын улмаас сайн дасан зохицож чадаагүй төлөвлөгөөнд хүргэж болзошгүй.</p>	<p>Магадлал: 2 Үр дагавар: 4 Эрсдэл: Дунд зэрэг</p>	<p>Орон нутгийн агентлагуудтай нягт хамтран ажиллах, оролцооны зарчимд тулгуурлан үүнийг боловсруулах</p> <p>Хөрөнгө оруулалтыг сонгож, байршуулахад үүнийг ашиглахаас өмнө чанарыг нягт нямбай хянаж нягтлан, баталгаажуулах үйл явц байна.</p>	<p>Магадлал: 1 Үр дагавар: 3 Эрсдэл:Бага зэрэг</p>
---	--	---	--	--

Үйл ажиллагаа 1.3. Газар болон усны нөөцийн тогтвортой ашиглалтыг дэмжсэн бодлогын болон эрх зүйн зохицуулалтын шинэчлэлийг дэмжсэн дүн шинжилгээний бүтээгдэхүүнүүд

<p>Орц 1.3.1.Олон тоо толгой малтай байхыг урамшуулах замаар газрын доройтолд сөргөөр нөлөөлж байж болохуйц өнөөгийн мал аж ахуйн бодлого, хөрөнгө оруулалт, холбогдох төр/хувийн хэвшлийн хөтөлбөрүүдийг эргэж нягтлан үзэх (ж нь, зудын тусламжийн хөтөлбөр, даатгалын схем гэх мэт)</p>	<p>Энэ бол нягталж үзэх үйл явц бөгөөд үүний эрсдэл нь ихэвчлэн хянан нягтлах үйл ажиллагааны чанар болон хэр гүн гүнзгий хийгдсэн байдлыг тойрон хамаарч байдаг, ж нь хяналт шалгалтыг хангалтгүй хэмжээнд хийх эрсдэл, шинэчлэгдэх шаардлагатай бодлого ба хөтөлбөрүүд хангалтгүй байх гэх мэт.</p> <p>Бодит биет эрсдэл бага байна.</p>	<p>Магадлал: 2 Үр дагавар: 3 Эрсдэл:Бага зэрэг</p>	<p>Хянан нягтлах үйл ажиллагааг хангалттай өргөн хүрээнд хийх.</p> <p>Хянан нягталж буй хүмүүсийн хувьд олон төрлийн суурь мэдлэг/үзэл санааны өнцгөөс хандах хэрэгтэй.</p> <p>Шаардлагатай тохиолдолд техникийн тусалцаа үзүүлэх</p>	<p>Магадлал: 2 Үр дагавар: 2 Эрсдэл:Бага зэрэг</p>
--	--	--	---	--



**Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ**

<p>Орц 1.3.2. Үйл ажиллагаа 1.1-ийн үр дүнгийн мэдээлэлд үндэслэн, цагийн байдлын хувилбаруудад дүн шинжилгээ хийнэ</p>	<p>Салбар хоорондын төлөвлөлтийг дэмжих чиглэлээр оролцогч талуудыг хамруулан / семинар зохион байгуулж – үүнд зохих төлөөллүүдийг хамруулахыг шаарддаг.</p>	<p>Магадлал: 2 Үр дагавар: 2 Эрсдэл:Бага зэрэг</p>	<p>Зохион байгуулж байгаа арга хэмжээ нь өргөн хүрээг хамарсан байхаас гадна, бүх зохих бодлого боловсруулагч нар оролцож/уг асуудлын талаар мэдээлэл авах хэрэгтэй болно. Насны ангиллаар болон салбаруудаар ангилсан эрэгтэйчүүд/эмэгтэйчүүдийн өргөн хүрээний төлөөллийг хангаж ажиллах</p>	<p>Магадлал: 1 Үр дагавар: 2 Эрсдэл:Бага зэрэг</p>
<p>Орц 1.3.3. Байгалийн нөөцийн тогтвортой ашиглалт, мал аж ахуйн салбарыг уур амьсгалд тэсвэртэй болгохыг дэмжсэн бодлогын шинэчлэлт өөрчлөлтийн хувилбарыг боловсруулах, мөн үүнийг зохих сайд нарын түвшинд шийдвэрлүүлэхээр өргөн барих</p>	<p>Шинэчлэлт өөрчлөлтийг зохих хэмжээнд хийж чадахгүй байх эрсдэл Техникийн ур чадвар хангалтгүй байх эсвэл тухайн этгээдийн хувийн ашиг сонирхол нь шинэчлэлт өөрчлөлтийн ажилд өрөөсгөлөөр хандуулах магадлалтай.</p>	<p>Магадлал: 2 Үр дагавар: 3 Эрсдэл:Дунд зэрэг</p>	<p>Шинэчлэлт өөрчлөлтийн ажлыг төлөвлөж/хянан нягтлах ажилд өргөн хүрээнд бодлого боловсруулагчид/эрх зүйн зохицуулагч нарыг оролцуулах Шинэ бодлого болон эрх зүйн зохицуулалтуудыг боловсруулахын тулд шаардлагатай тохиолдолд, техникийн дэмжлэг үзүүлэх</p>	<p>Магадлал: 1 Үр дагавар: 3 Эрсдэл:Бага зэрэг</p>
<p>Орц 1.3.4. Шаардлагатай шинэчлэл өөрчлөлт хийх боломжийг олгохын тулд шийдвэр гаргагч нарт байгалийн нөөц болон мал аж ахуйн салбарт</p>	<p>Нутгийн ард иргэдийн зүгээс хангалтгүй хэмжээнд оролцох Бодлог шинэчлэгдэхгүй байх эрсдэл эсвэл тус бодлого нь уур амьсгалд зохих хэмжээнд дасан зохицож чадахгүй байгаа нөхцлийг бууруулж чадахгүй байх</p>	<p>Магадлал: 2 Үр дагавар: 3 Эрсдэл:Дунд зэрэг</p>	<p>Нутгийн ард иргэдийг оролцуулах мөн зохих урамшууллыг олж тодорхойлох Салбар хоорондын төлөвлөгөөг боловсруулах</p>	<p>Магадлал: 2 Үр дагавар: 2 Эрсдэл:Бага зэрэг</p>



GREEN
CLIMATE
FUND

үзүүлэх уур
амьсгалын
нөлөөллийн
талаарх ойлголт,
мэдрэмийг буй
болгох

**Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ**

Гарц бүтээгдэхүүн 2: Уур амьсгалд тэсвэртэй уян хатан, ус ба хөрсний зохицуулалтын арга туршлагыг малчдын түвшинд байгалийн нөөцийг удирдан, зохицуулах (менежментийн) бага оврын бүтэц, тогтолцоог бий болгоход зориулан өргөжүүлэх

Үйл ажиллагаа 2.1: Байгалийн нөөц ашиглалтын гэрээгээр албажуулах замаар, нийтийн эзэмшлийн газар болон усны нөөцийн тогтвортой хэрэглээ болон хяналт, хамгааллын чиглэлээр малчдын дунд хамтын ажиллагааг сайжруулах

<p>Орц 2.1.1: Байгалийн нөөц ашиглагчдын бүлгүүдийг албан ёсны болгож мөн/эсвэл бэхжүүлэх</p>	<p>БНАБ-үүдийг бий болгох/бэхжүүлэх үйл ажиллагааг хамруулна. Зохисгүй бүлгүүд үүсэх эсвэл нөөцийн хуваарилалтын эрсдэл</p>	<p>Магадлал: 2 Үр дагавар: 3 Эрсдэл:Дунд зэрэг</p>	<p>Одоогоор байгаа БНАБ-үүдийг бэхжүүлж эсвэл нутгийн ард иргэдтэй харилцаж, байгалийн нөөцийн логиктой ашиглалт болон нутгийн ард иргэдийн бүлэглэлүүдийг оролцооны зарчмаар олж тодорхойлсны үндсэн дээр БНАБ-үүдийг байгуулах</p> <p>Орон нутгийн захиргааны эрх бүхий байгууллагуудад БНАБ-үүдийг бүртгүүлж, тэдний үйл ажиллагааны журмыг тодорхойлж, тэдний эрх үүрэг хариуцлагыг хууль ёсны болгох</p> <p>Нутгийн ард иргэдтэй үргэлжлүүлэн харилцаж ажиллахын тулд сургагч багш нарыг сургах</p>	<p>Магадлал: 1 Үр дагавар: 3 Эрсдэл:Бага зэрэг</p>
<p>Орц 2.1.2: Тэсвэртэй, уян хатан чанарт тулгуурласан БНАБ-үүдийн [уур амьсгалд] тэсвэртэй байдалд</p>	<p>Газрыг хэрхэн, хэн ашиглахыг тодорхойлсон Бэлчээр ашиглалтын гэрээг байгуулж ажиллахад идэвхитэй оролцуулах. Ямар нэгэн биет дэд бүтцийн асуудал төсөлд үүсэхгүй бөгөөд үүсэх эрсдэл нь нийгмийн шинж чанартай боловч энэ нь уур амьсгалд зохисгүй түвшинд дасан зохицоход хүргэж</p>	<p>Магадлал: 2 Үр дагавар: 4 Эрсдэл:Дунд зэрэг</p>	<p>БНАБ-үүдтэй харилцаж, БНАБ тус бүрт зориулсан БНАГ-г боловсруулахад нь дэмжлэг үзүүлэх</p> <p>Бүх улирлын бэлчээрийг хамруулж, малчдын эрх, үүрэг хариуцлагыг маш</p>	<p>Магадлал: 2 Үр дагавар: 3 Эрсдэл:Дунд зэрэг</p>



тулгуурласан
Бэлчээр
ашиглалтын гэрээг
(БАГ) боловсруулж,
нэгтгэж, бүртгүүлэх

болох бөгөөд хэрэв зохих хэмжээнд
зохицуулж чадахгүй бол зөрчилд хүргэж
болзошгүй.

Уг үйл явц нь эрх тэгш бөгөөд нутгийн ард
иргэдийн зүгээс зөвшөөрсөн байх ёстой.

Гэрээг дагаж мөрдөхгүй байх зарим
малчдын эрсдэл байж болзошгүй бөгөөд
байгалийн нөөцийн төлөө өрсөлдөөнд
хүргэж болзошгүй.

Усны сав газрын тухай гэрээг Бэлчээр
ашиглалтын гэрээнд (БАГ) уялдуулан
оруулах үйл ажиллагааг хамруулна. Эрсдэл
нь дээрхтэй ижил.

[Өртгийн сүлжээний] эхэнд болон эцсийн
шат дамжлагад нь ажилладаг хэрэглэгчдийн
нөлөөлөлтэй холбогдсон нэмэлт эрсдлийн
түвшин.

Усны нөөц эх үүсвэрийн төлөө зөрчил үүсч
болзошгүй.

Үйл ажиллагаа болон засвар үйлчилгээний
төлөвлөгөөг батлахгүй байх эсвэл сайн
ойлголцоогүй байх асуудал.

Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ

тодорхой тусгахын тулд одоогоор байгаа
газар ашиглалтын гэрээг өргөжүүлэх

Засгийн газарт бүртгүүлэхээр төлөвлөж,
төсвийн эх үүсвэрээс санхүүжилт авахыг
хүсч буй гол хөрөнгө оруулалтыг
тодорхойлно (өөрөөр хэлбэл
урамшуулалтай болно).

Шаардлагатай тохиолдолд хил дамнасан
асуудлаар тохиролцоонд хүрэхийн тулд
олон БНАБ-үүдтэй хамтарч ажиллана.

Сонгогдож, хөрөнгө оруулалт хийгдэхээс
өмнө усны сав газрын төлөвлөгөөг чанарын
нарийн шалгалт, баталгаажуулалтын үйл
явцаар оруулна.

Дэд бүтцийн бүрэлдэхүүн хэсгийг үе шаттай
хэрэгжүүлэх замаар усны сав газрын гэрээг
баримталж ажиллахыг урамшуулна –
засгийн газар зардлыг хуваалцана. Шинэ
болон сэргээн босгосон дэд бүтцийг
ашиглах, хамгаалах, засвар үйлчилгээ хийх
үүрэг хариуцлага нь БНАБ-үүдэд байна.

Үйл ажиллагаа болон засвар үйлчилгээний
төлөвлөгөөг хэрэглэгчид ойлгосон байх
нөхцлийг хангах

Үйл ажиллагаа 2.2: Усны нөөц эх үүсвэрүүд болон экосистемийн үйлчилгээг хамгаалахын тулд онцгой ач холбогдолтой үс хурах сав газрыг дахин ойжуулах

Орц 2.2.1. Бэлчээр
ашиглалтын
гэрээгээр
дамжуулан
тодорхойлсон

Харилцан зөвшил нь муу үр дүнд хүрсэн
бол хөрөнгө оруулалт хүлээн авах
боломжгүй болоход хүргэнэ.

Магадлал: 3
Үр дагавар: 2
Эрсдэл: Дунд зэрэг

Оролцогч талуудын оролцоо

Магадлал: 1
Үр дагавар: 2
Эрсдэл: Бага
зэрэг



GREEN
CLIMATE
FUND

**Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ**

хөрөнгө оруулалтыг
баталгаажуулах

Орц 2.2.2. Бэлчээр ашиглалтын гэрээг хэрэгжүүлэх	Энэ үйл ажиллагаа нь дахин ойжуулах болон урсгал усыг хамгаалахад чиглэгдэнэ. Хашлага барихад нутгийн ард иргэд эсэргүүцэх магадлалтай. Зохисгүй төрөл зүйлийг ашиглах асуудал.	Магадлал: 2 Үр дагавар: 3 Эрсдэл:Дунд зэрэг	Төлөвлөгөөг урьд нь тохиролцсон байсан тул хашилтын байршлыг нутгийн ард иргэдийн хүрээнд шийдсэн. Хашилтууд нь түр зуурынх байх болно (доройтсон талбай нөхөн сэргэх хүртэл) Зохих төрөл зүйлийг сонгох бөгөөд нутгийн уугуул ургамлыг илүүд үзэх болно.	Магадлал: 1 Үр дагавар: 2 Эрсдэл:Бага зэрэг
Орц 2.2.3. Удирдамж материалыг боловсруулж, сургалт зохион байгуулах	Нийлүүлж буй материал болон сургалтууд нь эрэлт хэрэгцээтэй нь бүрэн нийцэхгүй байх асуудал. Материал болон сургалт хүлээн авах тал дээр тэгш бус байдал үүсэх.	Магадлал: 2 Үр дагавар: 3 Эрсдэл:Дунд зэрэг	Оролцооны аргаар тухайн бүтээгдэхүүнийг боловсруулж, хүлээн авах/үр нөлөөг нь дүгнэх Оролцогч талуудын оролцоог хангаж, суралцагчдыг эрх тэгш байдлаар сонгоно. Мэдлэгийг дамжуулж, сургалтын тогтвортой байдлыг сайжруулахын тулд сургагч багшийг сургана.	Магадлал: 1 Үр дагавар: 3 Эрсдэл:Бага зэрэг

Үйл ажиллагаа 2.3. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй ноцтой тохиолдлуудтай холбоотой амьдрах орчны тогтворгүй байдлыг бууруулахын тулд хадлан болон бэлчээрийн нөөц газруудыг тогтоож, онцгой үед туслах хадлан тэжээл агуулах байгууламжийг байгуулна.

Орц 2.3.1.БАГ-нүүдээр дамжуулан тодорхойлсон хөрөнгө оруулалтуудыг баталгаажуулах	Харилцан зөвшил нь муу үр дүнд хүрсэн бол хөрөнгө оруулалт хүлээн авах боломжгүй болоход хүргэнэ.	Магадлал: 3 Үр дагавар: 2 Эрсдэл:Дунд зэрэг	Оролцогч талуудыг оролцуулах	Магадлал: 1 Үр дагавар: 2 Эрсдэл:Бага зэрэг
Орц 2.3.2. Бэлчээр ашиглалтын гэрээг хэрэгжүүлэх	Энэхүү үйл ажиллагаа нь, өвлийн бэлчээрийг хадгалан хамгаалж, малын тэжээл бэлдэхийн тулд хадлангийн бэлчээрийг хашаалах, малд зориулж	Магадлал: 2 Үр дагавар: 3 Эрсдэл:Дунд зэрэг	Төлөвлөгөөг өмнө нь тохиролцсон байх болно.	Магадлал: 1 Үр дагавар: 2

Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ

өвлийн хашаа хороо барих, өвс хадлан агуулах байгууламж зэрэг дэд бүтцийг байгуулж, төлөвлөгөө хэрэгжүүлэхэд чиглэсэн болно.

Хэрэгжүүлэлтийн явцад ердийн барилга байгууламжийн/ эрүүл мэнд аюулгүй байдлын эрсдлүүд, мөн жишээ нь зарим газруудад газар хөндөхийг цээрлэдэг ёс зэрэг аливаа соёлын эмзэг мэдрэмтгий чанар зэргийг харгалзан авч үзэх хэрэгтэй.

Барилгын аюулгүй ажиллагааны стандарт аргыг ашиглан дэд бүтцийг зохих улиралд нь суурилуулна.

Эрсдэл:Бага зэрэг

БНАБ-үүд төлөвлөгөөг өөрийн болгон эзэмшиж, хэрэгжилтийг хянахдаа соёлын хувьд аливаа зүй зохисгүй үйлдлээс зайлсхийх ёстой.

Орц 2.3.3. Удирдамж материалыг боловсруулж, сургалт зохион байгуулах

Нийлүүлж буй материал болон сургалтууд нь эрэлт хэрэгцээнд нийцэхгүй байх
Нийлүүлж буй материал болон сургалтуудыг тэгш бус байдлаар хүргэх

Магадлал: 2
Үр дагавар: 3
Эрсдэл:Дунд зэрэг

Оролцооны зарчмаар бүтээгдэхүүнүүдийг зохион бүтээж, хүлээн авах нөхцөл/үр ашигтай байдлыг нь үнэлж дүгнэнэ
Оролцогч талуудын оролцоог хангах болон сурагчдыг эрх тэгш байдлаар сонгоно.
Мэдлэгийг шилжүүлж, сургалтын тогтвортой байдлыг сайжруулах нөхцлийг хангахын тулд сурагчдыг сургана.

Магадлал: 1
Үр дагавар: 3
Эрсдэл:Бага зэрэг

Үйл ажиллагаа 2.4. Байгалийн булаг шандыг хамгаалах, шинэ худаг барих, одоо байгаа худгийг сэргээн засварлах, ус хураах арга замаар усны хүртээмжийг сайжруулах

Орц 2.4.1. Хөрөнгө оруулалт хийхэд, тохиромжтой, уур амьсгалын талаархи мэдээллээр хангасан хуралдаан

Тухайн хуралдаан нь уур амьсгалын талаарх мэдээллээр хангагдсан байлгах тал дээр техник ур чадвар муутай байх.
Улстөрийн хөндлөнгийн оролцоо

Магадлал: 3
Үр дагавар: 3
Эрсдэл:Дунд зэрэг

Техникийн ур чадварыг олгох
БНАБ-үүдэд хөрөнгө оруулалтын чиглэлээр сургалт өгөх
Stakeholder engagement and empowerment
Оролцогч талуудыг оролцуулж, эрх мэдлийг нь бэхжүүлэх

Магадлал: 2
Үр дагавар: 2
Эрсдэл:Бага зэрэг

Орц 2.4.2. Төр, хувийн хэвшил, нутгийн ард

Уг үйл ажиллагаанд усны аюулгүй байдлыг дэмжихийн тулд бүтэц тогтолцооны болон экосистемд тулгуурласан арга хэмжээний

Магадлал: 3
Үр дагавар: 3

Төлөвлөгөөг өмнө нь тохиролцсон байх болно.

Магадлал: 2
Үр дагавар: 3



GREEN
CLIMATE
FUND

**Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ**

иргэдийн түншлэлээр дамжуулан, тэсвэртэй уян хатан чанарт тулгуурласан, Усны сав газрын гэрээг хэрэгжүүлэх	<p>аль алийг нь хамруулна: булаг шандыг хашаалах;</p> <p>Жижиг далан хашлага болон ус хураах байгууламж; салхины саадуудыг байгуулах; хөрс хамгаалал (элэгдлээс); усны нөөц эх үүсвэрийг нөхөн сэргээх; гүний худгуудыг байгуулах; гүехэн устай газруудыг байгуулах/нөхөн сэргээх</p> <p>Дээрхтэй ижил эрсдлүүд. Гүний усны чанар болон тоо хэмжээтэй холбоотой нэмэлт эрсдлүүд байсаар байгаа.</p> <p>Зарим хаалт болон хязгаарлалтуудыг зориулалтын дагуу мөрдөж ажиллахгүй байх зарим эрсдэл бий.</p>	Эрсдэл:Дунд зэрэг	Барилга угсралтын ажлыг аюулгүйгээр гүйцэтгэнэ.	Эрсдэл:Дунд зэрэг
			Ашиглалтын хувьд зохистой эсэх, нөөц хэмжээний хувьд тогтвортой эсэхийг тогтоохын тулд гүний усанд шинжилгээ хийх	
			Зарим хашилтуудын зориулалтын дагуу ашиглах журмыг баримталж, аливаа хязгаарлалтуудыг хэрэгжүүлэх тал дээр сумын зарим албан хаагчид хариуцлага хүлээж ажиллах болно.	

Гарц бүтээгдэхүүн 3. Тогтвортой зарчмаар ханган нийлүүлсэн, уур амьсгалд тэсвэртэй уян хатан мал аж ахуйн бүтээгдэхүүнд чиглэсэн зах зээлд нэвтрэх малчдын чадавхийг бий болгох

Үйл ажиллагаа 3.1: Тогтвортой зарчмын дагуу ханган нийлүүлсэн, уур амьсгалд тэсвэртэй, уян хатан мал аж ахуйн бүтээгдэхүүнд чиглэсэн төр-хувийн хэвшил-нүтгийн ард иргэдийн түншлэлийг хэлбэрийг олж тодорхойлох

Орц 3.1.1: Цаашид уур амьсгалд тэсвэртэй малын гаралтай бүтээгдэхүүнд оролцож, хөрөнгө оруулахад шаардлагатай мэдээллийн хэлбэр/түвшинг үнэлэхийн тулд	Хязгаарлагдмал хүрээний бизнес эрхлэгчидтэй зөвлөлдсөнөөр, эргэх холбоог хязгаарлана	Магадлал: 1 Үр дагавар: 2 Эрсдэл:Бага зэрэг	Хувийн хэвшлийн салбарт, үүнд салбар дамнасан бизнес эрхлэгчдийг хамруулсан өргөн хүрээний зөвлөгөөн	Магадлал: 1 Үр дагавар: 2 Эрсдэл:Бага зэрэг
--	--	---	--	---



Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ

хувийн хэвшлийн салбарынхантай зөвлөлдөх

Орц 3.1.2. Төр, хувийн хэвшил, нутгийн ард иргэдийн түншлэлийн (ТХХНАИТ-РПСР) нөөц боломжийг тодорхойлох үүднээс мал аж ахуйн хөрөнгө оруулалтын үзэсгэлэн худалдааг дэмжиж, зохион байгуулах

Үйл ажиллагаа нь үзэл санаа болон боломжуудын талаар олон нийтэд ойлголт өгөхөд чиглэсэн байна.
Зарим малчдыг оруулахгүй байх эрсдэлтэй.
Малчдын зүгээс “хөрөнгө оруулалтын үзэсгэлэн худалдааг” өөрийн болгож авч чадахгүй байх байдал
Бэлтгэл ажил хангалтгүй байх

Магадлал: 2
Үр дагавар: 2
Эрсдэл:Бага зэрэг

Оролцогч талуудын оролцоо
Зохих хэмжээнд бэлтгэл хийхэд туслалцаа үзүүлэх техникийн мэдлэг олгох нөхцөл
"Хөрөнгө оруулалтын үзэсгэлэн"-г дөрвөн аймгийн хэмжээнд тогтмол зохион байгуулах
Уг арга хэмжээг малчид болон хувийн хэвшлийн салбарын түүхий эд, материалын холбоодуудад зориулан зохион байгуулах
Уг арга хэмжээг олон нийтэд сайн сурталчилан таниулж, бүх оролцогч талуудад нээлттэй байх хэрэгтэй.

Магадлал: 1
Үр дагавар: 2
Эрсдэл:Бага зэрэг

Орц 3.1.3: Олж тодорхойлсон боломжид тулгуурлан ТХХНАИТ-ийн гэрээг дэмжиж, эцэслэн боловсруулна.

Энэхүү үйл ажиллагаа нь гэрээг боловсруулж/эцэслэн байгуулахад чиглэсэн байна.
Эрсдийн мөн чанар нь гэрээний талууд ба/эсвэл талуудын харилцаанд байдаг.
Хэлэлцээ хийх болон эрх зүйн ур чадвар хязгаарлагдмал

Магадлал: 1
Үр дагавар: 3
Эрсдэл:Бага зэрэг

Эрх тэгш болон шударга үр дүнг хангаж ажиллахын тулд малчдын бүлгүүдийг хувийн хэвшлийн салбарынхантай хэлэлцээ хийхэд нь дэмжлэг үзүүлэх
Үүрэг хариуцлагуудыг нарийн тодорхойлсон эдгээр гэрээнүүдийн хууль ёсны маягтуудыг боловсруулах
Гэрээнүүдийг баталгаажуулахад зориулж, нэгдсэн байдлаар хурдавчилсан дүн шинжилгээ хийх арга хэрэгслийг боловсруулах
Техникийн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх нөхцөл

Магадлал: 1
Үр дагавар: 2
Эрсдэл:Бага зэрэг

Activity 3.2: Малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэгч малчдын байгууллагуудыг байгуулж, сургалт зохион байгуулах

<p>Орц 3.2.1. ҮБА-уудад оролцох нутгийн ард иргэдийн бүх сонирхсон гишүүдийг шударга, эрх тэгш хамруулах урьдчилсан нөхцөл болгож, одоо байгаа шийдвэр гаргах үйл явц болон нутгийн ард иргэдийн засаглалын механизмыг шалгах үүднээс бэлэн байдлын үнэлгээ явуулна.</p>	<p>Чадавхи болон эрэлт хэрэгцээг нягтлан үзэх үйл ажиллагаануудыг хамруулах</p>	<p>Магадлал: 1 Үр дагавар: 1 Эрсдэл:Бага зэрэг</p>	<p>Техникийн дэмжлэг үзүүлэх болно.</p>	<p>Магадлал: 1 Үр дагавар: 1 Эрсдэл:Бага зэрэг</p>
<p>Орц 3.2.2: Үйлдвэрлэл, түүхий эд хурааж авсны дараах боловсруулалт, түүхий эд хурааж авсны дараа нэмүү өртөг шингээх, газар дээр нь агуулж хадгалах зэрэг зах зээлийн тодорхой сургалт явуулах</p>	<p>Тухайн түүхий эд, бараатай холбоотой сургалт. Төслийн зүгээс сургалт зохион байгуулах боловч, агуулах эсвэл боловсруулах байгууламж, боловсруулах байгууламжаас гарах хог хаягдлын тухай хурал гэх мэт сургалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой хоёрдогч нөлөөлөл үзүүлэх магадлалтай арга туршлага үр дүнд нь гарч болох юм.</p>	<p>Магадлал: 2 Үр дагавар: 3 Эрсдэл:Дунд зэрэг</p>	<p>Сургалтанд байгаль орчин/нийгэмд үзүүлэх нөлөөллийн асуудлуудыг хамруулсан, үйлдвэрлэл болон түүхий эдийг хурааж авсны дараах үйлдвэрлэл зэрэг бүх талуудыг хамруулах болно. БОНМБХХ-ийг (ESMF) хэрэглэх явдал нь төсөл дууссанаас хойш ч үргэлжлэх боломжтой бөгөөд – ж нь, хамгийн шилдэг арга туршлагыг үйл ажиллагаанд уялдуулж болно.</p>	<p>Магадлал: 1 Үр дагавар: 2 Эрсдэл:Бага зэрэг</p>



**Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ**

<p>Орц 3.2.3: Бизнесийн эрэлт хэрэгцээг дэмжихийн тулд жижиг хэмжээний хөрөнгө оруулалт</p>	<p>Уг үйл ажиллагааг эхлүүлэх үүднээс БНАБ-үүдэд уг үйл ажиллагааны хүрээнд санхүүжилт олгоно.</p> <p>Санхүүгийн чанартай эрсдэл гэвэл, санг зориулалтын бусаар зарцуулах, сангийн эрх тэгш бус байдлаар олгох нөхцөл гэх мэт.</p>	<p>Магадлал: 3 Үр дагавар: 2 Эрсдэл: Дунд зэрэг</p>	<p>Санхүүжилтийг ТХХНАИТ-ийн (РРСР) үүрэг хариуцлагыг биелүүлэхтэй холбоотой юм.</p> <p>БНАБ-үүдэд санхүүгийн болон менежментийн сургалтууд зохион байгуулна.</p> <p>БНАБ-ийн үйл ажиллагааг гэрээнд маш тодорхой зааж өгсөн байх тул үүнд аудит хийж, мөшгих боломжтой.</p> <p>Техникийн дэмжлэг үзүүлэх болно.</p>	<p>Магадлал: 1 Үр дагавар: 2 Эрсдэл: Бага зэрэг</p>
---	--	---	--	---

<p>Орц 3.2.4 Малчин өрх бүлд төслийн хөндлөнгийн оролцоо хэрхэн нөлөөлсөн талаар үнэлгээ хийх</p>	<p>Уг үйл ажиллагаанд үнэлэлт/дүгнэлт хийх нягтлан үзэх үйл ажиллагааг хамруулна.</p>	<p>Магадлал: 1 Үр дагавар: 1 Эрсдэл: Бага зэрэг</p>	<p>Магадлал: 1 Үр дагавар: 1 Эрсдэл: Бага зэрэг</p>
---	---	---	---

Үйл ажиллагаа 3.3: Тогтвортой зарчмаар ханган нийлүүлсэн, уур амьсгалт тэсвэртэй малын гаралтай бүтээгдэхүүнүүдийг мөшгих тогтолцоог сайжруулах

<p>Орц 3.3.1 Тогтвортой зарчмаар ханган нийлүүлсэн, уур амьсгалт тэсвэртэй малын гаралтай бүтээгдэхүүнийг баталгаажуулах үйл явцыг мөшгих боломжийн талаар судалгаа явуулж, дүн шинжилгээ хийх</p>	<p>Одоогоор төлөвлөсөн байгаа мөшгих тогтолцоог нягтлан үзэж, харилцан зөвлөлдөж, судалгаа явуулах эхний судалгааны ажлыг хийх ба үүнд сөрөг нөлөөлөл байхгүй гэж үзэж байна.</p> <p>Техникийн дэмжлэг хэрэгтэй болно.</p>	<p>Магадлал: 2 Үр дагавар: 3 Эрсдэл: Дунд зэрэг</p>	<p>Техникийн дэмжлэг үзүүлэх болно.</p>	<p>Магадлал: 2 Үр дагавар: 2 Эрсдэл: Бага зэрэг</p>
--	--	---	---	---



**Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ**

<p>Орц 3.3.2 Уур амьсгалд тэсвэртэй бүтээгдэхүүнүүдийн стандарт хэм хэмжээг нягтлан үзэж/төслийг нь боловсруулах</p>	<p>Бүх зохих оролцогч талуудыг оролцуулахгүй байх эрсдэл</p>	<p>Магадлал: 2 Үр дагавар: 3 Эрсдэл: Дунд зэрэг</p>	<p>Өргөн хүрээний оролцогч талуудыг хамруулах нөхцлийг хангах (ж нь, засгийн газар, хувийн хэвшил, нутгийн ард иргэд)</p>	<p>Магадлал: 2 Үр дагавар: 2 Эрсдэл:Бага зэрэг</p>
<p>Орц 3.3.3 Мөшгих боломжтой бүтээгдэхүүний хөгжлийг дэмжихийн тулд ТХХНАИТ-ийн гэрээний төслийг боловсруулах (Үйл ажиллагаа 3.1.3.-тай холбоотой)</p>	<p>Энэхүү үйл ажиллагаа нь мөшгих тогтолцоотой холбоотой гэрээг тойрсон үйл ажиллагаа. Эрсдлийн мөн чанарын хувьд гэрээлэгч талууд ба/эсвэл талуудын харилцаанаас хамааралтай. Эрсдэл болон учруулах нөлөөллийг бага гэж үзсэн. Хэлэлцээ хийх болон эрх зүйн ур чадвах хязгаарлагдмал.</p>	<p>Магадлал: 1 Үр дагавар: 3 Эрсдэл:Бага зэрэг</p>	<p>Эрх тэгш, шударга үр дүнд хүргэхийн тулд, малчдын бүлгүүдийг хувийн хэвшлийн салбарынхантай хэлэлцээ хийхэд нь дэмжиж ажиллана. Үүрэг, хариуцлагуудыг нарийн зааж өгсөн эдгээр гэрээнүүдийн хууль ёсны загваруудыг боловсруулна. Гэрээнүүдийг баталгаажуулахын тулд нэгдсэн байдлаар хурдавчилсан дүн шинжилгээ хийх арга хэрэгслийг боловсруулна. Техникийн болон хууль эрх зүйн дэмжлэг үзүүлэх</p>	<p>Магадлал: 1 Үр дагавар: 2 Эрсдэл:Бага зэрэг</p>
<p>Орц 3.3.4 Малын гаралтай бүтээгдэхүүний мөшгих загвар тогтолцоог боловсруулах (3.3.1-ийн мэдээллээр хангагдсан байх)</p>	<p>Уг үйл ажиллагаа нь техник шинж чанартай бөгөөд нарийн мэргэжилтэн шаардлагатай болно.</p>	<p>Магадлал: 2 Үр дагавар: 3 Эрсдэл: Дунд зэрэг</p>	<p>Техникийн мэргэжлийн мэдлэг олгох болно</p>	<p>Магадлал: 2 Үр дагавар: 2 Эрсдэл:Бага зэрэг</p>



**Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ**

Орц 3.3.5 Мөшгих тогтолцооны үр дүнд дүн шинжилгээ хийж, баримтжуулж, мэдлэгээ хуваалцах зорилгоор бусдад түгээх	Энэ үйл ажиллагаа нь нотолгоог баримтжуулах тухай юм. Төслийн зүгээс ямар нэгэн эрсдэл байхгүй гэж үзэж байна.	Магадлал: 1 Үр дагавар: 2 Эрсдэл:Бага зэрэг	Бууруулах арга хэмжээ авах шаардлагагүй.	Магадлал: 1 Үр дагавар: 2 Эрсдэл:Бага зэрэг
--	--	---	--	---

Үйл ажиллагаа 3.4: Монгол улсад хувийн хэвшлийн оролцоог дэмжиж, уур амьсгалд тэсвэртэй, тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд малчдын [иргэний болон улстөрийн] эрхийг олгохыг дэмжих үүднээс мэдлэгийн бүтээгдэхүүнийг бүтээж, түгээн тараах

Орц 3.4.1. Бүтээлч санхүүжилтийн механизмд чиглэсэн (ж нь, тогтвортойгоор ханган нийлүүлэх платформ, нөлөөлөл үзүүлэхүйц хөрөнгө оруулалтын сан) хамгийн шилдэг туршлага бүхий мэдлэгийн бүтээгдэхүүнүүдийг бий болгоно	Уг бүтээгдэхүүн нь зорьсон хэрэглэгч нарын хувьд тохиромжтой бус байх Энэ үйл ажиллагаатай холбоотой эрсдэл байга гэж үзсэн Сурталчилгааны ажил нь өргөн хүрээнд боломжит хөрөнгө оруулагч нарт хүрэхгүй байх Төслийн хүрээнд гарсан гэх амжилтын талаар хөрөнгө оруулагч нар тодорхой/шууд талархан хүлээн авахгүй байх (ж нь, амжилтын талаар сайн ухуулж чадаагүй)	Магадлал: 2 Үр дагавар: 2 Эрсдэл:Бага зэрэг	Зорилтот хэрэглэгчидтэй зөвлөлдөх Боломжит хөрөнгө оруулагчдын өргөн хүрээний оролцоо Олон төрлийн хэвлэл мэдээллийн арга хэрэгсэл/ сувгуудаар өргөн хүрээнд сурталчлах Амжилтыг онцолж, боломжит хөрөнгө оруулагчдад ач холбогдлын хувьд хамаатай болгох	Магадлал: 1 Үр дагавар: 2 Эрсдэл:Бага зэрэг
Орц 3.4.2: Тогтвортой арга ажиллагааны талаар хувийн хэвшлийн салбар мөн/эсвэл боломжит хөрөнгө	Харилцаа холбооны сувгууд нь зохисгүй Материалууд нь тохиромжгүй Хэрэглэгчид нь уг асуудлыг өөрийн болгож хүлээн авахгүй байх	Магадлал: 2 Үр дагавар: 3 Эрсдэл:Дунд зэрэг	Ашиглаж болох өргөн хүрээний харилцаа холбооны сувгууд бий Материалыг боловсруулах техникийн мэдлэг	Магадлал: 1 Үр дагавар: 2 Эрсдэл:Бага зэрэг



GREEN
CLIMATE
FUND

оруулагчид болон
эцсийн
хэрэглэгчид/төрийн
байгууллагуудын
ойлголтыг
дээшлүүлэхийн
тулд төслийн
амжилтын талаар
сурталчилах

**Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ**

Зорилтот үзэгчдэд зориулсан шалгах
материалууд

Ж нь, уншигчдад шууд ач холбогдолтой
байлгаж мөн тэдний зүгээс хэрэгжүүлж
болох арга хэмжээг санал болгох зэргээр,
эцсийн хэрэглэгчид/олон нийтийн хүрээнд
“хувь хүний түвшинд” хүрч чадсан материал
бэлтгэх

1.3.1 Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээг хөгжүүлэх суурь ойлголт Н

57. Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийн менежментийн бүтэц, хамрах хүрээг (БОНҮНМБХХ-ESMF) бэлтгэх хүрээнд дараах ойлголтуудыг гаргаж ирсэн:

- Төслийн ямар ч хөндлөнгийн оролцооны хувьд хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх шаардлагагүй болно, ж нь, гэр орон эсвэл үүнтэй адилтгах барилга дэд бүтэц алдагдахгүй байх болно;
- дэд бүтэцэд шаардагдах аливаа газар нь нэг бол төрийн мэдлийн, эсхүл газар эзэмшигчийн зөвшөөрөлтэй ашиглах болно;
- ямар ч үйл ажиллагаа хуультай зөрчилдөхгүй;
- далан, хашлага зэрэг дэд бүтэц нь жижигхэн байх тул эрсдэл багатай – энэ төслийн бүрэлдэхүүнд том барилгын бүтээн байгуулалт орохгүй;
- төслийн бүхий л үе шатанд хөрсний элэгдэл болон хурдас, тунадасын зохих хяналтыг хийж байх болно;
- төслийн үр дүнд бохирдол ба / эсвэл химийн бодис гарахгүй.

1.3.2 Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохион байгуулах бүтэц, хамрах хүрээний зорилго болон зорилтууд

58. БОНҮНМБХХ (ESMF) гэдэг нь байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөллийг бууруулж, мөн байгаль орчин ба нийгмийн багц зорилтуудыг биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд ашиглах менежментийн арга хэрэгсэл юм. Энэхүү БОНҮНМБХХ-ийг УАНС-гийн “Монгол улсын хөдөө орон нутгийн ард иргэдийн дасан зохицох чадвар болон эрсдлийн менежментийг сайжруулах” төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох зорилгоор бэлтгэн гаргасан.

59. Төслийн байгаль орчин, нийгмийн зорилтыг биелүүлэхийн тулд энэхүү БОНҮНМБХХ-ийг байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, эсвэл бууруулахад шаардлагатай байгаль орчны менежментийн хамгаалалтыг боловсруулж, хяналт тавихдаа төсөл хэрэгжүүлэгчид ашиглаж байх болно.

60. БОНҮНМБХХ нь нийгмийн болон хүрээлэн буй орчинд нөлөөлж болохуйц асуудлууд болон төслийн тодорхой үйл ажиллагаануудын байршил болон нарийвчилсан мэдээллүүд нь цаашид улам тодорхой болохын хэрээр тэдгээрээс үүсэн гарах нөлөөлөл зэрэгт хурдавчилсан байдлаар дүн шинжилгээ хийх алхамуудыг тодорхойлох бөгөөд мөн зайлсхийх боломжтой үед нь сөрөг нөлөөллөөс зайлсхийх, багасгах, бууруулах, удирдан зохицуулахад чиглэсэн зохих үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийг бэлтгэж, батлахад зориулагдсан болно.

61. Төслийн байгаль орчин ба нийгмийн зорилтууд нь:

- Зорилтот газруудад усны хангамжийг сайжруулах мөн усны нөөцийг хадгалан хамгаалах арга хэмжээг нэвтрүүлэх
- Аливаа үйл явдал тохиолдохоос өмнө нь хангалттай арга хэмжээ авах нөхцлийг бүрдүүлэхийн тулд урьдчилан сэрэмжлүүлэх системийг хангаж өгөх;
- Бэлчээрийн менежмент болон байгаль орчны арга туршлагыг төлөвлөж, тууштай хэрэгжүүлж, байнга сайжруулах замаар сайн менежментийн арга туршлагыг хөхиүлэн дэмжих;
- Газар, агаар, усны бохирдлыг бууруулах эсвэл урьдчилан сэргийлэх;
- Нутгийн уугуул ургамал, амьтан болон чухал экосистемийг хамгаалах;
- Байгаль орчныг хамгаалах холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг дагаж мөрдөх;
- Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг урьдчилан сэргийлэх, багасгах боломжтой хамгийн сайн практик арга туршлагыг ашиглах;
- Малчид болон газар тариаланчдын өрхийн амьжиргааг дээшлүүлэх;
- Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тодорхойлоход шаардлагатай хяналт шинжилгээний журмыг тайлбарлах;
- Байгаль орчны үүрэг хариуцлагатай холбоотойгоор, Байгаль орчны яам, Хүнс хөдөө аж ахуйн яам, НҮБХХ-ийн хүлээсэн үүрэг хариуцлагын талаар товч тойм мэдээлэл өгөх.

62. Төслийн нарийвчилсан төлөвлөлтийн үе шатанд гарах өөрчлөлтүүдийг уялдуулах үүднээс, Төслийн менежментийн нэгж (ТМН-PIU)/гэрээлэгч байгууллага нь НҮБХХ-ийн ажилтнууд болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай (MoFALI) хамтран зөвлөлдсөний үр дүнд БОНҮНМБХХ-ийг цаг тутам шинэчилж байх болно.



1.3.3 Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохион байгуулах бүтэц, хамрах хүрээний хурдавчилсан үнэлгээний журам

Н

Анхны түргэвчилсэн дүн шинжилгээг НҮБХХ-ийн Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийн менежментийн бүтэц, хамрах хүрээний журмыг ашиглан хийсэн болно. Төлөвлөж буй үйл ажиллагааны үнэлгээг улмаар хийж, эрсдэл, болзошгүй нөлөөллийг танилцуулав (Хүснэгт 4).

НҮБХХ-ийн Нийгэм ба байгаль орчны стандарт (НБОС-SES) болон УАНС-гийн Байгаль орчин ба нийгмийн хамгаалал (БОНХ-ESS) хэмээх стандарт журмуудыг төслийн бүх үе шатанд хэрэглэх бөгөөд төслийн хэрэгжилтийн явцад хэрэгжилтээс нь өмнө дэд үйл ажиллагаануудыг хурдавчилсан байдлаар дүн шинжлэх хэрэгтэй байж магадгүй юм. Төслийн эхэн үеийн хэрэгжилтийн нэг хэсэг бол нутгийн ард иргэдтэй хамтран зохих дэд үйл ажиллагаануудыг сонгох мөн дэд үйл ажиллагаануудыг нарийвчлан боловсруулах ажлыг хийх болно. Хурдавчилсан үнэлгээг НҮБХХ-ийн НҮБХХ-ийн Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийн менежментийн бүтэц, хамрах хүрээний журмын (SESP) дагуу хийх болно (Хавсралт 1). ХХААХҮЯ болон НҮБХХ нь дэд үйл ажиллагаануудыг хурдавчилсан байдлаар дүн шинжлэх болон олон нийтэд ил тод байдлыг хангаж ажиллах үүрэгтэй. Хасах зүйлсийн жагсаалтын (дор харуулсан) шаардлагад нийцсэн аливаа дэд үйл ажиллагаануудыг цаашид авч хэлэлцэхгүй болно.

1.3.3.1 Хасах зүйлсийн жагсаалт

“Өндөр эрсдэлтэй” байж болно гэж үзсэн аливаа үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөхгүй.

Дээр нь төслийн үйл ажиллагаануудыг дараах “сөрөг жагсаалт” эсвэл “хасах жагсаалтын” дагуу хурдавчилсан байдлаар дүн шинжилж үзнэ. “Монгол орны хөдөө орон нутгийн ард иргэдийн дасан зохицох чадвар ба эрсдлийн менежментийг сайжруулах нь” төслийн хувьд дараах дэд үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх боломжгүй юм, хэрвээ тэдгээр нь:

- Байгалийн амьдрах таатай орчинг ихээхэн хэмжээгээр хувиргаж эсвэл доройтуулахаар байвал мөн/эсвэл байгалийн нэн чухал амьдрах таатай орчинд хэмжигдэхүйц хэмжээний сөрөг нөлөөлөл учруулахаар байвал;
- Гадны төрөл зүйл болон түрэмгий байж болзошгүй гадны төрөл зүйлийг нэвтрүүлэх эрсдэлтэй байвал;
- Устах аюулд өртөөд буй төрөл зүйлд сөргөөр нөлөөлж магадгүй бол;
- Хүн ардыг биет байдлаар эсвэл эдийн засгийн зорилгоор нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг хамарч байгаа бол;
- Соёлын өвийг гэмтээх эсвэл алдахад хүргэхээр бол;
- Муу боловсруулсан эсвэл барилгын чанар муу, ялангуяа эмзэг газар байршуулах гэж байгаа зэрэг төсөл боловсруулах стандартын хамгийн доод хэмжээнд хүрээгүй бол;
- Мөн дараах зүйлсийг шаардсан эсвэл хамруулахаар байвал;
 - Хүлээн авагч улсын хууль тогтоомж эсвэл олон улсын конвенц болон хэлэлцээрийн дагуу хууль бус гэж үздэг аливаа бүтээгдэхүүн эсвэл үйл ажиллагааны үйлдвэрлэл эсвэл худалдаа;
 - Хортон шавьж устгах хортой бодис, аюултай материалыг худалдан авах, ашиглах, хадгалах;
 - Албадан хөдөлмөрлүүлэх/хүүхдийн аюултай хөдөлмөр зэргийг агуулсан үйлдвэрлэл эсвэл үйл ажиллагаа;
 - Зохицуулалт хийгдээгүй ой модноос авсан мод эсвэл бусад ойн аж ахуйн бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэх эсвэл худалдаалах;
 - Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн (CITES) дагуу зохицуулсан байдаг, зэрлэг ан амьтан болон зэрлэг ан амьтны гаралтай бүтээгдэхүүний худалдаа.
 -

1.3.3.2 Дэд үйл ажиллагаануудад хурдавчилсан байдлаар дүн шинжилгээ хийх

Энэ хэсэг нь төслийн хэрэгжилтийн явцад дэд үйл ажиллагаанууд болон холбогдох бүрэлдэхүүн хэсгүүдийг хурдавчилсан байдлаар дүн шинжилгээ хийх үйл явцыг зааж өгсөн байдаг. Төслийн явцад боловсруулсан аливаа дэд үйл ажиллагаа болон түүнтэй холбоотой бүрэлдэхүүн хэсгүүдийг хүрээлэн

буй орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийн болзошгүй эрсдлийг тодорхойлох, холбогдох бууруулах боломжуудыг тодорхойлохын тулд доор тайлбарласан хурдавчилсан дүн шинжилгээ хийх явцын дагуу үнэлэх ёстой.

Уг үйл явц нь дараах алхамуудаас бүрдэнэ:

- Алхам 1: хангалттай хэмжээний нарийвчилсан мэдээлэлтэй болсны дараа, дэд үйл ажиллагаа тус бүрийг эсвэл холбогдох бүрэлдэхүүн хэсгийг хурдавчилсан байдлаар дүн шинжилж, ангилах ёстой бөгөөд төслийг цаашид боловсруулж урагшлуулах эсвэл болзошгүй сөрөг нөлөөллийг “хасаж, бууруулах” шийдвэр гарахад, уг төслийн санал нь В болон С ангиллын хүрээнд хэвээр байх нөхцлийг хангаж засаж өөрчилж мөн холбогдох хамгаалалтын арга хэрэгслийг олж тогтооно. Энэхүү 1-р алхмын нэг хэсэг бол, дэд үйл ажиллагаануудыг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хурдавчилсан байдлаар дүн шинжлэх болно. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ шаардлагатай эсэхийг тодорхойлохын тулд уг үйл ажиллагаануудыг Монгол улсын Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжуудад заасан шаардлагын дагуу үнэлж дүгнэх болно.
- Алхам 2: Шаардалгатай тохиолдолд оролцогч талуудтай зөвлөлдөх зэргээр, шаардлагатай хамгаалалтын арга хэрэгслүүдийг бэлтгэнэ. (БОНБҮ ба/эсвэл Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан зохион байгуулах төлөвлөгөөг (ESMPs) бэлтгэнэ).
- Алхам 3: Монгол улсын болон НҮБХХ-ийн хамгаалалтын бодлогуудын дагуу бэлтгэсэн хамгаалалтын арга хэрэгслүүдийг нягтлан үзнэ; шаардлагатай гэж үзсэн тохиолдолд оролцогч талуудын нэмэлт зөвлөгөөн хийх.
- Алхам 4: Батлагдсан арга хэрэгслийг дотооддоо болон НҮБХХ-ийн цахим хуудсаар дамжуулан ил болгоно. В ангиллын дэд үйл ажиллагаануудын хувьд, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБҮ) ба/эсвэл Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан зохион байгуулах төлөвлөгөөг (ESMPs) батлагдсан шийдвэр гарахаас доод тал нь 30 хоногийн өмнө олон нийтэд ил болгох хэрэгтэй. Хамгаалалтын арга хэмжээний талаарх тайланг Англи болон дотоодын эх хэлийн аль алианаар нь хэвлэж гаргасан байна. Тайлангуудыг УАНС-нд өргөн барих бөгөөд УАНС-нд УАНС болон НҮБХХ-ийн цахим хуудсуудаар дамжуулан цахим холбоосыг илгээх замаар мөн УАНС-гийн Байгаль орчин ба нийгмийн бодлогын УАНС-гийн Мэдээллийг ил тод болгох бодлого ба (Мэдээллийг ил тод болгох) 7.1-р хэсгийн шаардлагуудтай нийцүүлж, төслийн нөлөөнд өртөж буй хүмүүсийн хувьд тухтай газарт нь хүргэх замаар хүртээмжтэй болгоно.
- Алхам 5: Хэрэгжүүлэлт – хяналт, тайлагнал, хохирлыг арилгах арга хэмжээ. Зөвлөгөөн болон нутгийн ард иргэдтэй үргэлжүүлэн харилцах.

1.3.4 Газрын асуудлууд

63. Монгол орны газар нутгийн ихэнхийнх нь хувьд эдэлбэр газрыг бүртгүүлэх хэрэгтэй байсаар л байгаа, хэдийгээр бэлчээрийн уламжлалт хил хязгаар байсаар байгаа боловч олон малдын бүлгүүд одоогоор өөрсдийн эдэлбэр газраа илүү хууль ёсны газрын эрхтэй болгож баталгаажуулахын тулд бүртгүүлэх үйл явцдаа байгаа.
64. Төслийн хувьд БАБ-үүдийг байгуулж, бэхжүүлэх замаар эдэлбэр газруудыг бүртгүүлэх үйл явцыг дэмжиж ажиллана.

1.3.5 Нутгийн уугуул ард иргэд

65. Монгол улс нь харьцангуй нэгэн ижил гаралтай, тархай суурьшсан хүн амтай улс юм. Хүн амынх нь 85% орчим нь Монгол гаралтай бөгөөд голцуу Халх (90%), Дүрвэд, болон бусад Монголчууд байдаг бол тус улсын баруун хойд хэсгээр буюу Баян-Өлгий гэх баруун аймагт голдуу төвлөрсөн байдаг Казак хэлээр ярьдаг Мусульман шашинтай милээн (ойролцоогоор 4%) бодит тоо хэмжээний цөөнхүүд амьдардаг. Мөн Дүрвэд, Баяд, Буриад, Дарьганга монголчууд гэх мэт өвөрмөц аялга, соёлтой бусад олон Монгол ястнууд байдаг. Мөн Казакуудаас гадна, Монгол улсын баруун болон хойд хэсгээр түрэг хэлтэй бусад зарим жижиг цөөнх ястнууд (Уйгур, Узбек, Тува, Урианхай, Хотончууд) байдаг.¹
66. УАНС-гийн Нутгийн уугуул ард иргэдийн бодлогын дагуу, төслийн хувьд “нутгийн уугуул ард түмэн ихэвчлэн үндэсний нийгэм дэх үндсэн бүлгүүдээс ялгаатай, онцлог өвөрмөц байдал, хүсэл эрмэлзэлтэй байдаг бөгөөд сөрөг нөлөөллийг бууруулах, түүнд дасан зохицох, хөгжүүлэх

¹ World Directory of Minorities and Indigenous Peoples – Mongolia <https://www.refworld.org/docid/4954ce4bc.html> accessed 10/3/20

уламжлалт загвартай байдгийнхаа хувьд эмзэг байдалтай байдаг." Ихэнх тохиолдолд эдгээр нь хүн амын дунд эдийн засгийнхаа байдлаар хамгийн гадуурхагдсан бөгөөд эмзэг бүрэлдэхүүн хэсэг нь байдаг. Уугуул иргэдийн эдийн засаг, нийгэм, хууль эрх зүйн байдал нь газар, нутаг дэвсгэр, байгалийн болон соёлын баялгийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах чадварыг нь ихэвчлэн хязгаарлаж байдаг бөгөөд хөгжлийн санаачлагууд болон уур амьсгалын өөрчлөлтийн үйл ажиллагаанд оролцох болон тэдгээрээс үр ашиг хүртэх тал дээр тэдний боломжийг нь хязгаарлаж байдаг байна.

67. Зохих ёсны анхаарал халамжийн нэг хэсэг бол нутгийн уугуул иргэд ба / эсвэл үндэстний цөөнхийг хамруулсан, хэрэгжих магадлалтай аливаа төслийн үйл ажиллагааны талаар магадлан дүн шинжилж, харилцан зөвлөлдөх үйл ажиллагааг явуулдаг. Төсөл хэрэгжих дөрвөн аймгууд нь ястан үндэстний хувьд ихээхэн олон янз бөгөөд эдгээр газар нутагт Монгол орны цөөнх болсон ястан үндэстнүүдийн ихэнх нь амьдардаг - эдгээр газар нутагт ж нь Ховдод эдгээр нь цөөнх биш байдаг, энд Халх хүмүүс аймгийн нийт хүн амын зөвхөн 28.4%-ийг бүрдүүлж байдаг.
68. Төсөл нь зөвлөлдөх үйл явц, ялангуяа Бэлчээр ашиглагчдын бүлгүүдийг албажуулах, Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах зэрэг үйл явцад тулгуурласан болно. Тийм учраас (үндэстний хүн амын ойролцоогоор 4%-ийг бүрдүүлж байдаг боловч төсөл хэрэгжүүлэх аймгуудад өндөр хувьтай байдаг) нийгмийн цөөнх болсон бүлгүүдтэй үргэлжлүүлэн зөвлөлдөж, төсөлдөө хамруулах болно. Цаашлаад төслийн хөндлөнгийн оролцоо нь дөрвөн аймгийн бүх малчин өрх (100%) нь хүйс, нийгэм, эдийн засгийн төлөв байдал, угсаатны гарлаасаа үл хамааран үр ашиг хүртэх нөхцлийг хангаж ажиллах болно. Төсөл нь төслийн үр ашгийг хүртэгчид болон аймгуудын дунд тэнцвэртэйгээр, тэгш ашиг хүртэх боломжийг олгоно.

1.4 Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохион байгуулах бүтэц, хамрах хүрээний төлөвлөгөөнд чиглэсэн институтын түвшний зохицуулалтын тухай тойм

69. Ямар нэгэн ажлыг хийж гүйцэтгэхээс өмнө, Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохион байгуулах бүтэц, хамрах хүрээг (БОНҮНМБХХ - EMSF) БОЯ болон НҮБХХ дэд үйл ажиллагаа тус бүрээр үнэлдэг. БОНҮНМБХХ нь төслийн зүгээс байгаль орчин болон нийгэмд үзүүлж болзошгүй эрсдлүүдийг олж тогтоон, тэдгээр эрсдлүүдийг зохицуулах стратеги болон байгаль орчин болон нийгэмд үзүүлэх хүсээгүй нөлөөллийг бууруулах талаар тусгадаг. Цаашлаад БОНҮНМБХХ нь өөрсдийнх нь үзэл санааг харгалзан авч үзээгүй хэмээн, төслийн нөлөөлөлд өртсөн байж болзошгүй хүмүүст зориулсан Өргөдөл, гомдлыг барагдуулах механизмаар хангаж өгдөг.
70. БОЯ нь БОНҮНМБХХ-нд хяналт тавьж ажиллах үүрэг хүлээсэн байдаг. НҮБХХ нь БОЯ-ны баталгааг олж авах бөгөөд БОНҮНМБХХ-ийг зохих ёсоор дагаж мөрдөх нөхцлийг хангаж ажиллана. Төслийн менежментийн нэгж (ТМН-PIU) нь шаардлагатай үед нь гүйцэтгэгчийн зүгээс цаг алдалгүй сөрөг нөлөөллийг арилгах арга хэмжээ авах нөхцлийг хангаж ажиллана.

1.4.1 Удирдалага

71. БОЯ нь ажлын явцад энэхүү баримт бичгийг хянан засварлаж эсвэл шинэчлэх үүрэг хариуцлагатай байна. Тухайн баримт бичгийг оноож өгсөн уг хүний хувьд үүнийг шинэчилж байх үүрэгтэй байдаг.
72. Тухайн талбайд хяналт тавих үүрэгтэй хүн нь тухайн барилгын ажил явагдаж буй газарт өдөр тутам байгаль орчны үзлэг шалгалт хийх үүрэгтэй. Ийм үзлэг шалгалтуудыг нийтэд нь БОЯ сар бүр аудит хийж ажиллана.
73. Гэрээлэгч нь өргөдөл гомдол болон тэдгээр гомдлуудын учир шалтгааныг бууруулсан тэмдэглэл бүхий өргөдөл гомдлын бүртгэлийг багтаасан, захиргааны болон байгаль орчны бүхий л бүртгэлийг хөтөлж, хадгалж ажиллах болно.
74. БОНҮНМБХХ-ийг (ESMF) тухайн өдөр өдөрт нь мөрдөж, хариуцан ажиллана.
75. БОЯ нь хэрэгжүүлэгч агентлаг байх бөгөөд хамтрагч талууд болон гэрээлэгчидтэй хамтран ажиллах замаар БОНҮНМБХХ-ийг хэрэгжүүлж, мөрдүүлж ажиллах үүрэг хариуцлагатай байх болно. БОНҮНМБХХ нь аливаа тендерийн баримтжуулалтын нэг хэсэг нь байх болно.



76. Хяналтын инженер / Төслийн менежер нь гүйцэтгэгчид хяналт тавьдаг бол БОЯ нь байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн асуудлыг хариуцна.

Н

1.4.2 Чадавхи бэхжүүлэх нь

77. Тухайн төсөл нь хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх асуудалд төвлөрсөн бүрэлдэхүүн хэсгүүдийг хамарсан байна. Зарим ийм үйл ажиллагаанд нь:

- Загварчлал хийх, урьдчилан таамаглах ур чадварыг сайжруулахын тулд УЦУОШГ-ын (NAMEM) чадавхийг бэхжүүлэх бөгөөд үүнд дэвшилтэт супер компьютерийг ашиглах, шинэ арга, загвар, боловсруулалтын дараах аргуудыг ашиглах зэрэг үйл ажиллагаанууд орно. Цаг уурын нэмэлт станцуудыг суурилуулах ажлын хувьд газар дээр нь ажилчдыг сурган дадлагажуулах ажил шаардагдана.
- Орон нутгийн захиргааны албан хаагчдыг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдлийн үнэлгээ, төлөвлөлтөнд сургана, ингэснээр уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг хөгжлийн төлөвлөгөөнд уялдуулж болно. Уур амьсгалын өөрчлөлтийг аймаг ба сумын түвшний төлөвлөгөөнд тусгаагүй байдаг тул ийм арга хэмжээ авах шаардлагатай бөгөөд тэсвэртэй уян хатан байхын тулд уур амьсгалтай холбоотой асуудлын талаар илүү сайн ойлголттой болж мөн тэсвэр, уян хатан байдалд чиглэсэн төлөвлөлт хэрэгтэй болно.
- Хөдөө аж ахуйн салбарт үзүүлэх уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн талаар шинэ Сайд нар болон гол яамдуудын албан хаагч нар ойлголттой болох бөгөөд улмаар уур амьсгалд зохисгүй байдлаар дасан зохицож буй хөдөө аж ахуйн бодлогыг шинэлэл хийх бодлого боловсруулагч нарт нөлөөлөх болно.
- Төслийн томоохон бүрэлдэхүүн хэсэгт бэлчээрийн болон усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг хөгжүүлж, хэрэгжүүлэхийн тулд Байгалийн нөөц ашиглагчдын бүлгийг (БНАБ-RUGs) байгуулах ажлыг хамруулна. Эдгээр нь засгийн газрын хамтран удирдан зохион байгуулсан, нутгийн ард иргэдэд түвшиглэсэн менежментийн систем байх болно. БНАБ-үүд амжилттай байхын тулд, нутгийн ард иргэдийн бүлэг болон засгийн газарт асуудлыг хөнгөвчлөх, гэрээ, хууль эрх зүй, эрх ба үүрэг хариуцлага, хэлэлцээ хийх, бэлчээрийн болон усны нөөцийн менежментийн техникийн асуудлууд зэрэг олон талбарын чадварыг нь сайжруулах сургалт зохион байгуулах хэрэгтэй.
- Тус төсөл нь хөдөө аж ахуйтай холбоотой нэмүү өртгийн сүлжээг нэмэгдүүлэх болно гэж найдаж байна. Үүнд төр, хувийн хэвшлийн түншлэл, Малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэгч малчдын байгууллагууд, зах зээлд илүү сайн нэвтрэх боломжууд зэрэг багтана. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд чадавхийг бий болгох шаардлагатай байна. Үүнд бизнесийн зөвлөх дэмжлэг, санхүүгийн менежмент, эрсдлийн менежмент, гэрээний хэлэлцээ ба удирдлага, ерөнхий менежмент, тухайн зах зээлтэй холбоотой үйлдвэрлэлийн сургалт, түүхий эдийг хураасны дараах боловсруулалт, түүхий эдийг хураасны дараах нэмүү өртөг шингээлт болон тухайн газар дээр нь агуулж хадгалах, дэлхийн зах зээлд нэвтрэх зэрэг асуудал багтана.

2 БАЙГАЛЬ ОРЧИН БОЛОН НИЙГМИЙН АСУУДЛЫН ХУУЛЬ ЗҮЙН БОЛОН ИНСТИТУТЫН БҮТЭЦ, ХАМРАХ ХҮРЭЭ



2.1 Хууль ТОГТООМЖ, БОДЛОГО, ДҮРЭМ, ЖУРМУУД

78. Төсөлд дараах хууль тогтоомжууд хамаарна

- **Байгаль орчныг хамгаалах тухай хууль 1995 он** – Энэхүү үндэсний хууль нь (1995 онд батлагдаж, 2012 онд нэмэлт өөрчлөлт оруулсан) байгаль орчныг хамгаалах, ус, ой, бэлчээр, биологийн олон янз байдал зэрэг байгалийн нөөцийн тогтвортой ашиглалтын чиглэлээр хувь хүмүүс, албан байгууллагууд, Засгийн газрыг зохицуулж байдаг байна. Саяхан Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар, эдэлбэр газруудыг баталгаажуулж, Нутгийн ард иргэдэд түшиглэсэн байгууллагуудад (НАИТБ-СВОs) эрх зүйн статус олгосноор байгалийн нөөцийн тогтвортой менежментэд нутгийн ард иргэдийг татан оролцуулах илүү таатай нөхцлийг бий болгосон байна. Нүүдлийн бэлчээрийг дахин сэргээхийн тулд нийтийн эзэмшлийн бэлчээр ашиглах эрхийн хүрээнд дахин гарч ирсэн НАИТБ-уудыг Монгол улсын иргэний хуульд хүлээн зөвшөөрсөн байдаг бөгөөд энэ нь тус улсын өргөн уудам газар нутагт газрын тогтвортой менежмент болон байгалийн нөөцийн менежментийн хүрээнд нэн чухал үүрэг гүйцэтгэж байгаа байгалийн нөөц ашиглагчид, орон нутгийн ард иргэд, нутгийн эрх зүйн хэм хэмжээнд (customary) буй болсон институтуудыг засгийн газар нь хүлээн зөвшөөрч байгааг тод илэрхийлэл юм. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд оруулсан бас нэг нэмэлт өөрчлөлт нь ойн нөөцөд зориулсан зохион байгуулалтын хэлбэр, эдэлбэр газрын эрх, ашиглагчдын бүлгийн (нөхөрлөл) эрх, үүргийг зохицуулж байдаг.
- **Усны тухай хууль 2004 он** - Энэхүү хууль нь 2004 оны 4-р сард Монгол Улсын Их Хурлаар батлагдаж, усны болон сав газрын усны нөөцийг үр ашигтай ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг. Усны тухай хуульд сав газрын менежмент болон Усны сав газрын байгууллагуудын хууль ёсны мандат/чиг үүргийг нэвтрүүлснийг 19-р Зүйлд тайлбарласан байдаг. Тус хууль нь Сав газрын зөвлөл хэмээн нэрлэгдсэн энэ зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнийг маш тодорхой тусгасан байдаг. Нэмэлт өөрчлөлт оруулсан Усны тухай хууль нь (2012 он) шийдэгдээгүй байсан хэд хэдэн асуудлыг тодорхой болгож өгсөн бөгөөд Усны сав газрын эрх бүхий байгууллагуудыг нэвтрүүлсэн нь Усны эрх бүхий байгууллагаас гаргасан мэргэжлийн дэмжлэг болон зааварчилгааны дагуу үйл ажиллагаа явуулдаг техникийн алба байх бөгөөд холбогдох усны сав газрынхаа хүрээнд усны нөөцийн менежментийн бүх л үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй байдаг. Уг хууль нь 5 бүлэгтэй бөгөөд үүнд Усны нөөц эх үүсвэр, түүний чанар, амьдрах таатай орчны нөхөн сэргээлтийн асуудлыг хамруулсан байдаг. Энэхүү хуулиар усны нөөц, чанарыг хамгаалах, ган, цөлжилтийн үед усны нөөцийг хамгаалах, үр дүнтэй ашиглах, усны хамгаалалт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг урамшуулсан хөшүүргийн арга хэмжээний талаар 31, 32, 35 дугаар зүйлд тусгасан болно.
- **Гарын тухай хууль 2002 он** – Энэ хууль нь иргэд, хуулийн этгээд, байгууллагуудын газар эзэмшил ба ашиглалт мөн бусад холбогдох асуудлуудыг зохицуулж байдаг. Газрын тухай хуулийг хэрэгжүүлэх үндсэн үүрэг хариуцлага нь Аймаг, Сумын албан тушаалтнуудад хамаарах бөгөөд ялангуяа өвөлжөөний бэлчээрийн газар болон өвлийн бэлчээр зэрэг бэлчээрийн нөөц баялгийг хэрэглэгчдэд хуваарилах тал дээр газрын тухай хуулийг тайлбарлаж, хэрэглэх байдал нь бүлгийн хэмжээ, газар эзэмших хугацаа, бусдыг нэвтрүүлэх хүрээнд хийсэн зохицуулалт зэргийн хувьд ялгаатай байж иржээ.
- **Тусгай хамгаалалттай газрын тухай хууль 2011** – Энэхүү хуулиар байгалийн бүс, бүслүүр, тэдний онцгой тогтоц хэлбэр, нэн ховор бөгөөд устах аюулд өртөөд буй амьтан, ургамал, түүхэн болон соёлын газрууд, байгалийн үзэсгэлэнт газрын онцлог шинж тэмдэгийг хэвээр нь хадгалан авч үлдэхийн тулд байгалийн өөрийнх нь газрын төрх байдлыг (ладшафт) хадгалан хамгаалж, газар нутгийг ашиглах, тусгай хамгаалалтад авах мөн тэдний хувьслыг судалж, тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулдаг. Тус хуулиар улсын болон орон нутгийн хэмжээнд тусгай хамгаалалттай газар нутгийн тогтолцоог бий болгох, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн зохицуулалтыг (улсын тусгай хамгаалалттай газар нутаг – State SPAs) тусгасан.
- **Газрын төлбөрийн тухай хууль 2007** – Энэ хуулийн зорилго нь төрийн өмчит газрыг ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шимтгэл ногдуулах, улсын төсөвт төлсөн шимтгэлийг зохицуулахад оршино. Газрын тухай хуулийн нөхцөл, заалтын дагуу гэрээнд тулгуурлан газрыг эзэмшиж эсвэл ашиглаж байгаа Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, эсвэл



байгууллагууд мөн гадаадын дипломат төлөөлөгчийн газрууд, консулын газар, олон улсын байгууллагуудын төлөөлөгчийн газар, гадаадын хуулийн байгууллага болон иргэд бүгдээрээ газрын төлбөр, хураамж төлөөд улсын өмчийн газрыг ашиглах гэрээ байгуулж болно. Энэхүү хуулийг, гэр зуслан (уламжлалт гэр) болон бусад амралтын газруудыг ажиллуулдаг аялал жуулчлалын оператор байгууллагуудаас газрын төлбөр, хураамжуудыг цуглуулах, үнэлгээ хийх зорилгоор орон нутгийн түвшинд аймаг, сумдууд ихээхэн хэрэглэдэг.

- **Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль 2011** – Энэхүү хуулийн зорилго нь байгаль орчныг хамгаалж, экологийн тэнцвэрт бус байдлаас хамгаалж, байгалийн нөөц ашиглалтаас үүдэх сөрөг нөлөөллийг бууруулах нөхцлийг хангаж, бүс нутгийн болон салбарын бодлого, хөгжлийн хөтөлбөрүүд, төлөвлөгөө, төслүүдийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ болон тэдгээрийг батлах шийдвэртэй холбоотойгоор үүсч болох харилцааг зохицуулахад оршино.
- **Жендерийн (хүйсийн) эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай – 2011.** Энэ хуулийн зорилго нь улс төр, хууль, эдийн засаг, нийгэм, соёлын болон гэр бүлийн харилцаанд хүйсийн тэгш байдлыг хангах нөхцлийг буй болгох эрх зүйн үндэс суурийг бий болгож, тэдгээрийн хэрэгжилттэй холбоотой харилцааг зохицуулах зорилготой юм. Энэхүү хууль нь Монгол улсын нутаг дэвсгэр дээр эдийн засгийн үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд болон аж ахуйн нэгж байгууллагууд мөн Монгол улсын иргэдэд адилхан хамаарах бөгөөд Монгол улсын элсэж орсон олон улсын хуульд өөрөөр заагаагүй л бол, Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй эсвэл оршин сууж буй бүх олон улсын байгууллагууд болон гадаадын байгууллага ба иргэдэд мөн ижил хамаарна.

2.2 Монгол улсад хийгдэж буй байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

79. Дээр дурдсанчилан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу зохицуулж байдаг. Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ нь (БОНБУ-EIA) “Ерөнхий БОНБУ” болон “Нарийвчилсан БОНБУ” гэсэн хоёр алхмаас бүрддэг.
80. **Ерөнхий БОНБУ**-г (Хурдавчилсан дүн шинжилгээний үйл явц) төсөл хэрэгжүүлэхээс өмнө буюу төслийн төлөвлөлтийн үе шатанд хийх ёстой байдаг. Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад эсвэл аймаг болон Нийслэлийн засаг даргын тамгын газарт буюу энэ хуульд заасан хавсралтын дагуу ашиглах боломжтой аль нэг байгууллагад нь байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгүүлэх өргөдлөө өргөн барих ёстой бөгөөд үүнд, төслийнхөө товч танилцуулга, бодит байдалд хэрэгжих боломж, инженерийн зураг төсөл, санал болгож буй төслийн байгаль орчны тухай суурь мэдээлэл, холбогдох сум, дүүргийн засаг даргын бичгээр ирүүлсэн санал, бусад холбогдох баримт бичгийн өргөн барьдаг.
81. Шинээр эсвэл одоо байгаа аж үйлдвэр, үйлчилгээ эсвэл бүтэц байгууламж эсвэл өөр хэлбэрийн байгууламжийг барьж, сэргээн босгож, эсвэл өргөжүүлэхийн тулд байгалийн нөөцийг ашиглах гэж байгаа төсөлд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг хийдэг байна. Хүснэгт 5-д БОНБУ-ийн төслийн ангиллыг жагсаасан бөгөөд үнэлгээ хийх засгийн газрын түвшний үүрэг хариуцлагыг зааж өгсөн байдаг.
82. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг хийхийн дөрвөн байж болох үр дүн:
 - Шууд хэрэгжүүлэх төсөл: хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй жижиг төслүүд.
 - Байгаль орчны нөхцөл бүхий төслийг хэрэгжүүлэх: хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөө багатай төслүүд
 - Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан ерөнхий үнэлгээ хийх шаардлагатай: Хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөтэй, БОНБУ-ийн ерөнхий үнэлгээ хийх явцад сөрөг нөлөөллийг тогтоох боломжгүй ба илүү нарийвчилсан судалгаа явуулах хэрэгтэй төслүүд.
 - Хэрэгжүүлэх боломжгүй: Холбогдох эрх зүйн зохицуулалтанд нийцээгүй төслүүд, газрын менежментийн төлөвлөгөөнд авч үзээгүй, байгаль орчин, хүний эрүүл мэндэд хортой технологи бүхий төслүүд.

Хүснэгт 5 Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээнд хамаатай төслүүдийн ангилал

Төслийн ангиллууд	Хэрэгжүүлэх үүрэгтэй байгууллагууд	
	Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага	Аймаг, нийслэлийн Төрийн захиргааны байгууллага
Уул уурхай	Бүх төрлийн эрдэс баялгийн олборлолт	
Хүнд аж үйлдвэр	Бүх төрлүүд	Нийтлэг илэрц бүхий эрдэс баялгийг ашгийн бус зорилгоор орон нутгийн хэмжээнд олборлох
Хөнгөн болон хүнсний үйлдвэрлэл	Үндэсний ач холбогдолтой томоохон аж үйлдвэрүүд	Орон нутгийн жижиг дунд аж ахуйн нэгжүүд
Хөдөө аж ахуй	<ul style="list-style-type: none"> - усны нөөц - усжуулалтын систем - атар газрын тариалангийн үйл ажиллагаа 	<ul style="list-style-type: none"> - орон нутгийн ойн аж ахуйн төслүүд - ногоон орон зай, парк
Дэд бүтэц	<ul style="list-style-type: none"> - 1 МВт-аас дээш хүчин чадалтай цахилгаан станцууд - 35 кВт-аас дээш чадлын цахилгаан дамжуулагчид - дулаан дамжуулах шугамууд - усан цахилгаан станц - төмөр зам ба нисэх онгоцны буудал - улсын болон улс/хот хоорондын авто зам - улс/хот хоорондын харилцаа холбоо - газрын тосны нөөц 	<ul style="list-style-type: none"> - 1MW хүртэлх чадлын цахилгаан станц - 35 кВт хүртэл хүчин чадалтай цахилгаан дамжуулагч - орон нутгийн дулаан дамжуулах шугамууд - орон нутгийн зам, харилцаа холбоо - шатахуун түгээх станцууд
Үйлчилгээний салбарын төслүүд	<ul style="list-style-type: none"> - 50 гаруй хүний багтаамжтай зочид буудал, амралтын газар, сувиллын газар, бусад үйлчилгээ - аялал жуулчлал 	<ul style="list-style-type: none"> - 50 хүртэлх хүний багтаамжтай зочид буудал, амралтын газар, сувиллын газар болон бусад үйлчилгээ
Бусад	<ul style="list-style-type: none"> - хот байгуулалт - батлан хамгаалах, иргэний хамгаалалт - усан хангамжийн систем - ариун цэврийн байгууламж - хог хаягдлыг зайлуулах хэсэг - 10,000-аас дээш хүн амтай хот, төв суурин газруудад ус хангамж, ариутгах татуурга, бохир ус зайлуулах байгууламж - улсын чанартай батлан хамгаалах, иргэний хамгаалалтын байгууламж барих 	<ul style="list-style-type: none"> - 10,000 хүрэхгүй хүн амтай хот, төв суурин газрын усан хангамж, ариутгах татуурга, хог хаягдлыг зайлуулах байгууламж - орон нутгийн батлан хамгаалах, иргэний хамгаалалтын байгууламж барих

Биологийн олон янз байдал	- үндэсний хэмжээний загасны аж ахуй - амьтан, ургамлыг нөхөн сэргээх, ашиглах	- ан агнуур ба ойн аж ахуй - орон нутгийн хүн амыг тогтвортой байлгах загас агнуурын ажил
Генетикийн хувьд өөрчлөгдсөн организмтай холбоотой аж үйлдвэр	- генетикийн хувьд өөрчлөгдсөн организмыг тариалах - Ургуулж, тариалах - импорт ба хил дамнанас худалдаа	- генетикийн хувьд өөрчлөгдсөн организмын орон нутгийн тариалалт - генийн өөрчлөлттэй организм ашиглан ойн аж ахуй, нөхөн сэргээлт хийх жижиг дунд үйлдвэрлэл
Хортой болон цацраг идэвхт бодис, аюултай хог хаягдал	- боловсруулах, ашиглах, агуулах хадгалах, тээвэрлэх, устгах	-
Тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа	- улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хил орчмын болон нөөц газрын бүсэд үйл ажиллагаа	- орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа

83. Нарийвчилсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ - БОНБУ (БОНБУ ба EIS)

БОНБУ-ний үр дүнд тулгуурлан, уг төслийг дэмжигчдийг нарийвчилсан БОНБУ-г хийлгүүлэхээр чиглүүлж болох бөгөөд үүнийг эрх бүхий (эсвэл лицензтэй) байгаль орчны зөвлөх байгууллагууд хийж гүйцэтгэх шаардлагатай байдаг. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль нь нарийвчилсан БОНБУ-ний талаар тавигддаг шаардлагуудыг зааж өгсөн байдаг. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний салшгүй нэг хэсгийг бүрдүүлж байдаг.

2.3 Олон талт хэлэлцээрүүд болон Биологийн олон янз байдлын тухай протоколууд

84. Монгол улсын Засгийн газар нь хэд хэдэн олон улсын болон бүс нутгийн хэлэлцээрүүд болон конвенцуудад нэгдэн орсон байдаг нь байгаль орчинтой холбоотой байдаг. Үүнд:

- Нэгдсэн Үндэстний Байгууллагын (НҮБ) Хүнс хөдөө аж ахуйн байгууллагын дүрэм, 1973 он
- Дэлхийн цаг уурын байгууллагын 1947 оны конвенц
- Хүний эрхийн түгээмэл тунхаг 1948 он
- Боловсролд ялгаварлан гадуурхалтын эсрэг конвенц 1960 он
- Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай конвенц 1952 он
- Далайд гарцгүй орнуудын транзит худалдааны тухай конвенц 1965 он
- Биологийн олон янз байдлын тухай конвенц 1992 он
- НҮБ-ын цаг уурын өөрчлөлтийн тухай суурь конвенц 1992 он
- Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц, 1973 он
- Озоны давхаргыг хамгаалах тухай Венийн конвенц 1985 он
- Озоны давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн протокол 1987 он
- Озоны давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн протокол 1990 он
- Озоны давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн протокол 1992 он
- Ноцтой хуурайшилт ба / эсвэл цөлжилтийг даван туулж буй орнуудад цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенц 1994 онд
- Олон улсын ач холбогдол бүхий ус, чийг, намгархаг газар, ялангуяа усны шувуудын амьдрах таатай орны тухай Рамсарын конвенц 1971 он
- Гамшгийн хор хохирлыг бууруулах ба тусламжийн үйл ажиллагаанд зориулж цахилгаан холбооны эх үүсвэрээр хангах нөхцлийн тухай конвенц 1998 он
- НҮБ-ын цаг уурын өөрчлөлтийн тухай суурь конвенцийн Киотогийн протокол 1997 он
- Биологийн олон янз байдлын тухай конвенцийн Биоаюулгүй байдлын тухай Картагенагийн протокол 2000 он

2.4 ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН БҮТЭЦ, ХАМРАХ ХҮРЭЭ БОЛОН БОДЛОГОД ОРУУЛАХ ХУВЬД НЭМЭР



2.4.1 Монгол улсын хууль тогтоомж болон бодлогыг УАНС-гийн Хамгаалалтын стандарттай нийцүүлэх

2.4.1.1 Гүйцэтгэлийн стандарт 1: Байгаль орчин, нийгэмд үзүүлэх эрсдэл, нөлөөллийг үнэлэх, удирдан зохицуулах

85. Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг Үндсэн хуульд заасан. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай 1995 оны хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай 2011 оны хууль нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулж, экологийн хувьд тэнцвэртэй, нийгэм нийгэм ба эдийн засгийн хөгжил, өнөө цагт болон ирээдүйд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах, байгаа байгалийн нөөцийг нөхөн сэргээхийн тулд, төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын хооронд үүсэх харилцааг зохицуулж байдаг. Байгаль орчны тухай хууль нь байгаль орчны гүйцэтгэлийн зорилго, зарчмуудаас гадна, байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийн эрсдэл болон төслийн нөлөөллийг олж тогтоох үйл явцыг зааж өгсөн байдаг.

2.4.1.2 Гүйцэтгэлийн стандарт 2: Хөдөлмөрлөх болон ажиллах нөхцөл

86. Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль нь 1999 оны (2015 оны) Хөдөлмөр эрхлэлтийн тухай төрөлжүүлэн нэгтгэсэн хуулинд хамрагдсан. Хөдөлмөрийн тухай хуулинд хуучин ЗХУ-ын тогтолцоо ихээхэн нөлөөлсөн байдаг бөгөөд энэ нь ажилчдад маш ээлтэй ханддаг гэдгээрээ алдартай.

87. УАНС-гийн Стандарт 2-ын шаардлагуудыг Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль хангасан байдаг.

2.4.1.3 Гүйцэтгэлийн стандарт 3: Байгалийн нөөцийн үр ашиг болон бохирдлоос урьдчилан сэргийлэх

88. Гүйцэтгэлийн стандарт 3-ыг хангахад туслах олон тооны харилцан хамааралтай хууль байдаг ба үүнд Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль (дээр дурдсан), Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль, Усны тухай хууль, Ойн тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль. Мөн Монгол улсын Тогтвортой хөгжлийн алсын хараа 2030 хамааралтай.

89. Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль тогтоомж нь Монгол улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Тусгай зөвшөөрлийн тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлохыг хориглох тухай хууль, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэнд хяналт тавих тухай хууль, Онцгой нөхцөл байдал үүсэхээс хамгаалах тухай хуулиудаас бүрэлддэг.

90. Ахуйн болон аж үйлдвэрийн хаягдлын тухай хууль нь ахуйн болон аж үйлдвэрийн хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, агуулах, газарт булшлах асуудлаас гадна хог хаягдлыг түүхий эд материалын эх үүсвэр болгон дахин ашиглах зэрэг асуудлыг хамардаг. Ахуйн болон аж үйлдвэрийн хаягдлын тухай хууль нь Монгол улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, энэ хууль болон үүнтэй нийцэх бусад батлагдсан хууль тогтоомжуудын актаас бүрэлдэх ёстой.

2.4.1.4 Гүйцэтгэлийн стандарт 4: Нутгийн ард иргэдийн эрүүл мэнд, найдвартай, аюулгүй байдал

91. Үндсэн хууль (Бүлэг 2) – Хүний эрх, эрх чөлөө, Монгол улсын иргэд ажиллах зохистой орчин нөхцөл, эрүүл мэндийн хамгаалалт, эмнэлгийн тусламж үйлчилгээ, өндөр настай болох, тахир дутуу болох, хүүхэд төрүүлэх, хүүхэд асран хүмүүжүүлэхэд эд материалын болон санхүүгийн дэмжлэг авах эрх эдлэх ёстой байдаг.

92. Дараах хууль болон дагаж мөрдөж буй хууль тогтоомжийн актууд нь Ажил, мэргэжлийн эрүүл ахуй, аюулгүй байдлын (OSH) асуудлыг хамаарна: Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай



GREEN
CLIMATE
FUND

Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ

хууль, Төрийн аудитын тухай Монгол улсын хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Засгийн газрын 37-р тогтоолын дагуу, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, (Specialized Professional Inspection Agency – SPIA) (тодорхой этгээдэд хамаарах, хуулиас ялгагдах) 2003 оны Ерөнхий хууль.

93. Монгол улс нь 1999 онд Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн конвенцийг баталсан.

2.4.1.5 Гүйцэтгэлийн стандарт 5: Газар чөлөөлөх болон Сайн дурын бус үндсэн дээр нүүлгэн суурьшуулах

94. Газрын тухай хуулинд (2002) засгийн газрын бүрэн эрх, түүний дотор газрыг чөлөөлөх болон нөхөн олговрын үйл явцыг тусгасан. Түүнчлэн уг хуульд газар ашиглагч / эзэмшигчийн эрхийг нарийвчлан тусгасан болно. Мөн а) шинэ хууль тогтоомж болон эрх зүйн зохицуулалтууд (Захиргааны ерөнхий хууль) гарсантай холбоотойгоор, б) гомдол, нэхэмжлэл гарсан тохиолдолд шийдвэрлэх журам байх ёстой зэрэг асуудлын талаар, нөлөөлөлд өртсөн нутгийн ард иргэдтэй зөвлөлдөх шаардлагын талаар зааж өгсөн байдаг.
95. Газрын тухай хууль (иргэд, аж ахуйн нэгж/хуулийн этгээд, байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг болон бусад холбогдох асуудлыг зохицуулж байдаг). Газрыг зөвхөн Монгол улсын иргэд өмчилж болно. Газрын тухай хууль нь газартай холбоотой гурван төрлийн эрхийг ялгаж тодорхойлсон байдаг, үүнд: “газар өмчлөгч”, “газар эзэмшигч”, “газар ашиглагч”. Газар ашиглах болон эзэмшихээс өөр эрх болох газар өмчлөгч гэдэгт уг газрыг захиран зарцуулах эрхийг хамруулсан байдаг.
96. Ялангуяа бэлчээртэй холбоотойгоор 54.2-р Зүйлд “зуны бэлчээр болон намаржааны бэлчээрийг баг, хот айлуудад хуваарилж, нийтээр эзэмшинэ” гэж заасан байдаг. Энэ нь төрийн өмчлөлд байгаа боловч хувь хүн болон эдийн засгийн зорилготой хуулийн этгээдүүд өмчлөөгүй эсвэл эзэмшээгүй, засгийн газраас тусгай хэрэгцээнд нөөцлөөгүй аливаа газар бол “нийтийн өмчийн эдэлбэр газар” бөгөөд уг газрын байршиж буй харъяа нутаг дэвсгэрт оршин суугчтай хамтран ашиглах боломжтой гэсэн утгатай. 6.2-р Зүйлийн дагуу, эзэмшиж байгаа эсвэл ашиглаж байгаагаас үл хамааран дараах төрлийн газрыг засгийн газрын эрх зүйн зохицуулалтын хүрээнд нийтийн эзэмшлийн зорилгоор ашиглах ёстой байдаг: 1) бэлчээр, бэлчээрийн уст цэг, худаг, хужир мараа; 2) хот, тосгон болон бусад суурин газрын нийтийн эзэмшлийн газар; 3) авто зам болон дэд бүтцийн сүлжээний дагуух газар; 4) ойн сан бүхий газар; 5) усны нөөц сан бүхий газар. Эдгээр нөхцлүүд нь эдгээр нэн чухал байгалийн нөөцийн малчдад хүртэх эрхийг хамгаалж байдаг.
97. Гуравдугаар бүлэг нь газрын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянаж ажиллах, өөрийн нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын менежментийн төлөвлөгөөг батлах, иргэн, аж ахуйн нэгжид ашиглагдаагүй улсын газрыг тусгай хэрэгцээнд авах зэрэг сумын засаг захиргааны эрхүүдийг зааж өгсөн байдаг. Сумын засаг захиргаа нь “орон нутгийн газрыг ашиглагч болон эзэмшигч нь тэдгээр газрын болон газрын нөөцийг үр ашигтай, зохистой ашиглаж байгаа эсэх, мөн тэд нар хууль болон гэрээний дагуу газрыг хамгаалж байгаа эсэх, тэдгээрийн дунд үүссэн маргааныг шийдвэрлэх шийдвэр гаргах, тэдгээр шийдвэрийг сахиулах ажлыг зохион байгуулж ажиллах” бүрэн эрхтэй байдаг бөгөөд иргэдийн газар эзэмших ба ашиглах талаар шийдвэр гаргах, газрыг эзэмшигч, ашиглагч нараас газрын төлбөр хурааж авах эрхтэй байдаг.
98. Тавдугаар бүлэгт, газар эзэмших, ашиглах эрхийг хэрхэн яаж олгох, газар эзэмших, ашиглах хүсэлт гаргах, авах нөхцлийг тусгасан болно. Ялангуяа Нэгдүгээр бүлэгт, газрын тухай хууль нь ямар ч нөхцөлд газрыг өмчлүүлэх эрхийг олгохгүй гэдгийг зааж өгсөн байдаг. Зөвхөн газрыг эзэмших, ашиглах эрхийн тухай л яригддаг. Хуульд газар эзэмших эрхийн өргөдөл гаргах журмыг тодорхой заасан байдаг. Газар эзэмших, шилжүүлэхтэй холбоотой эрх, үүргийг мөн тодорхой бичжээ.
99. 54.10-р Зүйлд бэлчээр ашиглахтай холбоотой маргааныг газар ашиглалтын уламжлалт арга туршлага болон малчдын ёс заншилд тулгуурлан Багийн иргэдийн нийтийн хурлаар авч хэлэлцэн, шийдвэрлэх ёстой талаар зааж тусгасан байдаг. Хэрэв тохиролцоонд хүрч чадахгүй бол асуудлыг сумдын Засаг дарга нар шийдвэрлэнэ.
100. 63 дугаар зүйлд газрын маргааныг шийдвэрлэх үйл явцыг тодорхойлж, газарт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд торгууль ногдуулах тухай тусгасан. Ерөнхийдөө талууд өөрсдөө шийдэж чадахгүй байгаа маргааныг засгийн газрын дараагийн дээд түвшинд; багуудын хоорондох маргааныг сумын Засаг даргын түвшинд, сумын Засаг дарга нарын хооронд үүссэн маргааныг аймгийн Засаг дарга гэх мэтээр шийдвэрлэнэ гэж заасан байдаг.

101. Санал болгож буй Монгол улсын Бэлчээрийн тухай хууль нь зөвхөн малчдын бүлэг өвөл, хаврын бэлчээрийг эзэмших эрхийг олгохоор мөн эзэмшилтэй холбоотой нөхцлүүд, эрх, үүрэг хариуцлагуудыг зааж өгсөн болно.

2.4.1.6 Гүйцэтгэлийн стандарт 6: Биологийн олон янз байдлыг хадгалан хамгаалах, амьд байгалийн нөөцийн тогтвортой менежмент

102. Энэхүү стандартыг хэд хэдэн хууль, дээр дурдсан Байгаль орчныг хамгаалах тухай хууль, түүнчлэн Усны тухай хууль, Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Ойн тухай хууль, Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн тухай хууль, Байгалийн ургамлын тухай хууль (энэ хууль нь ой болон таримал ургамлаас өөр бусад байгалийн ургамлыг хамгаалж, зүй зохистой ашиглаж, нөхөн сэргээх үйл ажиллагааг зохицуулдаг) зэргийг хэрэгжүүлэх замаар хангаж байна.

103. Ойн тухай хууль нь (2012) ойн газрын ангилал болон түүний хүрээнд ямар үйл ажиллагаа явуулж болохыг тогтоожээ. 5 дугаар зүйлд Ойн нөөцийн ангилал, ойн нөөц бүхий газрын ашиглалт хамгаалалтын хэлбэрүүдэд үндэслэн, экологийн болон эдийн засгийн үнэ цэнийг тогтоодог, ойн нөөцийг 5.1.1-ийн Хамгаалалтанд авсан ойн бүс болон 5.1.2-д заасан Арилжааны зорилгоор ашиглах ойн бүс/эсвэл ойн ашиглалтын бүсийн дагуу ангилдаг.

104. Ойн тухай хууль болон Газрын тухай хуульд заасны дагуу ойн сан бүхий газарт бэлчээрлэхтэй холбоотой зөрчил үүсч болзошгүй. Ойн тухай хууль (2012), 29 дүгээр зүйлийн 29.1.5 дахь заалтад "Ой мод бүхий газарт, үрсэлгээ суулгасан тариалангийн газар, эсвэл эдгээр үйл ажиллагаанд зориулсан газарт мод бэлтгэх эсвэл бэлчээрлүүлэхийг хориглоно" хэмээн заасан байдаг. Гэсэн хэдий ч Газрын тухай хууль (2002), 52 дугаар зүйлийн 52.3 дахь хэсэгт ойн нөөц газрыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бэлчээрийн зориулалтаар ашиглаж болно гэж заасан байдаг. Бүрэн ургаж гүйцээгүй байгаа ойн бүсэд бэлчээрлүүлэхийг зөвшөөрөхгүй гэдгийг тодорхой болгохын тулд энэ хоёр хуулийн хоёуланд нь нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгтэй.

105. Газрын тухай хуульд, төрийн тусгай хамгаалалтад байгаа газар болон байгаль орчны болон цаг агаарын байнгын ажиглалтад зориулагдсан ердийн газруулыг хамруулдаг "тусгай хэрэгцээнд зориулагдсан газар"-т зориулсан нөхцлүүдийг хамруулсан байдаг. Мөн тусгай хамгаалалттай газар нутгийн газрыг ашиглах ба хамгаалалтанд авах болон байгалийн бүс бүслүүрийн онцгой шинж чанарыг хэвээр нь хадгалан авч үлдэхийн тулд байгалийн газрын төрх байдал, тэдний онцгой бүрдэл, ховор болон нэн ховор ургамал, амьтны зүйл, түүхэн, соёлын дурсгалт газар, байгалийн үзэсгэлэнт газруудыг хадгалан хамгаалах, мөн тэдний хувьслыг судалж, тогтоохтой холбоотой харилцааг зохицуулах зорилготой Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль гэж нэртэй тусдаа хууль байдаг.

2.4.1.7 Гүйцэтгэлийн стандарт 7: Нутгийн уугуул ард иргэд

106. Монгол улсад угсаатан ястны цөөнхийн хувьд санаа зовоосон асуудлуудтай холбоотой ямар нэгэн тодорхой хууль тогтоомж байдаггүй. Үндэстэн ястны цөөнхийн эрхийг Монгол улсын Үндсэн хуульд баталгаажуулан: "ямар ч хүнийг угсаатан ястны гарал үүсэл, хэл, арьс өнгө, нас, хүйс, нийгмийн гарал үүсэл эсвэл статус, мэргэжил эсвэл албан тушаал, шашин, үзэл бодол, эсвэл боловсролд тулгуурлан ялгаварлан гадуурхаж болохгүй" хэмээн заасан байдаг.

107. Хөдөлмөрийн тухай хууль (7.1-р Зүйл) Эрүүгийн хууль (5.1-р Зүйл) зэрэг Монгол улсад цөөхөн хэдэн хуульд, жишээ нь угсаатан ястны бүлгийн дунд эрх тэгш байдлыг баталгаажуулсан байдаг.

108. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль нь (2016) зарим талаар өөртөө засан тогтнох зарчмыг дэмждэг ба, уг асуудал нь хэм хэмжээний/норматив актаар хязгаарлагдана хэмээн зааж – хэм хэмжээний актын түвшинд ямар нэгэн шийдвэр гаргахаас өмнө шүүхээр хянан шийдвэрлүүлэх ёстой гэж заасан байдаг. Үүнд мөн шинэ хууль тогтоомж болон эрх зүйн зохицуулалтуудын талаар зөвлөлдөх явцад урьдчилан мэдэгдэл гаргах, мэдээллийг нээлттэй болгох, гомдлыг шийдвэрлэх арга замыг бүрдүүлсэн байх ёстой гэдгийг үүрэгжүүлэн зааж өгсөн байдаг.

109. Хүний эрхийг хэрэгжүүлэх Үндэсний хөтөлбөрийн 2.4.3.5-д мэдэгдсэнээр бол "Төр угсаатны цөөнхийн өөрсдийн эх хэлээр боловсрол эзэмших эрхийг хангах нөхцлийг бүрдүүлнэ" гэсэн байдаг боловч, Монгол хэлээр ярьдаггүй цөөнхөд таатай нөхцөл олгохгүйгээр орхигдуулж – цөөнхийн хэлээр хангалттай хэмжээнд сургаж бэлтгээгүй багш нартай, цөөнхийн хэлээр боловсруулсан сурах бичиг, сургалтын материал хомсдолтой, цөөнхөд төвлөрсөн үр дүнтэй боловсролын бодлого байхгүй зэрэг байдлаар үүнийг хэрэгжүүлж иржээ.

110. Монгол улсын Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд үндэстний цөөнх угсаатнууд руу чиглэсэн редакцийн програм хангамж шаардлагатай байгаа тухай хэсгийг оруулсан боловч энэ хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.
111. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн (2011) 11-р Зүйлд, иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хүлээж авахтай холбоотой эрхийг заасан байдаг.
112. Монгол улс нь, “Нутгийн уугуул болон овгийн тогтолцоотой хүмүүсийн” эрх зүйн статусыг хүлээн зөвшөөрдөг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 169-р Конвенцийг (ILO 169) үзэглэсэн тал биш юм.
113. НҮБХХ-ийн Нийгэм ба байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хурдавчилсан дүн шинжилгээ (SESP) нь уг төсөлд хамаарна мөн НҮБХХ-ийн Нийгэм ба байгаль орчны стандарт хэм хэмжээ 6: Нутгийн уугуул иргэд нь нутгийн уугуул иргэд, тэдний эрх, газар нутаг, нутаг дэвсгэр, байгалийн нөөц баялагт үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийсэн механизмийг хангаж өгдөг.

2.4.1.8 Гүйцэтгэлийн стандарт 8: Соёлын өв

114. Монгол улсын Үндсэн хуулийн 7-р Зүйл нь түүхэн, соёлын, шинжлэх ухааны болон оюуны өв соёлыг Төрийн хамгаалалтанд оруулсан байдаг.
115. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд (1994) байгалийн дурсгалт газар (тухайлбал, өвөрмөц тогтоц ба илэрц, хүрхрээ, хад, хавцал, агуй хад, гэх мэт) болон түүхэн ба соёлын дурсгалт газруудыг (жишээлбэл эртний хүмүүсийн оромж байр, агуй, агуйн зураг, хадны бичээс, хөшөө дурсгал, булш, балгас, хана, цайз, суваг, далан, эртний уурхай, уламжлалт зан үйлтэй холбоотой уулс, шүтлэгтэй эсвэл түүхэн дурсгалт газрууд) хамгаалах арга хэмжээг багтаасан байдаг. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994), Орчны бүсийн тухай хуулийн (1997) хэд хэдэн заалтууд нь хамгаалалттай газар нутгийн хил хязгаар дотор болон түүний ойр орчмын уламжлалт амьдралын хэв маягтай холбоотой байдаг. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт: “Орчны бүсийн тухай хууль нь уламжлалт амьдралын хэв маягт үзүүлэх дарамтаас урьчилан сэргийлэх мөн уламжлалаа хамгаалж авч үлдэх зорилготой (соёлын уламжлалд нөлөөлөх байдлаар өргөжиж буй тусгай хамгаалалттай газар нутгийн эрсдлийг арилгахтай холбоотой).”
116. Байгаль орчин ба аялал жуулчлалын яам нь Малын генетик нөөцийн тухай хуулийг боловсруулах ажлыг хийж байна.

3 ХЭРЭГЖҮҮЛЭЛТ БОЛОН АШИГЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 МЕНЕЖМЕНТИЙН ЕРӨНХИЙ БҮТЭЦ БОЛОН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

117. Төслийн удирдах зөвлөл нь хэрэгжүүлэгч болон хариуцлагатай талуудаас бүрдэнэ. Энэхүү төслийн хэрэгжүүлэгч түнш бол БОАЖЯ юм (МЕТ). БОАЖЯ нь төслийн удирдан зохион байгуулах, үүнд төслийн хөндлөнгийн оролцооны хяналт, шинжилгээ болон үнэлгээ, төслийг үр дүнд хүргэх, НҮБХХ-ийн эх үүсвэрүүдийг үр дүнтэй ашиглах тал дээр НҮБХХ-т хариуцлага хүлээдэг.
118. БОАЖЯ нь хэрэгжүүлэгч бусад түншүүд болон хамтран санхүүжүүлэх байгууллагуудтай төслийн үр дүнг амжилттай хүргэхэд туслах зорилгоор гэрээ байгуулна. Эдгээр байгууллагууд гэрээний нөхцөлд заасны дагуу БОАЖЯ -нд шууд хариуцлага хүлээх болно. Ус, цаг уур, орчны шинжилгээний газар нь (НАМЕМ) БОАЖЯ-ны агентлаг гэдэг утгаараа Гарц бүтээгдэхүүн 1-ийг БОАЖЯ шууд хэрэгжүүлэх юм. БОАЖЯ-тай байгуулсан гэрээний дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь Гарц бүтээгдэхүүн 2-ийг хэрэгжүүлнэ. Яам тус бүр аймгийн түвшний хэлтэс болон сумын түвшний төлөөлөгчдийг дайчлан ажиллах болно.
119. Өндөр түвшний Төслийн менежментийн бүтэц тогтолцоог Зураг 2-рт харуулсан байна. Гол үүрэг хариуцлагуудыг доор харуулсан байгаа.



Зураг 2 Төслийн зохион байгуулалтын бүтэц тогтолцоо

3.1.1 Төслийн удирдах хороо болон Дэд хороо

120. Төслийн удирдах хороо нь төслийн талаархи шийдвэр гаргах, зохицуулах дээд байгууллага болох бөгөөд жил бүр хоёр удаа тогтмол хуралдана. Үүнийг БОАЖЯ, НҮБХХ хамтран Газрын дарга, Улс хариуцсан захирлаар удирдуулна. ХХААХҮЯ-ны Ахлах түвшний төлөөлөгч нь байнгын гишүүн байна. НҮБХХ-ийн Ахлах техникийн зөвлөх нь ажиглагчийн үүрэгтэй оролцоно. Ахлах түвшний, төслийн үр ашиг хүртэгч, хэрэгжүүлэгч түнш нь уг Зөвлөлийн нэг хэсэг нь байна. Цаашилбал, НҮБХХ нь төслийн ахлах ханган нийлүүлэгчийн хувьд төслийн чанарын баталгааг хангаж, Үндэсний түвшний хэрэгжилтийн зарчмыг (National Implementation Modality –NIM) удирдамжийг дагаж мөрдөх, УАНС, НҮБХХ-ийн бодлого, журамд нийцүүлэх нөхцлийг хангаж ажилладаг. Төслийн Удирдах хороо нь Ахлах техникийн зөвлөх (Chief Technical Advisor–СТА) болон Төслийн захирлуудад зааварчилгаа хэрэгтэй болсон тохиолдолд, зөвшилцөлд тулгуурлан менежментийн шийдвэр гаргах үүрэг хариуцлагатай. Төслийн зөвлөлийн шийдвэрийг хөгжлийн үр дүнг удирдан зохицуулах, мөнгөн зарцуулалтын хамгийн үр дүнтэй үнэ цэнийг бүтээх, шударга ёс, шударга байдал, ил тод байдал, олон улсад үр дүнтэй өрсөлдөх нөхцлийг хангасан стандартын дагуу гаргана. Удирдах хорооны хүрээнд зөвшилцөлд хүрч чадахгүй бол эцсийн шийдвэрийг НҮБХХ (НҮБХХ-ийн Улс хариуцсан захирлаар төлөөлүүлэн) гаргах болно.

121. Төслийн Удирдах хорооны тодорхой үүрэг:

- Удирдах хороо нь стратегийн чиглэлийг тодорхойлж, хөтөлбөрийг удирдах засгийн газрын манлайллыг бэхжүүлж, бүх хөндлөнгийн оролцоог уялдуулан зохицуулна;
- Тодорхой эрсдлийг арилгах чиглэлээр удирдамж өгч, болзошгүй хариу арга хэмжээ / менежментийн арга хэмжээ авах чиглэлээр тохиролцох;
- Жилийн ажлын төлөвлөгөөг батлах (НҮБХХ-ээр батлуулахаас өмнө);
- Төслийн явцыг хянах зорилгоор жил бүр хоёр удаа уулзалт зохион байгуулж, батлагдсан жилийн ажлын төлөвлөгөөний дагуу тохиролцсон гүйцэтгэх ажлын үр дүнг хангалттай түвшинд гаргаж өгөх чиглэл, зөвлөмжүүдийг гаргаж өгөх;
- Төслийн менежер шийдвэр гаргах боломжгүй байгаа тохиолдолд тухайн үед нь зааварчилгаа өгөх;
- Хөтөлбөрийн зорилго, ажлын төлөвлөгөө, санхүүжилтийн бэлэн байдлыг харгалзан хөтөлбөрөөр дэмжигдсэн бүх үйл ажиллагааг хянаж, батлах;



GREEN
CLIMATE
FUND

Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ

- Хөтөлбөрийг дэмжиж буй үйл ажиллагаа, бодлогын хоорондох уялдаа холбоо, жигд байдлыг бий болгох техникийн зөвлөгөө өгөх;
- Салбарын түвшинд хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэх ажилд удирдамж өгч, дэмжлэг үзүүлэх;
- Хөтөлбөрийн санхүүжилтийн цоорхойг дэмжих зорилгоор эх үүсвэрийг дайчлахад дэмжлэг үзүүлэх;
- Тогтмол уулзалт хийж, хаяа газар дээр нь очиж үзэх замаар хөтөлбөрийн үйл ажиллагаанд нь хяналт, шинжилгээ үнэлгээ хийх;
- Хөтөлбөрийн хүрээнд дэмжигдсэн бүхий л үйл ажиллагаа тус бүрээр тайлан хүлээн авч, хөтөлбөрийн гүйцэтгэл болон үр дүнг үнэлж, хяналт шинжилгээ хийх нэмэлт үндэслэл болгон ашиглах;

3.1.2 Үндэсний төслийн менежментийн нэгж

122. Төслийн үндэсний зохицуулагч нь (ТҮЗ-NPC) Төслийн менежментийн нэгжийг удирдан, Төслийн Удирдах хорооны гаргаж өгсөн цар хүрээнд, НҮБХХ болон БОАЖЯ-ны өмнөөс өдөр бүр төслийг гүйцэтгэн хэрэгжүүлнэ. УАНС болон НҮБХХ-ийн зүгээс шаарддаг төслийн эцсийн үнэлгээний тайлан болон бусад баримт бичгүүдийг боловсруулан дуусгаж, НҮБХХ-т хүргүүлснээр ТҮЗ (NPC) үйл ажиллагаа дуусгавар болно.
123. Тэрээр төслийг өдөр тутмын удирдлагаар хангаж, шийдвэр гаргах үүрэгтэй бөгөөд төслийн баримт бичигт заасан үр дүнг, шаардлагатай чанарын стандарт, заасан хугацаа болон төсвийн хүрээнд гаргаж өгөх үүрэгтэй. Жилийн ажлын төлөвлөгөөг ТҮЗ боловсруулж, Төслийн удирдах хороогоор хянан баталдаг. Гэвч эцсийн зөвшөөрлийг чанарын баталгаажуулалтын үүргийн нэг хэсэг нь болсон Бүсийн техникийн зөвлөх, НҮБХХ-ийн Даян дэлхийн байгаль орчны сангийн нэгж хийдэг. Төслийн менежер нь анх тодорхойлсон төслийн эрсдэлүүдийг удирдан зохицуулж, хяналт шинжилгээ явуулах үүрэгтэй бөгөөд шинээр гарсан эрсдлийн талаар төслийн удирдах хороонд хэлэлцүүлж, шаардлагатай тохиолдолд боломжит шийдвэр гаргуулахаар өргөн барих бөгөөд Үндэсний түвшний хэрэгжилтийн зарчмын (NIM) Зааварчилгааны дагуу төслийн эрсдлийн бүртгэлд бүртгэн хөтлөх замаар эдгээр эрсдлийн төлөв байдлын мэдээллийг шинэчилж байна.
124. Төслийг Төслийн удирдах хорооноос баталсан ажлын төлөвлөгөөний дагуу Төслийн менежментийн нэгж (ТМН-PMU) хэрэгжүүлнэ. Төслийн менежментийн нэгж нь ТМН нь БОАЖЯ, ХХААХҮЯ, НҮБХХ-тай холбогдсон төслийн хоёр захиралтай байх бөгөөд Гарц бүтээгдэхүүн 1, Гарц бүтээгдэхүүн 2 ба 3-ыг тус бүр хэрэгжүүлэхэд хяналт тавих үүрэг хүлээсэн болно. Тэд өөрсдийн холбогдох яамдууд болон бусад түнш байгууллагуудаасаа төсөл хэрэгжүүлэхэд үзүүлэх дэмжлэгийг дайчлан, уялдаа холбоог хангаж, төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай байгаа салбар хоорондын уялдаа холбоог удирдан зохицуулж ажиллах болно. Дээр нь нэмээд тус төсөл нь үндсэн ажилтнууддаа дараах үүргийг хариуцуулна, үүнд: аюулгүй байдлыг хангах, хүйсийн тэгш байдал, харилцаа холбоо, хяналт шинжилгээ, сургалт, санхүү, худалдан авалт, захиргааны дэмжлэг гэх мэт. Бүрэн боловсон хүчинтэй болсон үед, ТМН-ийн үндсэн ажилтнууд болон дэмжих ажилтнуудын нийт тоо нь ойролцоогоор хорин ширхэг байна. Дээр нь нэмээд ТМН-нь шаардлагатай тохиолдолд зөвлөх авч ажиллуулна.
125. ТМН-ийн аймгийн түвшинд өргөжүүлэн ажиллахад дөрвөн ширхэг Төслийн зохицуулалтын оффисуудыг (ТЗО-PCUs) байгуулах болно. Эдгээр оффисууд нь төслийн хэрэгжилтийг газар дээр нь хэрэгжүүлэх ажлыг хариуцаж ажиллах болно. ТЗО тус бүрийг нэг зохицуулагч удирдах бөгөөд аймаг орон нутгийн БНАБ-үүд болон БАГ-үүдийг дэмжиж ажиллах чиглэлээр сургагдсан багаас бүрдэх ба тус баг нь Малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэгч малчдын байгууллагыг (ҮМБ-НРОs) байгуулж, зах зээлийг хүртээмжийг сайжруулах чиглэлээр сургагдсан байна. Инженер эсвэл техникийн мэргэжилтэнг ажилд авч Гар бүтээгдэхүүн 2-ийн дагуу боловсруулж, дэд бүтэц байгуулах ажлыг гүйцэтгэнэ. Дээр нь нэмээд ТЗО-ууд нь худалдан авалт болон захиргааны дэмжлэг үзүүлж ажиллана.

3.2 Төслийн гүйцэтгэлийн ажил ба Удирдлага

3.2.1 Төслийн гүйцэтгэлийн ажил

126. Төслийг газар дээр нь БОАЖЯ болон ХХААХҮЯ болон тэдний харъяа газруудаар дамжуулан хэрэгжүүлнэ. Дээр нь НҮБХХ-ийн хувьд атоллын зөвлөлүүд, одоогоор байгаа ТББ-ууд, нутгийн ард иргэдтэй хамтран ажиллана гэсэн хүсэн хүлээлт байгаа.



3.2.2 Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийн менежментийн бүтэц, хамрах хүрээний удирдлага (БОНҮНМБХХ - EMSF)



127. Хэрэгжүүлэгч агентлагийн хувьд БОАЖЯ болон ХХААХҮЯ нь ажлыг гүйцэтгэгч байгууллагуудаар дамжуулан БОНҮНМБХХ-нд хэрэгжүүлэх үүрэг хариуцлагатай байх болно.
128. БОНҮНМБХХ нь аливаа тендерийн баримт бичгийн нэг хэсэг болно. Ажлын явцад БОАЖЯ болон ХХААХҮЯ нь энэхүү баримт бичгийг хянан засварлаж, шинэчилж байх үүрэгтэй байх болно. Энэхүү баримт бичгийг хүлээлгэн өгсөн хүний хувьд үүнийг хамгийн сүүлийн үеийн байдлаар шинэчилж ажиллах үүрэгтэй.
129. НҮБХХ, БОАЖЯ, ХХААХҮЯ нь байгаль орчин болон нийгмийн асуудлаар гаргасан мэргэжилтний зөвлөгөөг ажлыг гардан хэрэгжүүлэгч байгууллагуудад (ж нь гэрээлэгчид ба/эсвэл ТББ-уудад) хүргэж мөн байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийн хяналт шинжилгээ хийх болон тайлагнах нөхцлийн хүрээнд үүрэг хариуцлагатай. БОАЖЯ болон ХХААХҮЯ эсвэл түүний төлөөлөгчид нь төслийн явцад бүрэлдэхүүн тус бүрийг хариуцаж ажиллаж байгаа ажил гүйцэтгэгч байгууллагуудын (ж нь гэрээлэгчид) байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийг үнэлэх бөгөөд БОНҮНМБХХ-ийг мөрдөж ажиллах нөхцлийг хангаж ажиллана. Төсөл хэрэгжүүлж байх ашиглалтын үйл явцад ажил гүйцэтгэгч байгууллагууд нь БОНҮНМБХХ-ийг хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээж ажиллана. Төсөлд ажиллаж байгаа боловсон хүчин нь байгаль орчин болон нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлж эсвэл бууруулж ажиллах үүрэг хүлээнэ.
130. Хээрийн ажилтан/нуудыг томилох бөгөөд тэд төсөл/барилгын талбайд өдөр бүр байгаль орчны хяналт шалгалт хийж байх үүрэг хариуцлагатай. БОАЖЯ болон ХХААХҮЯ эсвэл тэдгээрийн төлөөлөгчид нь сар бүх аудит хийх замаар эдгээр хяналт шалгалтыг хөндлөнгөөс шалгаж байх болно.
131. Ажил гүйцэтгэгч байгууллага, жишээлбэл гэрээлэгч нь захиргааны болон байгаль орчны талаархи бүх бүртгэлийг хөтлөнө. Үүнд гомдлын бүртгэл, гомдлын шалтгааныг багасгах талаар авсан аливаа арга хэмжээний тэмдэглэл орно.
132. Ажил гүйцэтгэгч байгууллага нь БОНҮНМБХХ-ийг өдөр бүх мөрдөж ажиллах үүрэг хариуцлага хүлээнэ.

3.2.3 Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохион байгуулах (менежментийн) төлөвлөгөө (БОНҮНМТ-ESMPs), Байгаль орчны журам, тухайн газар ба үйл ажиллагаанд чиглэсэн ажлын төлөвлөгөө/зааварчилгаа

133. БОНҮНМБХХ нь хүрээлэн буй орчин, нийгмийн сэдэвчилсэн асуудлуудыг хамарсан нийтлэг зорилт тавьдаг. Дэд төслийн эрсдлийг хурдавчилсан байдлаар дүн шинжилсэний үндсэн дээр төслийн тухайн газартай холбоотой БОНҮНМТ (эсвэл тухайн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны журам эсвэл ажлын төлөвлөгөө) хийх шаардлагатай болж болох юм. Байгаль орчны журам нь хүрээлэн буй орчны тодорхой бүрэлдэхүүн хэсгийн менежментийн зорилтыг хэрхэн биелүүлэх тухай бичиж боловсруулсан аргаар хангадаг. Үүнд төслийн тухай газар эсвэл үйл ажиллагаатай холбоотой шаардлагатай нарийвчилсан мэдээллийг агуулсан байдаг бөгөөд эдгээрийг бүх барилгын ажилд баримтлах шаардлагатай байдаг. Талбай, үйл ажиллагаатай холбоотой ажлын төлөвлөгөө, заавар гаргах бөгөөд НҮБХХ, IFAD, Швейцарийн хөгжлийн хамтын ажиллагааны ижил төстэй төслүүдийн өмнө хийж байсан амжилттай ажлыг мөрдөж ажиллана.
134. БОНҮНМТ болон/эсвэл байгаль орчны журмын эрэлт хэрэгцээ нь дэд үйл ажиллагаа, оролцогч талуудын оролцооны үр дүн дээр суурилсан байх ёстой (холбогдох оролцогч тал болзошгүй эрсдлийг тодорхойлох, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг боловсруулахад гол үүрэг гүйцэтгэдэг). БОНҮНМТ-нд зориулсан үзүүлэлтүүдийн тоймыг Хавсралт 2-т харуулсан байгаа. БОНҮНМТ-ийг БОНҮНМБХХ-нд аль хэдийнээ тодорхойлсон асуудал/үйл ажиллагаануудад тулгуурлан гаргаж болох бөгөөд үүн дээр нь нэмээд төслийн тухайн газар эсвэл үйл ажиллагаатай холбоотой болгож өгдөг.
135. Байгаль орчны журам, төслийн тухайн газар, үйл ажиллагаатай холбоотой тодорхой ажлын төлөвлөгөөг БОАЖЯ эсвэл түүний төлөөлөгч (гүйцэтгэгчийг оролцуулан) боловсруулж болох боловч тухайн газар дээр ажил эхлэхээс өмнө БОАЖЯ-аар батлуулсан байх ёстой.

3.2.4 Байгаль орчинд учирсан хэрэг, ослын талаар тайлагнах

136. БОНҮНМБХХ-ний журмыг дагаж мөрдөхгүй байх зэрэг аливаа хэрэг, ослыг Хохирлын хэрэг бүртгэлийг ашиглан, нарийвчилсан мэдээллийг оруулан бүртгэнэ. Байгаль орчинд ноцтой



GREEN
CLIMATE
FUND

Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ

УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ

хохирол учруулсан буюу ноцтой хор хохирол учруулж болзошгүй аливаа ослын талаар Хээрийн ажилтан төслийн менежер аль болох хурдан мэдэгдэнэ. Ажил гүйцэтгэгч байгууллага/гэрээлэгч байгууллага нь БОАЖЯ болон ХХААХҮЯ-ны зөвшөөрлийн дагуу залруулж, нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэж дуусах хүртэл ажлаа зогсооно.

3.2.5 Өдөр бүр, долоо хоног бүрийн байгаль орчны хяналт шалгалтын хяналтын хуудас

137. Байгаль орчны өдөр тутмын хяналтын хуудсыг ажлын талбар хариуцсан ажилтан бөглөж, бүртгэлд хөтлөнө. Долоо хоног тутмын байгаль орчны хяналтын хуудсыг бөглөж, Хээрийн ажилтнуудын бөглөсөн өдөр тутмын хяналтын жагсаалтад тодорхойлсон аливаа асуудлын талаархи лавлагааг оруулна. Дууссан хяналтын хуудсыг ямар нэг асуудал гарвал нягтлан үзэж, хариу арга хэмжээ авах үүднээс БСШУЯ, ХХААХҮЯ-нд хүргүүлнэ.

3.2.6 Залруулах арга хэмжээ

138. БОНҮНМБХХ-д үл нийцэх байдлыг долоо хоног бүрийн байгаль орчны хяналт шинжилгээнд тэмдэглэж, бүртгэлд оруулна. Үл нийцсэн байдлын ноцтой байдлын зэргээс хамааран Хээрийн ажилтан долоо хоногийн талбайн шалгалтын тайланд залруулах арга хэмжээг зааж өгч болно. Бүх залруулах үйл явцын явцыг бүртгэлийг ашиглан мөшгиж хянах болно. Аливаа үл нийцэх байдал, залруулах арга хэмжээтэй холбоотой асуудлын талаар БСШУЯ, ХХААХҮЯ-нд зөвлөж байна.

3.2.7 Нягтлан үзэж, аудит хийх тухай

139. БОНҮНМБХХ болон түүний журмыг дор хаяж 2 сар тутамд НҮБХХ-ийн ажилтнууд, БОАЖЯ, ХХААХҮЯ-наас хянаж байх болно. Нягтлан шалгах зорилго нь төслийг хэрэгжүүлж, барилгын ажлыг гүйцэтгэх явцад хуримтлуулсан мэдлгийг тусгах мөн шинэ мэдлэг мэдээлэл болон нутгийн ард иргэдийн хувьд өөрчлөгдсөн стандартыг (үнэ цэнийг) тусгах зорилгоор уг баримт бичгийг шинэчилж байх явдал юм.

140. Дараах нөхцлүүд үүсвэл БОНҮНМБХХ-ийг нягтлан шалгаж, нэмэлт өөрчлөлт хийх болно, үүнд:

- Байгаль орчны нөхцөлд эсвэл ерөнхийдөө хүлээн зөвшөөрөгдсөн байгаль орчны арга туршлагад холбогдох өөрчлөлтүүд орох үед; эсвэл
- Байгаль орчны шинэ болон өмнө нь тогтоогдоогүй эрсдлийг тодорхойлсон; эсвэл
- Төслийн хяналт шинжилгээ, тандалт судалгааны аргуудаас авсан мэдээлэл нь, одоогийн хяналтын арга хэмжээг үр дүнтэй болгохын тулд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байгааг харуулж байгаа бол, эсвэл
- Төсөлд хамаарах байгаль орчны хууль тогтоомжид өөрчлөлт орсон бол; эсвэл
- Эрх зүйн зохицуулалт хийх холбогдох эрх бүхий байгууллагаас гаргасан хүсэлт байгаа; эсвэл
- НҮБХХ-ын ажилтнууд, БОАЖЯ, ХХААХҮЯ-тай зөвшилцсөний үндсэн дээр аливаа хийх өөрчлөлтийг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай болсон зэрэг нөхцлүүд байна. Шинэчлэл хийгдсэн бол талбайд ажиллаж байгаа бүх бие бүрэлдэхүүн аль болох хурдан уг засварын талаар мэдсэн байх хэрэгтэй, ж нь, арга хэрэгслийг танилцуулах уулзалт эсвэл бичгээр мэдэгдэх зэрэг хэлбэрээр хүргэнэ.

3.2.8 Хяналт, шинжилгээ, үнэлэлт дүгнэлт ба тайлагнал

141. Өмнө дурдсанчлан БОАУЖЯ нь БОНҮНМБХХ-ийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэгтэй. Талбайн ажилтнууд ба / эсвэл гэрээт ажилтнууд өдөр бүр хянаж шалгаж, байгаль орчны аливаа хохирлын талаар БОАУЖЯ-нд мэдээлэх үүрэгтэй.

142. БОАЖЯ эсвэл түүний төлөөлөгч сар бүр хяналт шалгалт хийнэ. БОНҮНМБХХ болон холбогдох баримт бичгүүдийг төслийн хэрэгцээнд нийцсэн эсэхийг баталгаажуулах зорилгоор НҮБХХ, ХХААХҮЯ, БОАЖЯ нар хоёр сар тутамд хянана.

143. Түүнчлэн, шаардлагатай бол дунд хугацааны болон эцсийн үнэлгээний ажил гэх мэт тусдаа хяналт шинжилгээ, үнэлгээ хийх боломжтой. Ийм үнэлгээнүүд нь БОНҮНМБХХ-д уялдуулж болох эерэг ба сөрөг гүйцэтгэлийн нотолгоо мөн сурсан сургамжийн нэгтгэл дүгнэлт ба/эсвэл сайжруулахад чиглэсэн зөвлөмжүүдийг гаргаж өгөх ёстой.

144. БОАЖЯ нь хяналт шинжилгээ, үнэлгээний бүх мэдээлэл өгөгдлийг цуглуулж, Удирдах хорооны хуралд хураангуй тайланг танилцуулна. Уг тайлан нь УАНС-гийн итгэмжлэгдсэн хуулийн этгээд



Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ

болох НҮБХХ-ийн зүгээс гаргах жил бүрийн байгаль орчин болон нийгмийн хүрээнд хийсэн ажлын гүйцэтгэлийн үндэс суурийг тавьж өгнө.



3.3 СУРГАЛТ

145. Ажил гүйцэтгэгч байгууллага нь БОНҮНМБХХ-ийг хамруулаад, барилгын ажилд шаардагддаг байгаль орчин ба нийгмийн хүрээнд тавигддаг шаардлагын талаар холбогдох ажилчид, гэрээт ажил гүйцэтгэгчид, бусад ажилчид мэдэж байх, тийм систем ажиллаж байх нөхцлийг хангаж ажиллах үүрэгтэй.
146. Төслийн бүх бие бүрэлдэхүүн эрүүл ахуй, найдвартай байдал, байгаль орчин болон соёлын шаардлагуудыг хамарсан танилцуулах ажилд оролцох болно.
147. Байгаль орчинд ноцтой хор хохирол учруулах аливаа үйл ажиллагаа эрхэлдэг бүх ажилчид (жишээ нь, аюултай материалтай харьцах) байгаль орчны чиглэлээр мэргэшсэн сургалтанд хамрагдана.

4 ХАРИЛЦАА ХОЛБОО



4.1 Олон нийтийн зөвлөгөөн ба Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийн талаарх мэдээллийг ил болгох нь

148. БОНҮНМБХХ-д оролцогч талуудын оролцооны төлөвлөгөөний нэг хэсэг болох олон нийтийн хэлэлцүүлгийг багтаасан болно.
149. Санал боловсруулах явцад Үндэсний агентлагууд, аймгийн түвшний төлөөлөгчид, орон нутгийн засаг захиргааны албан тушаалтнууд, ТББ, ИНББ, нутгийн ард иргэдийн байгууллагууд, түүнчлэн хөгжлийн бусад түншүүд, тэдгээрийн холбогдох салбарт болон ижил газарзүйн зорилтот бүсэд чиглэн хэрэгжүүлсэн төслүүдтэй тогтмол зөвлөлдөж байсан. Оролцогч талуудтай хийсэн зөвлөгөөний тухай тайланг Хавсралт 3-д агуулсан байгаа.
150. Зөвлөгөөнийг дараах өөр өөр хэлбэрүүдээр зохион байгуулсан:
- Төслийн зорилтот аймгуудын төлөөллийн түвшинд
 - Орон нутгийн түвшинд, төслийн үндсэн үр ашиг хүртэгч нартай (Дорнод аймаг)
 - Хувийн хэвшлийн дугуй ширээний уулзалтыг:
 - Төв (Нийслэл хот)
 - Орон нутгийн түвшинд (Ховд аймаг)
 - Баталгаажуулалтын ажлыг төвд
 - Гол оролцогч талууд болон төслийн зорилтот ашиг хүртэгч иргэдтэй хоёр талын уулзалт, тогтмол зөвлөгөөнүүд
151. Оролцогч талуудтай зөвлөлдөх нь төслийн саналыг бэхжүүлэхэд тусалсан. Төслийн зорилтуудтай уялдсан оролцогч талуудын оруулсан саналын хувь нэмрийг төслийн баримт бичигт тусгасан болно. Хэлэлцүүлгийн үр дүнд төслийн хүрээнд үзэл баримтлалын тэмдэглэлийн үе шатаас одоогийн хэлбэрээ олох хүртэл зарим зүйлс өөрчлөгдсөн байна (Хавсралт 3-ыг үзнэ үү).
152. Төслийг боловсруулж байх явцад хийсэн газар дээр нь хийж байсан зөвлөгөөн (мөн энэхүү төслөөр өргөжүүлэхээр төлөвлөж байсан өмнөх төслийн үеэр) төслийн нөлөөлөлд өртсөн бүх нутгийн ард иргэдтэй үргэлжлүүлэн хийх болно. Энэ зорилгоор Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө боловсруулсан (Хавсралт 4). Өнөөдрийг хүртэл хийсэн хэлэлцүүлэг, нутгийн ард иргэдийн хэрэгцээ шаардлагад үндэслэн төслийг бүрэн хүлээж авна гэж төлөвлөж байна.
153. Дэд үйл ажиллагааг нарийвчлан судалж, болзошгүй эрсдлийн үнэлгээг хийсний дараа батлагдсан эрх зүйн баримт бичгийн мэдээллийг орон нутагт болон НҮБХХ-ны цахим хуудсанд байршуулна. Б ангиллын дэд үйл ажиллагааны хувьд, БОНБУ ба/эсвэл Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохион байгуулах төлөвлөгөөг (ESMP) батлагдсан шийдвэр гарахаас 30-аас доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлнэ. Хамгаалалтын тайланг Англи болон эх хэлний аль алианаар нь авах боломжтой. Тайланг УАНС-д өргөн барих бөгөөд үүнийг НҮБХХ болон УАНС-гийн цахим хуудсуудаар дамжуулан мөн УАНС-гийн Мэдээллийг ил болгох бодлого болон УАНС-гийн Байгаль орчин ба нийгмийн бодлогын 7.1-р хэсэгтэй уялдуулан, төслийн нөлөөнд өртөж буй нутгийн ард иргэдэд тохиромжтой газруудаар дамжуулан УАНС-нд хүргүүлнэ.
154. НҮБХХ, БОАЖЯ, ХХААХҮЯ нь төслийн талаар сонирхож буй талуудыг төслийн төлөв байдлын талаарх мэдээллээр хангахын тулд төслийн талаарх шинэчилсэн мэдээллийг тогтмол боловсруулж, нийтэлж байх болно. Шинэчилсэн мэдээллийг хэвлэл, радио, нийгмийн сүлжээ эсвэл албан ёсны тайлан гэх мэт олон мэдээллийн хэрэгслээр дамжуулж болно. Лавлагаа, санаа зовоосон асуудал, өргөдөл гомдлыг хүлээн авахад зориулсан харилцааны цэг болгож үйлчлэхээр, төслийн явцад олон нийтэд нээлттэй утасны дугаарыг ажиллуулна. Бүх лавлагаа, асуудлууд, гомдлуудыг бүртгэл дээр тэмдэглэж авах бөгөөд энэ талаар зохих менежерүүдэд мэдээлж ажиллана. Бүх материалыг Монгол болон Англи хэлээр зохих үед нь хэвлэн нийтэлж ажиллах ёстой.
155. Нутгийн ард иргэдтэй холбоотой асуудал үүссэн үед, дараах мэдээллийг тэмдэглэж авна, үүнд:
- цаг, өдөр, лавлагааны мөн чанар, гомдол эсвэл асуудал
 - харилцааны хэлбэр (ж нь, утас, захиа, хувийн холбоо)



- нэр, холбоо барих хаяг, утсны дугаар
- лавлагаа, гомдол, эсвэл тавьсан асуудлын дагуу өгсөн хариулт болон мөрдөн шалгасан арга хэмжээ
- авсан арга хэмжээ болон үүнийг хэрэгжүүлсэн хүний нэр



156. Зарим лавлагаа, гомдол, санал хүсэлтийг шийдэхэд урт хугацаа шаардагдаж болох юм. Гомдол гаргагчид холбогдох асуудлыг шийдвэрлэх явцын талаар мэдэгдэх болно. Бүх асуулт, гомдол, санал хүсэлтийг судалж, гомдол гаргагчид цаг тухайд нь хариу өгнө. Хурдан шийдвэрлэх боломжгүй байж болох бүх гомдлыг шийдвэрлэх зорилгоор нь БОНҮНМБХХ-т гомдлыг барагдуулах механизмыг оруулсан болно.
157. Нэр дэвшүүлсэн ТМН/гэрээгээр гүйцэтгэгчийн ажилтнууд нь бүх лавлагаа, гомдол, тавьж буй асуудлуудыг нягтлан үзэж, тэдгээрийн тус бүрийнх нь шийдэлд чиглэсэн ахиц дэвшил гаргах үүрэг хариуцлага хүлээх болно.

4.2 Өргөдөл, гомдлын бүртгэл, Гомдол барагдуулах механизм

158. Аливаа төслийг боловсруулж, хэрэгжүүлэх үе шатанд хувь хүн эсвэл бүлэг хүмүүст сөргөөр нөлөөлж, төслийн үйл ажиллагааны улмаас шууд болон шууд бусаад өртөж болзошгүй байдаг. Гарч болзошгүй гомдлууд нь нийгмийн шалгуур, эрх, үйлчилгээний тасалдал, амьжиргаагаа түр зуурын эсвэл бүрмөсөн алдах болон бусад нийгэм, соёлын бусад асуудалтай холбоотой байж болно. Гомдол нь мөн хэт их тоосжилт үүсэх, барилгатай холбоотой чичирхийлэл болон түүхий эд материалын тээвэрлэлт, дуу чимээ, замын түгжрэл, усжуулалтын нөхөн сэргээлт хийх явцад хувийн болон төрийн өмчийн хөрөнгөөр хийгдсэн ил /гүний худгийн усны нөөцийн чанар болон тоо хэмжээ буурах, гэр ахуйн цэцэрлэг болон хөдөө аж ахуйн эдэлбэр газарт хохирол учрах зэрэгтэй холбоотойгоор дэд бүтцэд эвдрэл гэмтэл үүсэх зэрэг байгаль орчны асуудалтай холбоотой байж болно.
159. Ийм нөхцөл байдал үүсвэл нөлөөлөлд өртсөн тал эдгээр асуудлыг төслийн ажилтнуудтай хамтран үр ашигтай, шударга, ил тод байдлаар, цаг тухайд нь, зардал багатайгаар шийдвэрлэх боломжтой механизм байх ёстой. Энэ зорилгод хүрэхийн тулд энэхүү төслийн БОНҮНМБХХ-д гомдол барагдуулах механизмыг оруулсан болно.
160. Төсөл нь гомдолтой байгаа болон төслийн улмаас хохирол учруулсан гэж үзэж байгаа хүмүүст зориулан зохих үйл явцаар дамжуулан өөрсдийн санаа зовсон асуудал ба/эсвэл гомдлоо уламжилж харилцах боломжтой байх нөхцлийг олгодог. БОНҮНМБХХ-д тусгасан Гомдлыг бүртгэл, Гомдол барагдуулах механизмийг төслийн нэгэн хэсэг болгож ашиглах бөгөөд холбогдох оролцогч талууд, ялангуяа албан ёсны хууль ёсны тогтоолцоо багатай аливаа эмзэг бүлгийнхэнд хүртээмжтэйгээр, шуурхай, шударга, үр дүнтэй байдлаар хариу мэдээлэл өгөх болно.
161. Олон гомдлыг даруй шийдвэрлэж чадна гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа боловч энэхүү БОНҮНМБХХ-д тусгасан тусгасан Гомдлын бүртгэл, Гомдол барагдуулах механизмийг тухайн үед нь асуудал үүсэхэд харилцан хоёр талын хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргахыг хөхиүлэн дэмжих болно. БОНҮНМБХХ-д тусгасан тусгасан Гомдлын бүртгэл, Гомдол барагдуулах механизмийг дараах зорилгоор боловсруулсан юм, үүнд:
- Оролцогч талуудын дунд итгэлцэл буй болгох нөхцлийг олгосон мөн оролцогч талуудын санаа зовж байгаа асуудлуудыг шударга, ил тод байдлаар үнэлэх баталгаа олгосон хууль ёсны үйл явц байна;
 - Бүх оролцогч талуудад зориулсан Гомдлын бүртгэл, Гомдол барагдуулах механизмийн энгийн бөгөөд хялбаршуулсан хүртээмжтэй байдлыг олгох бөгөөд өнгөрсөн хугацаанд саад тотгортой учирч байсан байж болзошгүй тэдгээр хүмүүст санаа зовсон асуудлаа дэвшүүлэх боломжтой байлгахын тулд хангалттай хэмжээнд дэмжлэг үзүүлнэ,
 - Гомдол барагдуулах механизмийн үе шат болгонд тодорхой бөгөөд мэдэгдэхүйц журмыг гаргаж, хувь хүмүүс болон бүлгүүдийн хувьд боломжтой үр дүнгийн хэлбэрүүдийг тодорхой болгож өгнө,
 - Шударга, мэдээллээр хангагдсан, гомдол ба/эсвэл асуудалд хүндэтгэлтэй хандах замаар, тууштай, албан ёсны арга барилаар дамжуулан холбогдох, гомдолтой байгаа бүх хувь хүмүүс болон бүлгүүдэд эрх тэгш хандана,



- Хохирсон аливаа хувь хүн / бүлгүүдэд тэдний гаргасан гомдлыг шийдвэрлэх явц болон тэдний гомдлыг үнэлэхэд ашигласан мэдээлэл болон уг асуудлыг шийдэхийн тулд ашиглах механизмын талаарх мэдээллээр хангаж байна,
- Байнга суралцаж, Гомдол барагдуулах механизмыг сайжруулж байх нөхцлийг хангана, Байнга үргэлжлүүлэн үнэлгээ хийх замаар сурч авсан мэдлэг нь байж болох гомдол болон нэхэмжлэлийн тоог бууруулж болох юм.

Н

162. Гомдол барагдуулах механизмд сонгогдох эрхийн шалгуур үзүүлэлтэд дараах зүйлс багтана, үүнд:

- Хувь хүмүүс ба/эсвэл бүлэгт эдийн засаг, нийгэм, эсвэл байгаль орчны сөрөг нөлөөлөл үзүүлсэн эсвэл сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлалтай гэж санаа зовсон тохиолдолд,
- Маш тодорхой төрлийн нөлөөлөл бий болсон эсвэл бий болох магадлалтай, мөн уг төсөл нь хэрхэн ийм нөлөөлөл үзүүлсэн эсвэл үзүүлэх магадлалтай болох талаар гаргасан тайлбар,
- Гомдол ба/эсвэл маргаан гаргаж буй хувь хүн ба/эсвэл бүлэг нөлөөлөлд өртсөн, эсвэл нөлөөлөлд өртөх магадлалтай байгаа эсвэл нөлөөлөлд өртөх эрсдэлтэй байгаа, эсвэл гомдол ба/эсвэл маргаан гаргаж буй хувь хүн ба/эсвэл бүлэг нь нөлөөлөлд өртөөд буй эсвэл өртөх магадлалтай байгаа хувь хүн эсвэл бүлэг этгээд, тэдгээрийн ашиг сонирхлыг төлөөлөх бүрэн эрхтэй гэдгээ нотлон харуулсан бол гэсэн нөхцлүүд бий.

163. Орон нутгийн ард иргэд болон бусад сонирхсон оролцогч талууд бүх цаг үед БОАЖЯ болон ХХААХҮЯ-д маргаан/гомдлоо тавьж байж болно. Нөлөөлөлд өртсөн орон нутгийн ард иргэд БОНҮНМБХХ-ийн нөхцлүүд болон түүний гомдлын механизм болон хэрхэн гомдол гаргах талаар мэдээллээр хангагдсан байх ёстой.

4.2.1 Гомдлыг бүртгэх

164. Нутгийн ард иргэдтэй холбоотой асуудал гарсан тохиолдолд, дараах мэдээллийг бүртгэн тэмдэглэсэн байх ёстой, үүнд:

165. Бүтээн байгуулалтын явцад нутгийн ард иргэдийн дэвшүүлсэн аливаа асуудлын талаар тэмдэглэхийн тулд гомдлын бүртгэлийг төслийн нэг хэсэг болгон байгуулах болно. Аливаа гомдлыг хүлээж авснаас хойш 24 цагийн дотор НҮБХХ, БОАЖЯ, ХХААХҮЯ-нд зөвлөмж болгон мэдэгдэнэ. Уг гомдлыг хурдавчилсан байдлаар дүн шинжилнэ. Ийнхүү дүн шинжилсэний дараа хээл хахуультай холбоотой гомдлыг БОАЖЯ болон ХХААХҮЯ-тай хамт зөвлөлдөж, тайлбар, зөвлөгөө гаргуулах зорилгоор НҮБХХ-рт хаяглан хүргүүлнэ.

166. Төслийн баг гомдлыг аль болох хурдан шийдвэрлэхийг эрмэлзэж, улмаар асуудлыг улам хурцатгахаас зайлсхийх болно. Гэсэн хэдий ч, гомдлыг хурдан шийдвэрлэх боломжгүй бол уг асуудал хурцдах болно.

167. Хүлээн авсан өргөдөл гомдлын хураангуй жагсаалтыг, тэдгээрийг устгах асуудлыг зургаан сар тутамд гаргадаг тайланд нийтэлж байх ёстой.

4.2.2 Гомдол барагдуулах механизм

168. Гомдол барагдуулах механизмыг сайн дурын сайн сайхны төлөө хүчин чармайлтын үндсэн дээр асуудлыг шийдвэрлэх механизм болгон зохион бүтээсэн. Гомдол барагдуулах механизм нь хууль ёсны хэрэг хянан шийдвэрлэх үйл явцыг орлож буй зүйл биш юм. Гомдол барагдуулах механизм нь, боломжтой л байгаа бол гомдол, нэхэмжлэлийг бүх талуудад харилцан хүлээн зөвшөөрөгдсөн нөхцлийн дагуу шийдвэрлэхийг хичээх болно. Гомдол, нэхэмжлэл гаргахдаа бүх талууд бүхий л цаг үед бат итгэлтэй ажиллах ёстой бөгөөд харилцан хүлээн зөвшөөрөхүйц аливаа шийдвэрийг хойшлуулах эсвэл саад учруулахгүй байх ёстой.

169. Төслийг жигд хэрэгжүүлж, хэрэгжилтийн явцад тулгарч болзошгүй бэрхшээлийг цаг тухайд нь, үр дүнтэй шийдвэрлэх зорилгоор Төслийн эрх бүхий байгууллагууд төслийн оролцогч талуудын гомдлыг шийдвэрлэх боломжийг олгосон, гомдол барагдуулах хүчтэй механизмыг бий болгосон болно.

170. Нийгэм, байгаль орчны асуудлаарх бүх гомдлыг амаар (талбайн ажилтнуудад) утсаар, гомдлын хайрцагт эсвэл НҮБХХ, БОАЖЯ, ХХААХҮЯ, барилгын ажил гүйцэтгэгч компанид бичгээр хүргүүлэх замаар хүлээн авах боломжтой. Гомдол барагдуулах механизмын гол хэсэг бол төсөл хэрэгжүүлэгч, барилгын гүйцэтгэгч нарт төслийг газар дээр нь хэрэгжүүлэгч холбогдох

оффисуудад ирсэн гомдлын бүртгэлийг хөтлөх шаардлага юм. Бүх гомдол гаргагч нар т хүндэтгэлтэй, эелдэг, мэдрэмжтэй байдлаар хандана. Төслийг дэмжигч нар болон барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч нар гомдлод дурдсан асуудлыг өөрсдийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэхийн тулд байж болох бүхий л хүчин чармайлтыг гаргах ёстой. Гэсэн хэдий ч илүү нарийн төвөгтэй, төслийн түвшний механизмаар дамжуулан шийдвэрлэх боломжгүй зарим асуудлууд байж болно. Ийм гомдлыг Гомдол барагдуулах хороонд хүргүүлнэ. Эдгээр асуудлыг тодорхой /чадвартай үйл явцаар шийдвэрлэх нь БОАЖЯ болон ХХААХҮЯ-ны үүрэг хариуцлага юм.

Н

171. Гомдол барагдуулах механизм нь гомдол гаргах үйл явц нь хувь хүн болон /эсвэл бүлэгт санхүүгийн нөлөөлөл үзүүлэхгүй байхаар боловсруулагдсан болно. Гомдол барагдуулах механизм нь хууль ёсны гомдол болон/эсвэл нэхэмжлэлийг бэлтгэх тал дээр дэмжлэг үзүүлэх үүднээс зохих/шаардлага хангасан хүнийг ажиллуулахад гарах аливаа үндэслэлтэй зардлыг хариуцан даах болно.
172. Гомдол барагдуулах механизмийн талаарх мэдээлэл болон хэрхэн гомдол гаргах тухай мэдээллийг гол оролцогч талуудад хүргэхийн тулд тохиромжтой газруудад байршуулах ёстой.
173. Төслийн менежментийн нэгжид ажиллаж байгаа Хамгаалалтын болон Хүйсийн тэгш байдлын асуудал хариуцсан ажилтныг Гомдол барагдуулах механизмын үндсэн ажилтнаар томилно. Эдгээр албан тушаалын Ажил үүргийн удирдамжид дараах үүрэг хариуцлагуудыг тусгасан байна:
 - a. Асуудлыг шийдвэрлэхийн тулд барилга угсралтын ажил эхлэхээс өмнө Гомдол барагдуулах хороо байгуулах ажлыг зохицуулах;
 - b. Гомдол барагдуулах асуудлаарх Төслийн менежментийн нэгжийн (ТМН) гол холбогдох ажилтан байдлаар ажиллаж, ТМН-ийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагааг хөнгөвчилж ажиллана,
 - c. Олон нийтийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх замаар бүх оролцогч талуудын дунд Гомдол барагдуулах механизмийн талаарх ойлголтыг буй болгох,
 - d. Холбогдох талуудтай уялдан зохицуулах замаар бүх гомдлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах,
 - e. Гомдол, нэхэмжлэлийн талаарх мэдээллээр хангаж ажиллах,
 - f. Гомдол гарсан асуудлын талаар БОАЖЯ болон ХХААХҮЯ-ны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж ажиллах,
 - g. Гарсан ахиц дэвшлийн талаар сар/улирлын тайланг бэлдэж ажиллах.
174. Төсөлтэй холбоотой гарсан бүх гомдлыг шийдвэрлэхийн тулд Гомдол барагдуулах хоёр шатлалт механизмийг боловсруулсан. Гомдол барагдуулах эхний шатлалын механизмд гомдлыг сум ба/эсвэл аймгийн түвшинд хүлээн авах ажлаас бүрдэнэ. Оролцогч талуудад (хэрэв байгаа бол) гомдол гаргаж хүргүүлэх олон цэгүүдийн талаарх мэдээллийг олгож, ТМН нь эдгээр цэгүүдээс тогтмол гомдлуудыг цуглуулж мөн тэднийг бичиж бүртгэх юм. Үүний дараа гомдлыг арилгах талаар холбогдох хүмүүстэй уялдуулсан зохицуулалт хийж байх юм. Ахлах техникийн зөвлөх (СТА) нь гомдлыг барагдуулахын тулд холбогдох Дүүргийн түвшинд үйл ажиллагаагаа уялдуулан ажиллах бөгөөд энэ талаар гол холбогдох ажилтан байдлаар ажиллана. Орон нутгийн эрх бүхий байгууллагын Нутгийн ард иргэдийн хөгжлийн асуудал хариуцсан ажилтан, эсвэл Нутгийн ард иргэдийн хөгжлийн асуудал хариуцсан ажилтан байхгүй байгаа тохиолдолд, энэ асуудлыг хариуцуулсан аливаа ажилтан нь тухайн гомдлыг барагдуулахын тулд Ахлах техникийн зөвлөх (СТА), БОАЖЯ, ХХААХҮЯ-тай уялдаж ажиллах болно. Орон нутгийн эрх бүхий байгууллагын томилогдсон ажилтан ирээдүйд ийм системийг үргэлжлүүлэн ажиллуулахын тулд гомдол барагдуулах процессийн талаар хангалттай хэмжээний сургалт өгсөн байна.
175. Гомдлыг амаар (талбайн ажилтнуудад) утсаар, гомдлын хайрцагт эсвэл НҮБХХ, БОАЖЯ, ХХААХҮЯ, Барилгын гэрээгээр гүйцэтгэгч компанид бичгээр өгөх боломжтой. Гомдол гаргагчид төслийн үндэсний зохицуулагчтай тусгайлан холбоо барьж, хариу арга хэмжээ авахтай холбоотой асуудал байгаа бол нууцлалыг хүсч болно. Нууцлалыг хадгалах хүсэлт гарсан (жишээ нь НҮБХХ, БОАЖЯ, ХХААХҮЯ болон Барилгын гүйцэтгэгч компанид гомдол гаргагчийн хувийн мэдээллийг тодруулахгүй байх), тохиолдолд Төслийн үндэсний зохицуулагч гомдлыг хянаж, гомдол гаргагчтай ярилцаж, гомдол гаргагчийн нууцлалыг хадгалахын зэрэгцээ төслийн гүйцэтгэгч байгууллагыг хэрхэн яаж хамгийн сайнаар ятгаж үнэмшүүлэх боломжийг тодорхойлно.

176. Гомдол хүлээж авсан даруйд Ахлах техникийн зөвлөх (СТА) нь хүлээн авснаа мэдэгдэх болно. Гомдол хүлээж авсан ажилтан нь гомдол, нэхэмжлэл гаргагчийн талаар холбогдох үндсэн мэдээллийг авахыг хичээх бөгөөд Ахлах техникийн зөвлөхөд (СТА) нэн даруй мэдэгдэх болно.
177. ТМН нь аймгийн түвшинд Гомдол/нэхэмжлэлийг барагдуулах бүртгэлийг хөтөлнө. Холбогдох этгээдүүдээс мэдээлэл цуглуулж, тэмдэглэл хөтлөх нь ТМН-ийн үүрэг хариуцлага юм.
178. Гомдлыг бүртгэсний дараа Ахлах техникийн зөвлөх нь гаргасан гомдлыг нарийвчлан судалж, тухайн гомдолд хариу өгч, барагдуулах тодорхой огноотой нь хамт холбогдох ажилтан руу нь уламжилна. Ахлах техникийн зөвлөх нь нөлөөлөлд өртсөн хүмүүс / гомдол гаргагчидтай уулзалт хийж, дараа нь хүлээн авсан гомдлын шийдлийг олохыг хичээнэ. Шаардлагатай бол асуудлын шийдлийг олох, гомдлыг барагдуулах төлөвлөгөө боловсруулах зорилгоор холбогдох нөлөөлөлд өртсөн хүмүүс / гомдол гаргагч, холбогдох ажилтантай уулзалт зохион байгуулна. Зохион байгуулсан хуралдаан, хэлэлцсэн шийдвэрүүдийн талаар тэмдэглэл хөтлөнө. Гомдол барагдуулах механизмтай холбоотой бүх уулзалт, түүний дотор Гомдол барагдуулах хорооны хурлыг тэмдэглэж байх ёстой.
179. Эхний шатлалд гарах шийдвэрийг 15 хоногийн дотор дуусгах ёстой байдаг бөгөөд мэдээллийг ил болгох маягыг ашиглан санал болгож буй хариу мэдээллийн талаар гомдол гаргагчид мэдэгдэх болно. Шийдвэрлэх үйл явц нь Гомдол барагдуулах механизмын шаардлагыг дагаж мөрдөх ёстой бөгөөд ингэснээр бүх талуудтай албан бус түвшинд хэрэгжүүлж болохуйц шударга байдлаар үйл ажиллагаа явуулна. Цаашлаад Гомдол барагдуулах механизм нь боломжтой бол бүх талуудын харилцан хүлээн зөвшөөрсөн үр дүнд хүрэх ёстой.
180. Энэ хугацаанд гомдлыг гомдол гаргагчийн сэтгэлд нийцэхээр шийдвэрлэж чадаагүй тохиолдолд, Гомдол барагдуулах механизмийн дараагийн шатны түвшинд уг гомдлыг хүргүүлэх болно. Хэрвээ Ахлах техникийн зөвлөх (СТА) нь ажлын дараагийн тав хоногийн дотор зохих шийдлүүдийг гаргаж чадна гэж үзвэл тухайн ажилтан гомдол гаргагчид тийнхүү мэдэгдэх замаар асуудлыг эхний түвшинд хадгалан шийдвэрлэхээр үлдээж болно. Гэсэн хэдий ч хэрэв гомдол гаргагч шууд дараагийн шатанд шилжүүлэхийг хүсч байвал асуудлыг дараагийн шатанд шилжүүлэх шаардлагатай. Ямар ч тохиолдолд ажлын 20 хоногийн дотор шийдвэрлэгдээгүй тохиолдолд асуудлыг дараагийн шатанд шилжүүлнэ.
181. Авлига, ёс зүйгүй үйлдэлтэй холбоотой аливаа гомдлыг Монгол Улсын Ерөнхий Прокурорын газар, Нью-Йорк дахь НҮБХХ-ийн дэргэдэх Аудит, мөрдөн шалгах газарт шууд нэн даруй өгөх ёстой.
182. Аймаг болгоны түвшинд байгуулагдсан Гомдол барагдуулах хороо нь гомдлыг хоёрдах шатны түвшинд шийдвэрлэх болно. Орон нутгийн засаг захиргааны Бүрэн эрхт төлөөлөгчийн гаргасан шийдвэрийн дагуу аймагт бүрт Гомдол барагдуулах хороо гэж байгуулагдах бөгөөд Бүрэн эрхт төлөөлөгч уг хорооны мөн дарга нь байна.
183. ТМН-ийн Ахлах техникийн зөвлөх (СТА) нь аймаг бүрт эдгээр хороодуудыг байгуулж, энэ асуудалтай холбоотой шаардлагатай шийдвэрийг гаргуулж, тэгснээрээ тэд шаардлагатай үед цугладаг байлгахын тулд, Орон нутгийн засаг захиргааны зохих Бүрэн эрхт төлөөлөгчтэй уялдаж ажиллана.
184. Гомдол барагдуулах хорооны Ажил үүргийн удирдамж нь;
- Нөлөөлөлд өртсөн хүмүүсийг асуудлаа шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх,
 - гомдлыг нэн тэргүүнд тавьж, эртнээс шийдвэрлэх;
 - ноцтой хэргүүдийн талаар ТМН, БОАЖЯ, ХХААХҮЯ-нд аль болох эрт мэдээллийг хүргэх;
 - Гомдол гаргасан, хохирсон хүн / бүлгүүдтэй уялдан ажиллах, тэдний/түүний гомдлын дагуу боловсруулсан шийдлийн талаар цаг тухайд нь шаардлагатай зохих мэдээллийг авах;
 - ердийн тохиолддог гомдлыг судалж, цаашид тохиолдохоос зайлсхийхийн тулд шийдвэрлэх арга хэмжээний талаар ТМН, Үндэсний түвшний болон дүүргийн Удирдах хороонд зөвлөх;
185. Гомдол барагдуулах хороо нь хохирогч тал / гомдол гаргагч, холбогдох ажилтантай шаардлагатай уулзалтыг зохион байгуулж, бүх түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн шийдлийг олохыг хичээнэ. Гомдлыг барагдуулах хороо хурлын тэмдэглэлийг хөтлөнө.
186. Гомдол барагдуулах хороо нь гомдол гаргагчид санал болгосон хариуг албан ёсоор мэдээлнэ. Хэрэв санал болгож буй хариу нь гомдол гаргагчийн сэтгэл ханамжийг хангаж байвал хариу арга

хэмжээ хэрэгжиж, гомдлын асуудал хаагдана. Санал болгосон хариу нь гомдол гаргагчийн сэтгэл ханамжид нийцэхгүй байгаа тохиолдолд Гомдол барагдуулах хороо нь гомдол гаргагчийн үлдсэн асуудалд нийцүүлэхээр санал болгосон хариугаа дахин шинэчлэх эсвэл гомдол гаргагчид Гомдол барагдуулах комиссоос өөр хариу өгөх боломжгүй гэдгийг мэдэгдэж болно. Гомдол гаргагч Гомдол барагдуулах механизмын гурван шатны хэлэлцүүлгийн дараа гарсан шийдвэрийн тухайд сэтгэл ханамжгүй байгаа бол хууль ёсны эсвэл өөр хариу арга хэмжээ авахаар шийдэж болно.

187. Гомдол гаргагчид нь төслийн түвшинд болон үндэсний гомдлыг шийдвэрлэх механизмаас гадна НҮБХХ-ийн хариуцлагын механизмыг ашиглах боломжтой байдаг бөгөөд энэ нь хуульд нийцүүлэх болон гомдол гаргах аль аль чиг үүрэгтэй юм. Нийгэм, байгаль орчны нийцлийн алба нь НҮБХХ-ийн стандарт, түргэвчилсэн үнэлгээний процедур эсвэл НҮБХХ-ийн нийгэм, байгаль орчны бусад үүрэг амлалтуудыг хангалттай хэмжээнд хэрэгжүүлээгүй бөгөөд үүний улмаас ард иргэд ба байгаль орчинд хохирол учруулж болзошгүй гэж үзэж байгаа мэдэгдэл, зөвтгөх үндэслэгээг мөрдөн шалгадаг. Нийгэм ба байгаль орчны нийцүүлэх асуудал хариуцсан нэгж гэдэг нь Аудит ба мөрдөн шалгах албанд байрладаг бөгөөд үүнийг Ахлах нийцлийн ажилтан удирдан зохион байгуулж байдаг. НҮБХХ-ийн хөтөлбөр эсвэл төслийн үр нөлөөллийн талаар санаа зовж буй аливаа нутгийн ард иргэд эсвэл хувь хүмүүст уг дүрэм, журмын нийцлийг хянан дүгнэсэн ажил нь нээлттэй байна. Нийгэм, байгаль орчны нийцлийн алба нь орон нутгийн түвшний нөлөөлөлд өртсөн хүмүүсийн зүгээс гаргасан үндэслэлтэй хүсэлтийг хараат бус, шударга байдлаар мөрдөн шалгаж, мөн шалгалтынхаа үр дүн болон зөвлөмжийг олон нийтэд тайлагнана.
188. Оролцогч талуудын хариу арга хэмжээ авах механизм нь НҮБХХ-ийн төслийн улмаас нийгэм болон байгаль орчинд үзүүлсэн нөлөөлөлд өртсөн тухай санаа зовж байгаа асуудлыг шийдвэрлэхийн тулд дотоодын түвшинд нөлөөлөлд өртсөн хүмүүсийг бусад хамтрагч талуудтай ажиллах боломжийг олгодог. Оролцогч талуудын хариу арга хэмжээ авах механизм нь төслийн мөчлөгийн бүхий л явцад НҮБХХ болон Хэрэгжүүлэгч түнш байгууллагуудын шаарддаг оролцогч талуудын идэвх санаачлагатай байдлыг дэмжиж ажиллах зорилготой. Нутгийн ард иргэд болон хувь хүмүүс төслийн удирдлага, чанарын баталгаажуулалтын стандарт сувгуудыг ашигласан боловч хариу арга хэмжээнд нь (энэ тохиолдол бол төслийн түвшинд ажиллаж байгаа гомдол барагдуулах механизм) сэтгэл ханамжгүй байгаа бол, Оролцогч талуудын хариу арга хэмжээ авах механизмд хүсэлт гаргаж болно. Оролцогч талуудын хариу арга хэмжээ авах механизмд хүчин төгөлдөр хүсэлт гаргасан тохиолдолд, тухайн улс, бүс нутаг, удридах төв байгууллагын түвшинд ажиллаж байгаа НҮБХХ-ийн зохих холбоо барьж ажиллах хүч нь уг асуудлыг шийдвэрлэхийн тулд холбогдох оролцогч талууд болон Хэрэгжүүлэгч түнш байгууллагуудтай хамтран ажиллах болно. Дараах www.undp.org/secu-srm цахим хуудсаар орж илүү нарийвчилсан мэдээлэл авна уу. Холбогдох маягтыг БОНҮНМБХХ-ийн төгсгөлд хавсаргасан болно.


5 БАЙГАЛЬ ОРЧИН БА НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Н

189. Энэ хэсэгт төслийн хүрээнд тодорхойлсон байгаль орчны болон нийгмийн үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлж, холбогдох менежментийн зорилтууд, болзошгүй нөлөөлөл, хяналтын үйл ажиллагаа болон эдгээр үзүүлэлтүүдтэй тулгаж үнэлж дүгнэх (ж нь, аудит хийх), хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг тоймлон гаргасан байгаа.
190. Энэ хэсэгт хяналтын журмын амжилт, алдаа дутагдлын талаарх мэдээллээр хангах, төслийг удирдан зохион байгуулж байгаа үйл явцыг үргэлжлүүлэн сайжруулах боломжийг олгох арга хэмжээг тодорхойлох болон залруулах шаардлагатай байгаа асуудлуудыг ялгаж салгах зорилготойгоор, байгаль орчны гүйцэтгэлийн талаар хяналт шинжилгээ хийх мөн тайлагнах шаардлагын талаар улам лавшруулан тусгасан болно.

5.1 УУР АМЬСГАЛ

191. Эх газрын гүнд байрладаг, уулархаг газрын гадаргуутай байдаг тул Монгол орны уур амьсгал нь эх газрын бөгөөд эрс тэс, хуурай байдаг. Уур амьсгал нь урт өвөл, богино зун, өдөр тутмын болон удирлын агаарын хэм огцом хэлбэлзэлтэй, үүлгүй өдрийн тоо харьцангуй их, хур тунадас бага бөгөөд ихэвчлэн зун (85%) унадаг.
192. Хангай, Хэнтий, Хөвсгөлийн уулархаг нутгаар жилд дунджаар 250-350 мм хур тунадас орно; Монгол Алтайн нутагт 150-300 мм; Говь цөлөрхөг бүсэд 50-150 мм байна (Зураг 3). Тус орны ихэнх нь зундаа халуун бөгөөд өвөлдөө маш хүйтэн, 1-р сарын дундаж нь -30 хэм хүртэл буурдаг. Жилийн дундаж агаарын хэм -7.8 °C -8.5 °C байна.



Зураг 3 Жилийн агаарын хэмийн газарзүйн тархалт °C-ээр, жилийн хур тунадас мм-ээр²

Агаарын хэм/ температур:

	УБ хот	Төв	Хойд	Зүүн бүс	Баруун бүс	Говь
1-р сар	-15 / -32	-10 / -22	-17 / -30	-15 / -27	-18 / -30	-11 / -24
8-р сар	8 / 22	8 / 20	8 / 22	11 / 24	9 / 23	9 / 23

Хүснэгт 6 Монгол орны янз бүрийн хэсэг дэх хамгийн их ба хамгийн бага агаарын хэм/температур

² Ministry of Environment and Green Development (2013) Integrated Water Management Plan of Mongolia


5.2 ЭКОЛОГИ

Н

5.2.1 Суурь мэдээлэл

193. Физик газарзүйн хувьд тал хээр (өвслөг нутаг) нь эко бүс нутаг бөгөөд уулын бэлчээр, ойт хээр, сэрүүн бүсийн өвст хээр, бэлчээр, саванн зэрэг тухай нутагт байгаа ургамал, амьтны аймаг нь гол нуурын ойролцоо байдгаас гадна ой модгүй бэлчээр өвст тал бүхий шинж чанартай. Энэ нэр томъёо нь тус бүс нутгийн уур амьсгал нь ой мод ургахад хэт хуурай боловч цөлөрхөг байхад хангалттай хэмжээний хуурай биш газар нутаг юм.
194. Тус орны ихэнх нутаг нь тал нутаг байдаг ба үүний үр дүнд мал бэлчээрлүүлэх нь хөдөө орон нутгийн ард иргэдийг дэмжих гол үйл ажиллагаа, эх үүсвэр болсон байна. Нүүдэлчин малчид хонь, ямаа, адуу, үхэр, сарлаг, тэмээ хосолсон сүрэгтэй байдаг ба; Монголын тал нутгийн хүмүүс 3000 гаруй жилийн турш бэлчээрийн нүүдлийн мал аж ахуйгаас хамааралтай байсаар ирсэн.
195. Монгол улсад эрүүл бэлчээр гэдэг нь ган, зуд зэрэг байгалийн гамшиг үзэгдэлд тэсвэртэй мал аж ахуйн үйлдвэрлэл болон малчин ард иргэдийг буй болгоход хувь нэмэр оруулж чадах юм. Эрүүл бэлчээр гэдэг нь малд илүү их хэмжээний өвс тэжээл өгч, илүү сайн шим тэжээл олгохыг дэмжиж байдаг. Малын тоо толгойг өсгөхөөс гадна, эрүүл бэлчээр гэдэг нь зудыг даван туулах илүү сайн чадвартай тарга тэвээрэг авсан, эрүүл мал онд өнтэй орох боломжийг дэмждэг байна.³
196. Монгол-Манжуурын өвст хээр тал нутаг нь 887'300 хавтгай дөрвөлжин километр талбайг хамардаг. Эртний арктикийн сэрүү бүсийн өвст хээр бэлчээр, саванн, сэрүү бүсийн өвст хээрийн модорхог экс бүс нутаг, саванн ба ойт хээр зэрэг тухай нутагт байгаа ургамал, амьтны аймаг нь Говийн цөлөрхөг бүс нутгийг тойрон хүрээлсэн хэлбэртэй бөгөөд Монгол орны төв болон зүүн бүс нутаг, Өвөр Монголын зүүн хэсэг, зүүн болон төв Манжуур, тэгээд Хойд Хятадын тал газрын баруун өмнөд хэсэг дагуу сунаж тогтсон байдаг. Энэхүү эко бүс нутаг нь Монгол зэрлэг бөхөн гөрөөс гэх мэт туурайтан амьтны жижиг популяц бүхий олон янзын өвст хээр тал нутагт амьтан, ургамлын төрөл зүйлийн популяцийн бүлгэмдэлийг тэтгэн дэмжиж байдаг.
197. Зүүн хойд болон хойд зүг рүүгээ Сэлэнгэ-Орхон болон Дагуурын ойт хээр бүс нь өвст хээр бэлчээр нутаг болон хойд талын Сибирийн ой хоёрын хоорондын шилжилтийн бүс нутгийг бүрдүүлж байдаг. Энд зонхилдог ургамлын аймаг нь дунд зэргээс авахуулаад өндөр ургадаг өвст хээр, хялганат өвс (*Stipa baicalensis*, *S. capillata*, and *S. grandis*), хонины овъёос (*Festuca ovina*), *Aneurolepidium chinense*, *Filifolium sibiricum*, and *Cleistogenes squarrosa* зэрэг нэртэй ургамлууд байдаг. Говийн эргэн тойронд хуурайшилт ихтэй газар хуурайшилтанд тэсвэртэй өвс, өвслөг ургамал, намхан, нарийхан бут сөөг ургадаг.

³ https://jornada.nmsu.edu/files/Mongolia-Rangeland-health-Report_EN.pdf



Зураг 4 Монгол орны байгалийн бүс, бүслүүр

5.2.2 Уулархаг, өндөрлөг газрын экосистемийн төрлүүд – Тал хээрийн өвст тал, бэлчээрийн газар

198. Монгол орны зүүн бүсийн тал хээр газрын ихэнх өвст тал, бэлчээр газрыг Хуурай хээр, дунд зэргийн хуурай хээр, нуга тал хээр бүрдүүлж байдаг. Шинж чанарыг нь илэрхийлж байдаг амьтны гол төрөл зүйлийн хувьд: Монгол бөхөн гөрөөс, тарвага, Хонин тоодог, Талын бүргэд, Идлэг шонхор, Монгол болжмор зэрэг амьтад байна.
199. Өвст хээр талд хэдэн зууны туршид мал бэлчээрлүүлж ирсэн байдаг бөгөөд энэ нь тухайн системийн тогтолцоо, бүтэц, экологийн үйл ажиллагааны хувьд (шим тэжээлийн мөчлөг, залгамж чанар, эвдрэлийн горим) ноцтой утгыг илэрхийлж байдаг. Даацаас хэтрүүлэн бэлчээрлүүлсэн талбайг тэсвэр арай багатай өвс ургамлыг орлож, далдуур тоос хүртдэг ургамал - *Cleistogenes squarrosa*, *Carex duriuscula*, and some prostrate forbs зэрэг нэр төрлийн ургамал маш шигүү ургасан байдаг нь илэрхийлж байдаг. Хамгийн ноцтой доройтол нь зарим газрыг ямар ч үетэн өвсгүй нэг наст ургамлын бүрхэвчид бүрэн хувиргах чадалтай байдаг.

5.2.2.1 Хуурай өвст хээр тал

200. Энэ төрлийн өвст хээр талын тогтолцоо нь судалгааны талбайн доод түвшний түвшнээс дээш, далайн түвшнээс 550 - 1200 метрийн өндөрт байрлах хавтгай эсвэл аажмаар налуу үүссэн хөндийд үүсдэг. Хуурай өвст хээр талын экосистем нь хуурай нөхцөлд дасан зохицсон *Stipa krylovii*, *Stipa grandis*, *Agropyron cristatum*, *Cleistogenes squarossa*, *Elymus chinensis*, shrubs such as Харгана болон *Anabasis species*, өвслөг ургамал ургасан шинж тэмдэгээр илэрхийлэгддэг өвст ургамлын төрөл зүйлийн бүлгэмдэл бүхий газар нутгийг бүрдүүлж байдаг.
201. Дунд зэргийн түвшинд мал бэлчээрлүүлсэн талбайд өвст ургамлын төрөл зүйлийг *Artemisia* гэх нэртэй ургамал нийтлэг давамгайлсан байдаг. Хэт ихээр бэлчээрлүүлсэн талбай эсвэл гангийн нөхцөл байдлаар эргээд сэргэж байгаа газрын хувьд *Chenopodium spp*, and *Bassia dasyphylla* зэрэг нэг наст өвслөг ургамал давамгайлсан байх болно. Хаагдмал байрлалтай сав гарын хувьд хуурай хээр тал газар нь зах хавиараа *Achnatherum spp*, *Reamuria*, *Salsola*, *Nitraria* and *Allium* (mainly *A. scenescens* *A. mongolicum*) нэртэй ургамал бүрхсэн, давсархаг хотгор газрыг агуулсан байдаг. Жижиг налуу толгодын хувьд *Populus*, *Betula*, болон *Salix* зэрэг ургамал нөхөж ургасан хэсэг газруултай байдаг.

5.2.2.2 Бага зэргийн хуурай тал хээр газар

202. Хуурай тал хээр газартай нэгэн адил энэ өвст хээр бэлчээр газрын тогтолцоо нь тэгш хавтгай эсвэл бага зэрэг аажим налсан хөндийд байдаг боловч далайн түвшнээс дээш 550 - 1600 метрийн өндөртэй өндөрлөг газруудад байдаг. Ургамлын бүлгэмдлийн мозайк нь *Stipa*, *Festuca*, *Agropyron*, *Cleistogenes*, *Poa*, *Elymus*, *Koelaria* болон бусад өвс ургамлаас бүрдэх бөгөөд бусад дэд бүс нутгийн илэрц, хөрсний чийг, бэлчээрлэлтийн түвшин, болон бусад хүчин зүйлсээс шалтгаалан өөр өөр харьцаатай байна. Ургамлын нэг төрөл зүйлийн бүлгэмдэл нь *Filifolium sibiricum* and *Stipa baicalensis* зэрэг ургамал илэрдэг энэ төрлийн экосистемийн төрөл нь зүүн хойд бүс нутгийн шинж чанарыг илэрхийлж байдаг. Өөр нэг өргөн дэлгэрсэн бүлгэмдлийг өндөр өвст ургамал болох *Stipa grandis*, *Elymus chinensis* зэрэг ургамал хэв шинжийг нь төлөөлж байдаг. Харгана хэмээх бус сөөг нь ургамлын төрөл зүйлийн бүлгэмдэл нь хээр талын бүс нутаг даяаар ач холбогдолтой боловч илүү хуурай, бүдүүн ширхэгтэй хөрсийг илүүд үздэг байна, арай хуурай газруудад уулархаг нуга тал бүхий олон өвслөг ургамал байдаг ба хуурай хөрсний дээжийг бодвол илүү зузаан, хүчтэй органик гадарга бүхий илүү хар бараан кастанозем бүхий хөрстэй байдаг.

5.2.2.3 Нуга, хээр тал

203. Энэхүү нуга, хээр талын тогтолцоо нь ихэвчлэн ойт хээрийн доох нь талд байрлах өндөрлөг толгод дээр, судалгааны талбайн зүүн хойд зүгт 650 метрийн өндөр, өмнөд, баруун талаас 1700 метрээс цаана байдаг. Нуга, хээр тал нь Монгол-Манжуурын Өвст хээрийн Экобүс нутаг дахь ойт, ойт хээрийн тогтолцоо ба илүү хуурай өвст хээр тал бүхий өргөн уудам талбай хоёрын хоорондын шилжилтийн бүсийг төлөөлж байдаг. Энэхүү төрлийн тогтолцооны өргөн хүрээнд тархсан илэрц нь Монгол орны зүүн бүсийн Хянганы дов толгод болон Орхон голын эхний өндөрлөг толгод, тус бүс нутгийн баруун хязгаарын Тарнийн голын сав газарт илэрдэг. Жилийн хур тунадас, ойролцоогоор 300мм, зөвхөн багахан хэмжээнд тархсан модлог (*Ulmus* ба *Betulus* зүйлүүд) ургамлыг дэмжихэд хангалттай байдаг боловч, өвст ургамал, хагд өвс, дунд зэргийн ус шаарддаг өвс ургамал болон бут сөөг ихтэй ургамлын төрөл зүйлийн бүлгэмдлийг дэмжиж байдаг байна. Харьцангуй чийг шаарддаг төрлүүд нь арайн илүү өндөрлөг газарт ба хойд зүгийн налуу газарт байдаг бол арай хуурай төрлүүд нь арай нам дор газарт гүехэн хөрсөнд илүү дулаан орчинд илэрдэг. *Festuca lenensis* and *F. sibirica*, *Poa attenuata*, and *Helictotrichon schellianum* зэрэг ургамлуудын төлөөлөл их байдаг. Олон янзын өвс ургамал нь ботаникийн хувьд энэ газрыг маш баялаг болгодог бөгөөд үүнд *Artemesia*, *Thalictrum*, *Aster*, *Polygonum*, *Potentilla*, *Carex*, and *Gallium* genera зэрэг төрлийн ургамлууд байна. Эдгээрийн зарим нь шинэс ой эсвэл хайлаасны бутны онцлог шинж чанартай бөгөөд энэхүү тогтолцооны ихээхэн хэсгийн ойг нь огтлох болон хэт их мал бэлчээрлүүлэх зэргээс болж хувиргасан байх магадлалтай бөгөөд – энэ нь хэрэв модыг нь огтох болон даацаас хэтрүүлэн мал бэлчээрлүүлэх явдлыг хязгаарлаж чадвал эргээд модлог тогтолцоондоо орж болох юм.

5.2.2.4 Цөлөрхөг хээр

204. Цөлөрхөг хээрийн экосистемийн төрөл нь хойд бүс нутаг дахь судалгааны газрын 2%-ийг хамарч байгаа бөгөөд энэ нь Монгол-Манжуурын өвст хээр бүс нутаг болон Дүүн Говийн цөлөрхөг хээр талын бүс нутаг хоёрын хоорондын завсрын бүс нутгийг илэрхийлж байдаг.

205. Энэхүү экосистемийн төрөл нь Дорнын Говийн цөлөрхөг тал хээрийн эко бүс нутгийг төлөөлж байдаг бөгөөд энэ нь Алашанийн Тэгш өндөрлөг хагас цөлөрхөг эко бүс нутаг болон Монгол-Манжуурын харьцангуй чийглэг өвст хээр тал нутаг хоёрын хооронд оршдог. Ургамалшил нь ганд зохицсон бут сөөг, нимгэн тархсан бага өндөртэй өвс ургамал зэргээс бүрдэх нэгэн төрлийн шинж чанартай байдаг.

5.2.3 Өндөрлөг газрын экосистемийн бусад төрлүүд

5.2.3.1 Элсэн манхан толгод

206. Энэхүү динамик элсэн манхан, дов толгодын тогтолцоо нь бургас, хайлаас, псаммофитын өвс, өвслөг ургамал энд тэнд хэсэгчилэн ургасан олон янзын байдалтайгаар тогтсон байдаг. Ургамлын төрөл зүйлийн хувьд *Filifolium sibiricum*, *Stipa baicalensis*, *koelaria mukdenesis*, *Cleistogenes kitagawae*, *Armeniaca sibirica*, *Ulmus japonicas*, *Iris dichotomoa*, *Nemerocallis minor*, *Leymus chinensis*, *Vupleurum sorzonerifolium*, *Galium verum* байдаг. Элсэн манхан, дов толгодын хооронд тогтсон хотгорууд нь салхиар туугдан ирсэн их хэмжээний хаягдлыг тогтоон барьж, цасан шуурганаас тогтож үлдсэн их хэмжээний чийг хадгалах чадалтай байдаг тул –элсэн



манхан, дов толгодын ердийн амьдрах таатай орчинд байдгаас илүү өөр, дунд зэргийн чийг шаарддаг ургамлын бүлгэмдэлд илүү тохирсон бичил амьдрах орчныг бий болгодог байна. Элсэн дов толгодыг үндсэндээ илэрхийлж байдаг мод, бутнаас бүрэлдсэн манхан нь тухайн элсэн манханы үндсэн суурь системийг бий болгож байдаг бүтцийн тогтвортой байдалд түшиглэж байдаг олон тооны молтогчин амьтдын хувьд нэн чухал амьдрах таатай орчин болж чаддаг.

5.2.3.2 Галт уулын тогоо

207. Галт уулын тогоо бол түүхэн хугацаанд идэвхигүй болсон галт уулын яндан юм. Галт уулын баялаг хөрс нь хүрээлэн буй тал хээрийн экосистемээс илүү их хэмжээний ургамлын олон янз байдлыг нэмэгдүүлж, 28 ботаник бүл, 75 төрөл, 180 зүйлийн тэжээлийн болон эмийн чанартай ургамлуудыг тэтгэн дэмжиж өгдөг. Галт уулын тогоо нь олон тооны жижиг хөхтөн амьтад, хэвлээр явагчид, шувуудын төрөл зүйлийн амьдрах орчныг бүрдүүлж, чонон, үнэг, махчин шувуу зэрэг олон төрлийн махчин амьтдыг тэтгэж байдаг. Галт уулын тогооноос Аргаль болон олон тооны мэрэгч амьтдын төрөл зүйлийг олж болох бөгөөд тэдгээр тогоонуудын хоорондын хотгор, уулын бэлийн хөндийд бөхөн гөрөөс болон тарвага байдаг. Эдгээр байгалийн тогтоц нь хүмүүст чухал ач холбогдолтой болохыг нотолгоо бол "хүн чулуу" юм. Эдгээр түүхэн олдворуудыг хамгаалахын тулд нэг галт уулыг Тусгай хамгаалалттай газар болгон тогтоосон байдаг.

5.2.3.3 Boreal Forest: Хөвчит ой

208. Дэлхийн байгаль хамгаалах сангийн (2010) нийтлүүлсэн Зэрлэг амьтдыг хамгаалах асуудлын төлөв байдлын үнэлгээнд тайлбарласан Уулын болон Өндөр уулсын бүсийн хөвчит ойн экосистемийн дараах зургаан төрлүүд байна, үүнд:

- Өндөр уулын тундр
- Өндөр уулын нуга ба түүнээс арай доогуурх өндөр уулын ой хөвч
- Өндөр уулархаг тал
- Хөвчит уулархаг газрын шилмүүст ой
- Өндөр уулын навчит-шилмүүст ой хөвч
- Хөвчит дэд бүс нутгийн навчит-шилмүүст ой

5.2.4 Нуур ба намгархаг газрын экосистемийн төрлүүд

5.2.4.1 Томоохон голуудын татам

209. Том гол мөрөн, томоохон гол цутгалууд ихэвчлэн үерийн өргөн уудам татмуудыг буй болгодог. Түүхээс үзэхэд эдгээр татмууд нь голын эрэг хавийн өргөн навчит ой мод болон бут, сөөгийг дэмжиж өгсөн байдаг. Гэршүүлсэн малыг бэлчээрийн даацаас хэтрүүлэн маллах эсвэл байгалийн үер болон усны элэгдлийн улмаас биет эвдрэл үүсэхгүй л бол Salix төрлийн бут, сөөг ихээр ургах боломжтой. Модлог ургамал бүхий давхарга болон бут, сөөгний давхаргын хувьд улиас, хус, шинэс, бургас зэрэг зүйл хамгийн элбэг тохиолдоно. Эдгээр модлог ургамлын доод үе давхаргад ихэвчлэн чийглэг эсвэл үе үе чийг бүрдэж байдаг газарт өвслөг ургамал болон өвс ургах нь их холбоотой байдаг. Үерийн татмын тогтолцоонууд нь эх газрын болон усны орчны олон төрөл зүйлийн хувьд нэн чухал амьдрах орчин бөгөөд усны чанарыг хэвийн хэмжээнд байлгахад нэн чухал үүрэгтэй, мөн хэт их мал бэлчээрлүүлэх, уул уурхай эрхлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалтын улмаас амархан эвдрэлд орж байдаг.

5.2.4.2 Жижиг голын эрэг хавийн газрууд:

210. Энэ нь томоохон гол горхи руу цутгаж байдаг гол горхины дагуу байдаг шугаман зурвас нойтон нугыг бүрдүүлж өгч байдаг.

211. Хөрс нь газрын доорхи усны хэмжээ, хөрсний чийглэг хэвээр байх хугацаанаас хамаарч кристал глейсоллол эсвэл хагас глейсол бөгөөд ерөнхийдөө олон төрлийн бүтэцтэй хунгарласан тунамал болон органик биет ихтэй. Ургамлын бүрхэвч нь нягт, олон янз байдаг ба ургамлын ургац өгөх чадвар өндөр байдаг ба үүнд өвсөрхөг ургамал (Poa pratensis, Agrostis mongholica, Hordeum brevisubulatum, Phragmites, Carex, Eriophorum, Puccinellia, and Juncus species) and өвслөг ургамал (Iris, Geranium, Vicia, Ranunculus, Polygonum, Sanguisorba, and many others) элбэг бий. Бетула, шинэс улиас, ялангуяа саликс бут сөөг, жижиг мод нь системд тохиолдож болно. Гэршүүлсэн малыг бэлчээрийн даацаас хэтрүүлэн бэлчээрлүүлэхгүй байж, эсвэл байгалийн үер болон усны элэгдлийн улмаас биет эвдрэл үүсэхгүй л бол Salix төрлийн бут, сөөг ихээр ургах боломжтой.

5.2.4.3 Түр зуурын чийглэг хотгор газар:

212. Судалгааны газрын өмнө зүгт, хуурай, хаагдмал сав газарт энэ төрлийн нам дор хотгор газрыг бүрдүүлсэн байдаг бөгөөд энд усны түвшин газрын гадаргатай ойр байдаг. Давстай хөрс нь тодорхой ургамлын бүлгүүд ба амьдрах орчныг дэмжиж өгдөг. Өндөр ургадаг *Achnatherum* хэмээх зөөлөн хөрсөн дахь бутлаг ургамал нь нийтлэг үзүүлэлт бүхий ургамлын бүлгэмдлийг тодорхойлж байдаг.

5.2.4.4 Том нуурууд:

213. Эдгээр нь Востокова ба Гунин (2005) -ы зураглалаар судлагдсан газрын томоохон нуурууд юм. Үүний хамгийн том жишээ бол Буйр нуур, Яхь нуур, Хөх нуур юм. Эдгээр нуурууд болон холбогдох намгархаг газрууд нь усан орчны онцгой биота буюу тухайн бүс нутгийн ургамал, амьтны аймгийг дэмжиж байдаг бөгөөд Сибирийн тогоруу (CR), Цэн тогоруу (VU), Хар тогоруу (VU), Хун галуу (VU), Хонин тоодог, Реликт цахлай зэрэг усны шувуудын үүр, нүүдлийн замд буудаллах чухал цэг нь юм. VU) (Нямбаяр болон Цэвээнмядаг 2009).

5.2.4.5 Жижиг нуур, усан сан бүхий газар:

214. Судалгааны талбайн урд хэсэгт хуурай хаагдмал сав газарт эдгээр жижиг устай газрууд нь ихэвчлэн давсархаг эсвэл шүлтлэг байдаг. Том нууруудын нэгэн адил эдгээр устай газрууд болон холбогдох намгархаг газрууд нь ихэвчлэн онцгой усан биота буюу тухайн бүс нутгийн ургамал, амьтны аймгийг дэмжиж байдаг бөгөөд усны шувуудын хувьд үүрлэх, буудаллах нэн чухал газар нь болдог.

5.2.4.6 Рамсарын конвенцоор хамгаалагдсан намгархаг газар

215. Одоогийн байдлаар Монгол улс нь 11 газрын олон улсын хувьд чухал ач холбогдолтой намгархаг газар хэмжээн тогтоогоод байна (Рамсарын конвенцоор хамгаалсан газрууд) (Зураг 5). Энэхүү конвенц нь 1998 оны 4-р сарын 8-ны өдөр манай улсад хүчин төгөлдөр болсон.



Зураг 5 Монгол улс дахь Рамсарын конвенцоор хамгаалагдсан газрууд

216. Рамсарын конвенцоор хамгаалагдсан таван газрууд төслийн зорилтот аймгуудад байдаг:

- НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын зүгээс Монгол Дагуурын – хээр тал газар болон намгархаг бүс нутгийг Дэлхийн биомандалын нөөц газар буюу Рамсарын конвенцоор хамгаалсан газар хэмээн жагсаасан. Энэ газрыг Монгол улсын хамгаалагдсан газрын хамрах хүрээнд Дархан цаазат газар хэмээн ангилсан байдаг. Энэ нь IUN ангиллын 1b гэж явдаг (зэрлэг онгон байгалийн бүс).
- Буйр нуур – Монгол улс болон БНХАУ улсын хилийг дамнан байрладаг цэнгэг уст нуур.
- Айраг нуур нь хоорондоо уялдаа холбоотой нууруудын системийн нэг хэсэг болох Их нууруудын хотгорт оршдог.
- Хар ус нуур – нь хоорондоо уялдаа холбоотой нууруудын системийн дээд хэсэгт байх бөгөөд (Их нууруудын хотгорт) үүнд Айраг нуур ордог. Үүнд цутгадаг үндсэн гол нь Ховд гол.




- Ганга нуур - Сүхбаатарын Дарьганга суманд байрладаг давстай нуур. Нуур нь өмнөд бүсийн тал хээр болон Говь цөлийн хоорондох шилжилтийн бүсэд оршдог. Нуур ба түүний намгархаг газар нь устах аюулд ороод байгаа ховордсон нүүдлийн шувуудын үржлийн ба буудаллаг чухал газар юм.

5.2.5 Тусгай хамгаалалттай газар

Тусгай хамгаалалттай газрыг дөрөв ангилдаг (Зураг 6). Тэднийг ач холбогдлын дарааллаар нь:

- **Дархан цаазат газар (ягаан)** – Нэн чухал ач холбогдолтой маш эмзэг газар; ан агнах, мод бэлтгэх, бүтээн байгуулалтын ажлыг хатуу хориглодог бөгөөд хүний нөлөөнд өртсөн зүйл байхгүй.
- **Үндэсний байгалийн цогцолбор газар (цэнхэр)** – Түүх болон боловсролын ашиг сонирхлын хувьд чухал газрууд; нүүдэлчин нутгийн ард иргэдийн хувьд загас агнах болон малаа бэлчээрлүүлэхийг зөвшөөрсөн байдаг бөгөөд цэцэрлэгт хүрээлэнгийн зарим хэсгийг эко аялал жуулчлалын зорилгоор хөгжүүлсэн байдаг.
- **Байгалийн болон түүхэн дурсгалт газрууд (ягаан)** - Түүх соёлын хувьд чухал газрууд; удирдамжийн хүрээнд бүтээн байгуулалт хийхийг зөвшөөрнө.
- **Байгалийн нөөц газар (ногоон)** – Ургамал, амьтны ховор төрөл зүйл болон археологийн дурсгалт газруудыг хамгаалах хүрээнд арай бага ач холбогдолтой бүс нутаг, тодорхой удирдамжийн хүрээнд зарим бүтээн байгуулалтыг зөвшөөрсөн байдаг.

Төслийн зорилтот аймаг тус бүрт байдаг тусгай хамгаалалтын газруудыг дор тайлбарласан байгаа⁴.



Зураг 6 Монгол улс дахь Тусгай хамгаалалттай газрууд

5.2.5.1 Хөвд аймаг дахь тусгай хамгаалалттай газрууд

- **Булган голын Байгалийн нөөц газар** (1,840 га). Хятадтай баруун өмнөд зүгээр хиллэж байгаа дээр байдаг бөгөөд үүнийг усны булга (минж), мөнгөн сортой хар булга, хадны цагаан элэгт суусар зэргийг хадгалан хамгаалах зорилгоор байгуулагдсан.
- **Их Говийн дархан цаазат газар** ('Говийн Б' гэгддэг) Хулан (зэрлэг илжиг), зээр, алагдаахай, тахи (зэрлэг адуу) -ийг хамгаалах зорилгоор байгуулсан.
- **Хар Ус Нуур Үндэсний байгалийн цогцолбор газар** (850,272 га). Гөрөөс болон хотон шувуу, шонхор, тоодог зэрэг нүүдлийн ховор шувуудын төрөл зүйлийн үржлийн газар болсон энэ газрыг хамгаалдаг.

⁴ https://www.legendtour.ru/eng/mongolia/informations/flora_and_fauna.shtml



- **Хөх Сэрхийн Дархан цаазат газар** (65,920 га). Баруун хойд талаараа Баян Өлгий аймагтай хиллэдэг. Энэ нь аргаль хонь, янгир, цасны цоохор ирвэсийг хамгаалахад тусалдаг.
- **Манхан Байгалийн нөөц газар**. Ховд хотын зүүн өмнөд хэсэг нь нэн ховордсон устах аюулд өртөөд буй зээр, гөрөөсийг хадгалан хамгаалдаг газар.
- **Цамбагарав уулын Байгалийн цогцолбор газар** (110,960 га). Энэ нь 2000 онд Баян-Өлгий аймагтай хил залгуулан байгуулагдсан. Энэ нь цоохор ирвэсийн амьдрах орчныг хамгаалдаг.

5.2.5.2 Дорнод аймаг дахь Тусгай хамгаалалттай газрууд

- **Дорнод Монгол** (570,374 га). Хялганатын экосистем болон цагаан гөрөөсний амьдрах таатай орчныг хамгаалах зорилгоор 1992 онд Улсын бага хурлын тогтоолын дагуу тус бүс нутгийг хамгаалалтын бүс болгон байгуулжээ. Энэ газарт Матад, Халх-Гол, Эрдэнэцагаан сумдыг оруулаад 570,300 га талбайг хамардаг. Энэ нутагт элсэн толгод, үзэсгэлэнтэй домогт уулс, 153 зүйлийн ургамал, 26 төрлийн хөхтөн амьтад байдаг. Шонхор шувуу гэх мэт зарим ховор шувууд нүүдэллэж байх замдаа энэ хавиар нисэж өнгөрдөг байна.
- **Нөмрөг (Нөмрөгийн нөөц газар)** (311,205 га). Тус хамгаалалтын бүсэд хилийн дагуух Хянган нурууны ой мод, хээрийн бүсийн 311,200 га газрыг хамардаг. Энэ нь 1992 онд ургамал, амьтны аймаг, усан сан бүхий газрыг хамгаалах зорилгоор байгуулагдсан. Тус газар нь ховор төрлийн буга, могой, сохор номин, халиу, хүрэн баавгай, зэрлэг нугас, бүргэд, шонхор шувуу, тогоруу, аварга тас зэрэг ховор зүйлийн төрөл зүйлүүд байдаг.
- **Монгол Дагуур** (103,016 га). 1992 онд энэхүү бүс нь ургамал, амьтан, ялангуяа нүүдлийн болон усны шувууд элбэг байгалийн хүрээлэн буй орчин, тал хээр, усан зам, намаг бүхий газруудыг хамгаалах зорилгоор болон судалгаа шинжилгээ хийх зорилгоор хамгаалалтын бүс болгон байгуулав. Үүнийг 1994 онд Монгол-Орос-Хятад улсуудын хамтарсан Дагуурыг хамгаалах газар болгон өргөжүүлж, Зүүн хойд Азийн тогорууг хамгаалах олон улсын сүлжээнд оруулсан. Тусгай хамгаалалтын бүс нь Чулуунхороот, Дашбалбар, Гурванзагал сумыг багтаасан 103,000 га газрыг хамардаг. Зүүн хойд Азийн ховор, хар, цагаан өнгийн болон бусад төрлийн тогоруунууд нь өндгөө энд дарж, нүүдлийн үеэрээ олон тоогоор цуглуулдаг.
- **Яхи нуурын Үндэсний байгалийн цогцолбор газар**. Энэхүү бүс нь цагаан гөрөөс, усны шувуудын дамжин өнгөрч буй газрыг хамгаалах зорилгоор 1998 онд хамгаалалтын бүс болгон байгуулжээ. Тус хамгаалалтын бүсэд багтдаг Чойбалсан, Сэргэлэн, Гурванзагал сумдын хилийн ойролцоох газрыг хамарсан 251,388 га газар нутагтай. Цагаан гөрөөс, чоно, тарвага, хээрийн үнэг гэх мэт олон тооны амьтадаас гадна нүүдлийн болон суурин шувууд мөн хад толгод, хөндий, уул бүхий гайхалтай байгалийн үзэсгэлэнт газрууд байдаг.
- **Угтам уулын Үндэсний байгалийн цогцолбор газар**. Угтам уулыг 1993 онд байгалийн хүрээлэн буй орчин болон ургамал, амьтны аймгийг хамгаалах зорилгоор тусгай хамгаалалтад авсан. Энэ уул нь Баяндун, Дашбалбар сумдуудад оршдог.
- **Тосон хулстай Үндэсний байгалийн цогцолбор газар**. Тосон Хулстай нуурын эргэн тойрны Цагаан-Овоо, Хөлөнбуйр, Баянтүмэн сумдын 470 000 га талбайг 1998 онд цагаан гөрөөсний гол нөөц газар болгон хамгаалах газар болгосон. Энд ховор төрлийн ургамал болох нохойн хошуу, цахирмаа цэцэг, Сибирийн хялгана, мөн олон тооны ургамлын төрөл зүйл болон ховор тогоруу, талын тоодог, зараа зэрэг амьтад байдаг.

5.2.6 Ургамал ба амьтан.

217. Монгол орны ургамлын аймагт бараг 150 төрлийн тухайн орон нутгийн шинжтэй ургамлууд болон бараг 100 эртний төрөл зүйлс байдаг. 100 гаруй төрлийн ургамлын зүйл нь Монгол Улсын Улаан номонд ховор болон устах аюулд өртөөд буй нэн ховордсон жагсаалтад багтжээ. Ургамалшилтайгаа адилхан, Монгол орны амьтдын аймаг нь Сибирийн хойд тайга, тал хээр, Төв Азийн цөл газруудын холимог төрөл зүйлсийг төлөөлж байдаг. Амьтдын аймагт 136 төрлийн хөхтөн амьтдын төрөл зүйл, 436 төрлийн шувууд, 8 төрлийн хоёр нутагтан, 22 төрлийн хэвлээр явагч амьтад, 75 төрлийн загас болон олон тооны сээр нуруугүй амьтад багтаж байдаг.
218. Төв Азийн бүс нутгийн шинжтэй төрөл зүйлс үндсэндээ Говь болон цөлөрхөг тал хээр нутгаас олддог бөгөөд, үүнд Соргог бөхөнгийн (*Tatarica mongolica*) Монголын дэд төрөл зүйл, Төв Азийн шинж чанартай алагдаахай болон оготнын дөрвөн зүйл багтдаг. Шувуудын хувьд Алтайн хойлог

(*Tetraogallus altaicus*), Козловын дууч болжмор (*Prunella kozlovi*) багтдаг. Төв Азид амьдардаг эндхийн хэвлээр явагч найман зүйл багтдаг. Тухайн орон нутгийн шинжтэй загасны хувьд Алтай Осман *Oreoloeuciscus potanini* болон Mongolian балиус загас (*Thymallus brevirostris*) багтдаг. Дэлхийн хэмжээнд устах аюулд өртөөд буй нэн ховор олон төрөл зүйлүүд Монгол улсаас олддог.

5.2.6.1 Монгол орны ургамлын аймаг

219. Үүнд ургамлын аймагтай холбоотой гурван онцгой төрөл байдаг – өвс, бут сөөг (газрын гадаргуугийн 52%), ой (15%), цөлөрхөг бүсийн ургамал (32%) зэрэг гурван төрлийн экосистем байдаг. Монгол орны газар нутгийн 1%-ээс бага хувьд нь газар тариалан болон хүн ам суурьшсан байдаг.
220. **Ой мод** - Монгол орны ой модны байгалийн нөхөн сэргэлт удаан, ширүүн уур амьсгалын улмаас ой нь гал түймэр, шавьжийн улмаас ихэвчлэн гэмтдэг. Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 8.1% хувь нь нийт 140 зүйлийн мод, бут сөөг, модлог ургамал бүхий ойгоор бүрхэгдсэн байдаг. Хойд хэсэгтээ ургадаг шинэс, нарс, эсвэл хус байна уу, Говь цөлийн заг байна уу модыг түлшний эх үүсвэр болгон ашигладаг. Барилга барих үүднээс нутгийн хойд хэсгээр гуалин модыг огтолдог.
221. **Найлзуур ургамал болон Доод ургамал** – Үүнд 2823 төрлийн найлзуур ургамлын төрөл зүйл, 445 төрлийн хөвд, 930 төрлийн булцуут ургамал, 900 төрлийн мөөг, мөөгөнцөр, 1236 төрлийн замагны төрөл ургадаг байна. Үүнээс 845 төрлийн ургамлыг Монгол оронд эмийн зорилгоор хэрэглэдэг, 1000 төрлийг нь малын тэжээлд, 173 төрлийг нь хүнсэнд, 64 төрлийг нь үйлдвэрлэлд хэрэглэдэг байна. Одоогоор 1997 онд Монгол Улсын Улаан номонд орсон, нэн ховордсон болон устах аюулт өртөөд буй гэж нэрлэгддэг 128 зүйлийн ургамал бий. Үүнээс 75 зүйл нь эмийн ургамал, 11 нь хүнсний, 16 нь үйлдвэрлэлийн зорилгоор ашиглаж байна.

5.2.6.2 Монгол орны амьтны аймаг

222. Монголд 133 хөхтөн амьтан байдаг бөгөөд тэдгээрийн ихэнх нь Төв Ази болон Монгол орны шинж чанартай амьтад бөгөөд тэдгээрийн дотор Монгол оготно, Монгол үлийн цагаан оготно, Говийн алагдаахай, Козловын атигдаахай, Монгол алагдаахай, Монгол орог зусаг/шишүүхэй байдаг. Цагаан сүүлт бөхөн гөрөөс, Соргог бөхөн, Тахь буюу Пржевальскийн адуу, минж, Сибирийн янгир ямааг тухайн ховордсон газар нь дахин нутагшуулсан байна.
223. Монгол улсад 400 гаруй зүйлийн шувуу амьдардаг. Монгол орны хамгийн түгээмэл шувуу бол саарал өнгийн бие, хар толгой, цээжтэй, цагаан тус үстэй (*demoiselle*) тогоруу юм. Хээр талын бусад төрөл зүйлд олон төрлийн өвөөлж, тас, Шилийн сар, талын бүргэд, идлэг шонхор, хар элээ, шар шувуу/ууль, харцага орно. Уулархаг бүс нутагт цагаан ятуу, бялзуухай, тоншуул, шар шувуу/ууль, Алтайн бүсийн шинжтэй хойлог бий. Баруун болон хойд бүс нутгийн нууруудад борцгор хотон, хар тогоруу, реликт цахлай, толгойндоо тууш судалтай галуу бий. Монгол орны зүүн бүс нутагт хар тогоруу болон Сибирийн төрөл зүйл зэрэг тогорууны популяцийн хамгийн том үржлийн цугларалт болдог бөгөөд үүнд мөн зэрлэг байгальд ердөө 4500 ширхэг үлдээд буй, устах аюулд өртөөд буй нэн ховор цэн тогоруу байдаг байна.
224. Сэлэнгэ, Орхон, Завхан, Балж, Онон, Эгийн гол зэрэг гол мөрөн, түүнчлэн Хөвсгөл нуур зэрэг олон арван нууранд 380 орчим зүйлийн загастай байдаг. Үүнд хулд загас, балиус загас (хулд загас), улаан нүдэн загас, ленок, Сибирийн хилэм загас, цурхай, алгана загас, Алтайн бүсийн шинжтэй нохой сугас, аварга том тул загас, мөн 1.5 метр урт, 50 кг жинтэй яргай загасны Сибирийн төрөл байдаг.

5.2.6.3 Устах аюулд өртөөд буй төрөл зүйл

225. Монгол оронд 28 төрлийн устах аюулд өртөөд буй хөхтөн амьтад байдаг. Үүний дундаас нийтлэг мэддэг төрөл зүйл нь хулан, хавтгай, Говийн аргаль, Говийн мазаалай, янгир, хар сүүлт бөхөн гөрөөс, мөн халиу минж, чоно, зээр гөрөөс, алагдаахай байна.
226. Мөн нэн ховордсон шувуудын 59 зүйл байдаг бөгөөд үүнд олон зүйлийн шонхор, сар шувуу, тогоруу, ууль/шар шувуу байдаг. Цэн тогоруу нь устах аюулд өртөөд байгаа. Тахь буюу Пржевальскийн адуу нь хэрэг дээрээ 1960-аад оны үед устаж үгүй болсон байв. Үүнийг гадаадад өргөн хүрээний үржүүлгийн хөтөлбөр хэрэгжүүлсний дараа хоёр ширхэг байгалийн цогцолбор газарт амжилттайгаар эргэж нутагшуулжээ. Уулын бүсийн хамгаалалттай газарт 1000 орчим цасны цоохор ирвэс үлджээ.



5.2.6.4 Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

227. Дараагийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг төслийн боловсруулахад зориулан тогтоосон байна, үүнд:

- Тодорхой заасан чөлөөлөх хил хязгаарын гадуур ямар нэгэн байдлаар ургамалшилыг чөлөөлөх ёсгүй,
- Төслийн үйл ажиллагаанаас болж байгалийн амьтны аймагт ямар нэгэн үхэл хорогдол учруулж болохгүй,
- Усан орчны болон эх газрын амьдрах таатай орчинд ямар нэгэн хортой нөлөөлөл үзүүлэхгүй,
- Барилгын үйл ажиллагааны улмаас ямар нэгэн хогийн ургамал, шарилжны төрөл зүйлийг нэвтрүүлэхгүй байх,
- Барилгын үйл ажиллагааны улмаас төслийн үлдээсэн ул мөрний дотор болон гадуур нь одоогоор байгаа хогийн ургамал, шарилжны тархалтыг нэмэгдүүлэхгүй байх,

5.2.6.5 Хяналт шинжилгээ

228. Ургамал, амьтны аймагт хяналт шинжилгээ хийх хөтөлбөр хэрэгжүүлнэ (Хүснэгт 7).

229. Хогийн ургамлын хяналт тавьж, гадны болон хор хөнөөлтэй төрөл зүйлийг олж тогтоовол зохих арга хэмжээг авна.

230. Ажлаа хийж байхдаа гүйцэтгэгч байгууллага нь БОАЖЯ болон ХХААХҮЯ-нд дараах зүйлсийг тусгасан, долоо хоног тутмын тайланг гаргаж өгнө, үүнд:

- Энэхүү БОНҮНМБХХ-ийн зарчимд үл нийцсэн аливаа асуудал,
- Өмнөх долоо хоногт нөхөн сэргээлт хийсэн газрууд,
- Залруулах үйл ажиллагааг авч хэрэгжүүлсэн нарийвчилсан мэдээлэл,

5.2.6.6 Тайлагнах

231. Бүх л ургамал, амьтны аймгийн хүрээнд нийж буй хяналт шинжилгээ ба/эсвэл осол хохирлуудын мэдээллийг шивж оруулаад БОНҮНМБХХ-нд заасны дагуу тайлагнана. Байгалийн амьтны аймагт хорогдол гарах, ургамалшилд хор хөнөөл учруулсан аливаа сэжигтэй тохиолдол гарсан тохиолдолд БОАЖЯ болон ХХААХҮЯ-нд мэдэгдэнэ.



**Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ**
GREEN CLIMATE FUND FUNDING PROPOSAL
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ

Хүснэгт 7 Ургамал ба амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг бууруулах менежментийн арга хэмжээ

Асуудал	Хяналтын үйл ажиллагаа (ба эх үүсвэр)	Арга хэмжээ авах цаг хугацааг сонгох	Үүрэг хариуцлага	Хяналт шинжилгээ ба тайлагнал
FF1. Амьдрах орчин алдагдаж, ургамлын аймагт эвдрэл үүсгэх	FF1.1 Хангалттай хэмжээнд хамгаалалт хийж, хадгалж авч үлдсэн ургамалшилийн менежмент хийх замаар, ургамлын бүрхэвчид чөлөөлж буй үйл ажиллагааг хязгаарлаж, амьдрах орчинд эвдрэл саад учруулж буй нөхцлийг бууруулах.	Барилгын ажлын явцад	Хээрийн/талбайн ажилтан	Өдөр тутам ба бүртгэл хөтлөх
	FF1.2: Аливаа эмзэг газруудын ойролцоо барилга байгууламж барих, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх замаар үүссэн дуу чимээний түвшин болон гэрэлтүүлгийн халдлагыг бууруулах,	Барилгын ажлын явцад	Хээрийн/талбайн ажилтан	Өдөр тутам ба бүртгэл хөтлөх
	FF1.3: Хээр талбайд ажиллаж байгаа бүх бие бүрэлдэхүүн эмзэг ургамал, амьтны аймгийн оршиж буй газрууд болон эдгээр газруудыг хамгаалах шаардлагуудын талаар мэдлэгтэй байх нөхцлийг хангаж ажиллах.	Барилгын ажлын явцад	Гэрээт гүйцэтгэгч	Өдөр тутам ба бүртгэл хөтлөх
	FF1.4 Тухайн газарт амьтны аймгийг нь сүйтгэж байгаа ашиглалтын үйл ажиллагааг багасгаж, барилга болон үйл ажиллагааны явцад гэмтсэн эсвэл өнчирсэн амьтдыг нөхөн сэргээж, аврах.	Барилгын ажлын явцад	Гэрээт гүйцэтгэгч	Өдөр тутам ба бүртгэл хөтлөх
FF2. Ургамал болон хогийн ургамал/шарилжны төрөл зүйл нэвтэрсэн бол	FF2.1: Усны урсац замаар орж ирж, улмаар тархаж байгаа хөрсний элэгдэл болон тунамал, хуримтлалаар дамжин тархаж буй шарилж, хогийн ургамлын тархалтыг бууруулах Хөрсний элэгдэл болон тунамал, хуримтлалыг хянах төлөвлөгөөг (ESCP) хэрэгжүүлэх.	Барилгын ажлын өмнө болон явцад	Гэрээт гүйцэтгэгч	Бүртгэл хөтлөх
	FF2.2: Амьдрах таатай орчны хувьд өндөр үнэ цэнэтэй, нутгийн уугуул болон орон нутгийн шинж чанартай төрөл зүйлийг ашиглан, сүйдсэн газрыг дахин ургамжуулах.	Барилгын ажлын явцад	Хээрийн/талбайн ажилтан	Шаардалагтай үед нь, мөн бүртгэл хөтлөх



**Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ**
GREEN CLIMATE FUND FUNDING PROPOSAL
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ


FF2.3: Ялангуяа лаврийн мод зэрэг бие гүйцсэн үлдэгдэл ургамалшилд эвдрэл үзүүлж буй үйлдлийг багасгах	Барилгын ажлын явцад	Хээрийн/талбайн ажилтан	Өдөр тутам ба бүртгэл хөтлөх
FF2.4: Үрийн хувьд хогийн ургамал, шарилжгүй болгох.	Үйл ажиллагаа	Хээрийн/талбайн ажилтан	Бүртгэл хөтлөх
FF3. Нүүдлийн зам болон байгалийн баялгийн хүртээмж	Барилга / Үйл ажиллагаа	БОАЖЯ	Бүртгэл хөтлөх

5.3 Гүний ус

5.3.1 Суурь өгөгдөл

5.3.1.1 Геологи

232. Монгол орны суурь геологийг Зураг 7-д харуулав.



Зураг 7 Монгол орны геологи

5.3.1.2 Гүний ус

233. Монгол орны гидрогеологийн газрын зураг нь (1) Кембрийн өмнөх эриний метаморфик ба талст чулуулгаас бүрдсэн суурь цогцолбор болон Палеозойн далайн болон галт уулын чулуулаг болон (2) Пермийн, Мезозойн/дунд төрмөлийн эрин, Кайнозойн/шинэ төрмөлийн эриний “тойрон хүрээлж буй эсвэл бүрхэж буй давхарга” бүхий суурь хоёрыг ялган харуулж өгсөн байна.
234. Гүний усыг хоёр төрлийн уст/усагсан давхаргаас хийсвэрлэн зураглав. Хамгийн өндөр гарцтай уст давхаргууд нь голын хандий даган байрладаг Дөрөвдөгч галавын голын/аллювын хурдасны үйрмэг/мөхлөг уст давхаргууд юм. Эдгээр хурдас оршин байдаггүй эсвэл усны нөөцийн тэжээмж/арвижуулалт нь хангалтгүй газар бол гүний усыг, хамгийн чухал хурдас болох Цэрдийн галав буюу ан цав, завсартай уст давхаргаас хийсвэрлэн зураглаж гаргав.⁵
235. Төсөлтэй холбоотой гүний усны судалгааг хийгээгүй байгаа боловч, гүний усны төлөв байдлыг талаар тодорхой мэдээлэл өгч чадах хэд хэдэн судалгаанууд байдаг байна.
236. Монгол орны хувьд сэргээгдэх боломжтой гүний усны нөөц тун хязгаарлагдмал юм. Ашиглаж болохуйц гүний усны үндсэн эх үүсвэр болон нөөц баялаг бол дарагдмал ус бөгөөд эмзэг, жишээ нь Монгол орны Говь болон Өвст хээрийн хуурай газруудад байдаг.

⁵ Ministry of Environment and Green Development (2013) Integrated Water Management Plan of Mongolia



Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ

237. Гүний усны нөөцийн тэжээмж/арвижуулалт болон тэнцвэр нь уур амьсгалын нөхцөл байдал болон уст давхаргаас хамаардаг. Гүехэн гүний ус нь голын дэвсгэр болон хотгор газрын мөхлөг уст давхаргаас гол төлөв бүрдэж байдаг бөгөөд энэ нь хур борооны усны нэвчилтээр тэжээгдэж, арвижиж байдаг байна. Борооны ус нь дээд уст давхаргад нэвчиж, булаг шанд руу урсдаг; ургамал, цөөрмийг тэжээдэг ба үүнийг гүехэн худгуудаар төлөөлүүлэн хийсвэрлэн зураглав. Багахан хэсэг нь гүн уст давхаргад нэвчдэг. Гүний уст давхаргууд нь ус нэвчүүлэх чадвартай чулуулаг хэсгүүд байдаг бөгөөд үүнээс гүний усыг хийсвэрлэн зураглаж болно. Гүнд байгаа уст давхаргууд нь 1,000-35,000 жилийн настай дарагдмал ус байх бөгөөд, ж нь, Дорнод аймагт байгаа гүний ус 1,000 жилийн настай гэж хэмжигдсэн байдаг. Гүний усны нас нь бүс бүсээсээ хамаардаг.

5.3.1 Гүйцэтгэлийн шалгуур

238. Төсөлд гүйцэтгэлийн дараах шалгуур үзүүлэлтүүдийг тогтоосон болно:

- Төслүүдтэй ойр байрших барилгын ажил болон ашиглалтын үйл ажиллагааны улмаас гүний усны чанар болон тоо хэмжээнд мэдэгдэхүйц буураагүй байх,
- Тухайн газартай холбоотой Хөрсний элэгдэл, ус хурах сав газар, тунадасны хяналтын төлөвлөгөө (Erosion, Drainage and Sediment Control Plan -EDSCP) болон гүний усыг хамгаалах бусад арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх.

239. Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийн менежментийн бүтэц, хамрах хүрээнд (БОНҮНМБХХ-ESMF) заасан дараах менежментийн арга хэмжээг дагаж мөрдсөнөөр төсөл нь усны чанарт өргөн хүрээнд мэдэгдэхүйц нөлөөлөл үзүүлэхгүй юм.

5.3.2 Хяналт, шинжилгээ

240. Гүний усны хяналт, шинжилгээний шаардлагын тухайд Хүснэгт 8-ийг үзнэ үү.

241. Төслийн явцад гүний усны чанарыг эхлээд нэг үнэлээд, дараа нь дор хаяж жил бүр үнэлж дүгнэх ёстой. Суурь өгөгдөл мэдээллийг гаргаж ирж мөн зорилтын дагуу ашиглахад тохирсон байдлыг баталгаажуулахын тулд эхний үнэлгээнд олон тооны параметруудийг (жишээлбэл, усны гүн, рН, DO, усны цахилгаан дамжуулах чанар, нитрат, фосфат, ялгадасын колицит, хүнд металл, булингар, нүүрсустөрөгч) багтаасан байх ёстой. Дараагийн хяналтын параметруудийг хэрэгцээ шаардлага гарсан үед нь тодорхойлно.

242. Үргэлжилж байх хяналт, шинжилгээг цооногуудын ашиглалтын үйл ажиллагааны нэг хэсэг нь болох ёстой.

5.3.3 Тайлагналт

243. Усны чанарын хяналт шалгалтын үр дүн болон / эсвэл ослын талаархи дүнг БОНҮНМБХХ-т тусгасны дагуу нэгтгэн шивж оруулан мөн тайлагнаж байх болно. Байгаль орчинд ямар нэгэн материаллаг эсвэл ноцтой хор хохирол учруулсан, эсхүл усны чанартай холбоотойгоор тогтоосон байсан тодорхой түвшнээс хэтэрсэн асуудал гарсан тохиолдолд БОАЖЯ болон ХХААХҮЯ-д нэн даруй мэдэгдэх шаардлагатай.



GREEN
CLIMATE
FUND

Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ

Хүснэгт 8 Гүний усанд үзүүлэх нөлөөллийн менежментийн арга хэмжээ

Асуудал	Хяналтын үйл ажиллагаа (болон эх үүсвэр)	Арга хэмжээ авах хугацаа	Үүрэг хариуцлага	Хяналт, шинжилгээ болон тайлагнал
GW 1: Гүний ус ба/эсвэл гадаргын усны орчинд нийт бохирдуулагч, нүүрсустөрөгч, металл болон бусад химийн бохирдуулагч бодис нэмэгдэх	GW1.1: Гүний усны чанарын өөрчлөлтийг хэмжиж үзэх зэрэг гүний ус нөлөөлөлд өртөх магадлалтай газруудад, гадаргын болон гүний усны чанарын хяналт, шинжилгээг тогтмол хийдэг байх.	Барилгын болон ашиглалтын үе шатанд	Хээрийн/талбайн ажилтан	БОАЖЯ, ХХААХҮЯ, НҮБХХ-үүдэд тайлагнахыг шаардсан байдгийн дагуу анхан шатны шинжилгээ хийх
	GW1.2: Бохирдсон гадаргын ус цооног болон худгуудаар дамжин уст давхарга руу орохоос урьдчилан сэргийлэх – үүнийг урсац, үерийн уснаас хамгаалж мөн орчин тойрныг цэвэр цэмцгэр байдгах.	Бүх үе шатанд	Бүх хүн хүч	Долоо хоног тутам
	GW1.3: Шатахуун, тос, химийн бодис эсвэл бусад аюултай шингэнийг хадгалах зориулалттай агуулах газрууд нь бин битүү, нэвтрэх боломжгүй, нягтруулсан суурьтай байх ёстой бөгөөд ямар нэгэн асгарах тохиолдлоос хамгаалахын тулд эргэн тойронд нь далан, шороо овоолсон байна.	Барилгын болон ашиглалтын үеийн бүх л үе шатанд	Бүх хүн хүч	БОАЖЯ, ХХААХҮЯ, НҮБХХ-үүдэд тайлагнах бүртгэл хөтлөх
	GW1.4: Бүх тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, материал хадгалж агуулдаг газруудыг өдөр бүр шалгаж, шатахуун, тос, химийн бодис урсаж, алдагдах боломжтой эсэхийг шалгах. Усны системээс хол зайтай, зориулагдсан газруудад түлшээ цэнэглэх ажлыг хийж гүйцэтгэнэ.	Бүх л үе шатанд	Бүх хүн хүч	Өдөр бүр бүртгэл хөтлөх
	GW 1.5: Усны чанар болон амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл хамгийн бага түвшинд, зөвхөн биологийн задралд ордог гербицидийг ашиглаж, ер нь гербицидийн хэрэглээг багасгах. Зөвхөн зааврын дагуу ашиглах.	Бүх л үе шатанд	Бүх хүн хүч	Бүртгэл хөтлөх


Асуудал	Хяналтын үйл ажиллагаа (болон эх үүсвэр)	Арга хэмжээ авах хугацаа	Үүрэг хариуцлага	Хяналт, шинжилгээ болон тайлагнал
GW2: Гүний усны чанар, хэмжээ	GW2.1: Зорилтот ашиглалтын хувьд усны чанар нь тохиромжтой эсэхийг баталгаажуулах.	Барилгын болон ашиглалтын үе шатанд	БОАЖЯ	Эхний туршилт хийгдэж, дараа нь шаардлагын дагуу БОАЖЯ-д тайлагнах
	GW2.2: Тогтвортой хэрэглээний нөхцлийг тодорхойлохын тулд гүний усны нөөцийн нас болон тэжээгдэх магадлалыг тодорхойлох. Тогтвортой урсгалын хэмжээг тогтоохын тулд насосны туршилт хийх шаардлагатай.	Барилгын үе шатанд	БОАЖЯ	Бүртгэлээ хөтлөх
	GW2.3: Хэт их олборлолт байлгахгүйн тулд гүний усны түвшинг хянаж байх.	Ашиглалтын үе шатанд	БОАЖЯ	Жил бүр, Бүртгэлээ хөтлөх

5.4 Гадаргын ус

5.4.1 Үндсэн суурь үзүүлэлтүүд

5.4.1.1 Гол, мөрөн

244. Монгол улсын гадаргын усны нөөц нь гол мөрөн, нуур, булаг шанд, мөсөн голоос бүрдэнэ. Усны гадаргын цэвэр усны нийт хэмжээг ойролцоогоор 535 км3 гэж тооцдог. Нэмэлт 90 км2 гадаргын ус нь давслаг, шорвог нуурт хадгалагддаг.
245. Гадаргын усны нөөц улс даяар жигд бус тархсан байдаг. Нутгийн хойд болон төв хэсэгт Байдаг гол, мөрний сүлжээ нутгийн бусад хэсэгтэй харьцуулбал харьцангуй нягт байдаг. Гадаргын усны нийт нөөцийн 70% хувь нь уул нуруунд бүрэлддэг бөгөөд эдгээр нь тус улсын газар нутгийн ердөө 30% хувийг эзэлдэг. Зураг 14-т Монгол орны бүх байнгын урсгалтай гол, мөрнүүдийн сүлжээг харуулав.
246. Монгол орны гадаргын усны нөөцийг 110 гол, 16 нуур дахь 126 байнгын ажиллагаатай хэмжих станцын гидрологийн хэмжүүрийн сүлжээнд түшиглэн УЦУОШГ хяналт тавьж байна. Хамгийн эртний бүртгэл 1942 онд бичигдэж байжээ.



Зураг 8 Монгол орны гадаргын усны сүлжээ

247. Монгол орны гол мөрний урсац илээс жилд эрс өөрчлөгдөж байдгаас гадна, жил бүр өөр өөр байдаг. Тухайн жилдээ хавар, зун, өвлийн урсацын горимд ялгаа гардаг.
248. Хаврын урсгал нь цас, мөс хайлж эхэлсэн эх үүсвэрээс эх авдаг. Ямар өндөрлөгт байгаагаас хамаараад энэ нь гуравдугаар сарын сүүлчээс эхлээд дөрөвдүгээр сарын эцсийн үед эхэлдэг байна. Хаврын урсгал нь зургаадугаар сарын турш бага урсгалтай болж ирдэг. Гол мөрний тогтолцоо нь цас, мөсөн гол хайлах цаг хугацаа болон урсац бүрэлдэхэд тэдгээрийн оруулах харьцангуй хувь нэмрээс хамаараад, газарзүйн хувьд ялгаатай байна.
249. Хамгийн том урсгал болох зуны урсгал нь 7, 8-р сард хур борооны улмаас үүсдэг бөгөөд 9-р сарын эцэс хүртэл үргэлжлэх боломжтой. Энэ сараас хойш хур тунадасны хэмжээ мэдэгдэхүйц буурч, гол мөрний урсац нь ус хөлдөх үед болон өвөл цагийн бага урсацтай болох үе буюу 11-р сарыг дуустал багасдаг байна. Гүехэн голуудад голын адаг руугаа хөлдөх магадлалтай бөгөөд голын урсгал нь хавар мөс хайлах үе хүртэл зогсонги байдалд ордог.

5.4.1.2 Нуурууд

250. Монгол орны нуур нутаг дэвсгэрийн ердөө 0.4 хувийг эзэлдэг боловч их хэмжээний усыг агуулж байдаг. Нууруудыг цэнгэг усны нуур, давсархаг усны нуур гэж ялгаж болно.
251. Цэвэр усны нуурууд нь нуураас нь гарч буй голын гольдролтой бөгөөд ус нь нуур луу орж ирж буй голын гольдролоор тэжээгдэн сэргээгддэг. Цэнгэг усны нуурын усны нийт хэмжээ 500 000 гага литр (GL). Бүх цэнгэг усны нөөцийн ойролцоогоор 75% орчим хувь нь нууруудад хадгалагддаг. Хамгийн том нь Хөвсгөл нуур бөгөөд энэ цэнгэг усны нөөцийн дөрөвний гурвыг нь (380,000 гага литр GL) агуулж байдаг. Цэнгэг устай бусад том нуурууд бол Буйр нуур, Хар нуур, Хар-Ус нуур юм. Давсархаг нууруудын хувьд тэднээс гадагшаа урссан голын гольдрол байхгүй бөгөөд усны ууршлын улмаас уусаад хатуу биетүүд бий болсон хуримтлал нь цаг хугацааны явцад нэмэгдсээр байдаг. Монгол орны давсархаг нууруудын усны нөөцийн нийт хэмжээ 90, 000 гага литр. Хамгийн том давсархаг нуур бол Увс нуур, Хяргас нуур юм. Цэнгэг болон давсархаг нууруудын аль аль нь ургамал, амьтны амьдрах таатай орчныг бүрдүүлж өгдөг тул хамгаалагдсан байдаг.

5.4.1.3 Мөсөн голууд, цас болон мөн цэвдэг

252. Урьд нь хийсэн тооцооллоор Монгол улс нийт 269 мөсөн голтой, тэдний нийт гадаргуу нь 659 км² талбайг хамарч байв. Мөсөн голууд нь Алтай, Хангай, Отгонтэнгэр уулнаас эх авч урсдаг голуудын найдвартай усны эх үүсвэр юм. Хайлж байдаг мөс бол тогтмол түвшинд хамгийн бага хэмжээний урсгалыг хангаж өгч байдаг.
253. Өвлийн улиралд цасны хэмжээ харьцангуй бага байдаг. Гэсэн хэдий ч цас хайлж байгаа нь хур бороо бага хэвээр байгаа хавар голын урсацад гол хувь нэмэр болж байдаг. Цас нь өвөл мал, зэрлэг амьтдын ундны усны эх үүсвэр болдог.
254. Монгол орны хойд хэсэгт мөнх цэвдэгт байдаг.

5.4.2 Зорилтот бүс нутаг

255. **Ховд аймаг** нь аварга том Монгол Алтайн уулс, нуруугаар дундуураа бараг хоёр хуваагдсан байдалтай байдаг ба уул нуруудаас холдох тусам газар нь мэр сэр давсархаг нуурууд болон жижиг уул нурууд бүхий, нүцгэн хагас-цөлөрхүү болж ирдэг. Тэнд Ховд, Булган, Буянт, Бодонч, Цэнхэр голууд байдаг. Хар Ус, Хар нуур, Дөргөн бол хамгийн том нуурууд юм.
256. **Сүхбаатар аймаг** нь Монгол орны зүүн хэсэгт байрладаг. Нутаг дэвсгэр нь толгод, гол төлөв хээр тал нутаг юм. Тус аймагт Шилийн Богд, Зотолхан, Алтан овоо, Аяабатар, Асгат, Сэнжитийн Өндөр, Дош, Ганга, Цагаан овоо, Нарт зэрэг 220 сөнөсөн галт уул байдаг. Далай булаг, Арнуур, Талбулаг, Дашин, Эрээн толгой зэрэг 20 гаруй булаг аймгийн нутаг дэвсгэрт байдаг. Ганга нуур, Дуут, Дош нуурууд бол хүмүүсийн түгээмэл очих дуртай газрууд. Нутгийн хойд болон баруун хойд хэсэг нь бор хөрстэй, зүүн хэсгийн хөрс нь цайвар, бор өнгөтэй байдаг. Нутгийн өмнөд хэсэг нь хагас цөлөрхөг (элсэн цөл), бусад хэсэгт гол төлөв тал хээр байдаг.
257. **Дорнод аймаг**: Онон, Хэрлэн, Халх, Улз голууд бол хамгийн том голууд юм. Дорнод аймагт Хөх, Галуут, Баян, Булан, Буйр зэрэг олон тооны нуурууд байдаг. Буйр нуур нь хамгийн том бөгөөд цэнгэг устай нуур юм, харин бусад нь давсархаг нуур юм. Аймгийн нутагт олон булаг шанд байдаг бөгөөд хамгийн алдартай нь Цагаан Хөндий, Утаат Минжүүр, Эрээн, Цагаан чулуут юм.
258. **Завхан аймаг**: Идэр, Тэс, Завхан, Хүйн гол зэрэг олон голууд байдаг. Жижиг, том нууруудад Отгон, Тэлмэн, Хар, Холбоо орно. Хамгийн урт гол нь Завхан бөгөөд урт нь 808 км юм. Хамгийн том нуур нь Тэлмэн юм - 200 км². Завхан аймаг нь Отгонтэнгэр, Улаан Хаалга, Хожуул зэрэг булаг шандтай аймаг юм. Нутгийн баруун хэсэгт хөрс нь цайвар, зүүн талаараа уулын төрлийн ойн хөрстэй.

5.4.3 Гүйцэтгэлийн шалгуур

259. Төслийг бүтээн байгуулахад гүйцэтгэлийн дараах шалгуурыг тогтоосон:
- Барилга болон ашиглалтын үйл ажиллагааны улмаас усны чанар мэдэгдэхүйц хэмжээгээр буурахгүй байх,
 - Усны чанар нь НҮБХХ, БОАЖЯ, ХХААХҮЯ болон бусад засгийн газрын холбогдох байгууллагуудын зүгээс зөвшөөрөх аливаа нөхцөлтэй нийцсэн байх ёстой, эсвэл тийм нөхцөл байхгүй байгаа тохиолдолд “улам доройтуулахгүй байх” аргачлалыг баримтлах,



GREEN
CLIMATE
FUND

Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ

УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ

- Тухайн газартай холбоотой Хөрсний элэгдэл, ус хурах сав газар, тунадасны хяналтын төлөвлөгөөг (EDSCP) үр дүнтэй хэрэгжүүлэх.

5.4.4 Хяналт, шинжилгээ

260. Зорилгодоо тохирсон чанартай устай байх нь чухал юм. Усны чанар нь ургамлын өсөлт, малын эрүүл мэнд, хөрсний чанар, фермийн тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээнд нөлөөлж болно. Усны эх үүсвэрийн чанар нь цаг агаар, гадны орц зэргээс шалтгаалан харилцан адилгүй байдаг.
261. Ууршилт нь давсны концентрацийг ихэсгэж, урсгал ус нь давсыг шингэлж өгөх боловч мөн хурдас, бордоо, ялгадас, шим тэжээлийн урсацыг нэмэгдүүлэх магадлалтай байдаг. Хяналт шалгалтыг зуны улиралд эсвэл удаан хугацаанд чийг тасалдаж байгаа үед тогтмол эсвэл илүү олон удаа хийх хэрэгтэй.
262. Хүснэгт 9-т шаардлагатай хяналт шинжилгээг нарийвчлан харуулав.

5.4.5 Тайлагнал

263. Усны чанарын хяналт шалгалтын үр дүн ба /эсвэл ослын талаархи дүнг нэгтгэн шивж оруулаад, БОНҮНМБХХ-д заасны дагуу тайлагнана. Материаллаг хэлбэрээр эсвэл байгаль орчинд ноцтой хохирол учруулсан байх магадлал бүхий аливаа сэжигтэй тохиолдолд эсвэл усны чанартай холбоотой тогтоосон байсан түвшингээс хэтэрсэн тохиолдолд БОАЖЯ болон ХХААХҮЯ-нд нэн даруй мэдэгдэж байх ёстой.

Асуудал	Хяналтын үйл ажиллагаа (болон эх үүсвэр)	Арга хэмжээ авах хугацаа	Үүрэг хариуцлага	Хяналт, шинжилгээ болон тайлагнал
W1: Гадаргын усны системд өндөрт өргөгдөж гацсан хатуу биет болон бусад бохирдуулагч.	W1.1: Төслийн бүх бүрэлдэхүүн хэсгүүдийг барьж байгуулах явцад ус хурах сав газарт хяналт тавьж, хурдас болон хөрсний элэгдлийг хянаж, хөрс зэрэг материалыг овоолж босгох үед, тухайн газартай нь холбогдох Хөрсний элэгдэл, ус хурах сав газар, тунадасны хяналтын төлөвлөгөөг (EDSCP) боловсруулж, хэрэгжүүлнэ. Бүх арга хэрэгсэл нь зүй зохистой ажиллаж байх нөхцлийг хангахын тулд Хөрсний элэгдэл, ус хурах сав газар, тунадасны хяналтын төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээг тогтмол шалгаж байх хэрэгтэй.	Газар шорооны ажлын өмнө	Хээрийн/талбайн ажилтан	Эхний ээлжинд байгуулаад дараа нь шаардлагын дагуу БОАЖЯ, ХХААХҮЯ, НҮБХХ-д тайлагнах
	W1.2: Шатахуун, тос, химийн бодис эсвэл бусад аюултай шингэнийг хадгалах зориулалттай газрууд нь нягтшил сайтай ус нэвчихгүй суурьтай байх ёстой бөгөөд ямар нэгэн байдлаар асгаруулахгүйн тулд эргэн тойронд нь шороон далан тойруулан барьсан байх хэрэгтэй. Түлшээ дахин цэнэглэж байгаа бол тухайн усны системээс хол газарт хийх ёстой.	Барилгын болон ашиглалтын бүхий л үе шатанд	Бүх хүн хүч	БОАЖЯ, ХХААХҮЯ, НҮБХХ-д тайлагнах бүртгэл хөтлөх
	W1.3: Газрын доорхи усанд нөлөөлөх магадлалтай газруудад газрын гадаргын болон гүний усны чанарт тогтмол хяналт тавих ба, үүнд гүний усны чанарт гарсан өөрчлөлтийг үнэлэх.	Барилгын болон ашиглалтын бүхий л үе шатанд	Хээрийн/талбайн ажилтан	Шаардлагын дагуу БОАЖЯ, ХХААХҮЯ, НҮБХХ-д тайлагнах
	W1.4: Төлөвлөсөн ажил дууссаны дараа, аль хэрэгжих боломжоор нь эвдрэлд орсон газруудыг дахин ургамжуулж мөн аажмаар тогтворжуулах нөхцлийг хангахын тулд ажлаа үе шаттайгаар төлөвлөх.	Бороо орох урьдчилсан мэдээ гарсан үед их хэмжээний газар шорооны ажил хийхээс зайлсхийх	Гэрээт гүйцэтгэгч	Бүртгэл хөтлөх



**Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ**
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ

W1.5: Байгаль орчинд алдагдаж болзошгүй барилгын материалыг усан орчинтой ойрхон овоолохгүй байх. Ажлын өдөр бүрийн төгсгөлд эсвэл хүчтэй бороо орох төлөвтэй байгаа тохиолдолд барилгын тоног төхөөрөмжийг усан орчны ойр тойрноос холдуулах.

Барилгын болон ашиглалтын бүхий л үе шатанд

Хээрийн/талбайн Бүртгэл хөтлөх ажилтан

5.5 ХӨРСНИЙ ЭЛЭГДЭЛ, УС ХУРАХ САВ ГАЗАР, ТУНАДАС ХУРИМТЛАЛ

5.5.1 Үндсэн суурь үзүүлэлтүүд


264. Монгол улсын геологийн талаар 5.3.1.1-р хэсэгт толилуулав.

5.5.2 Soils Хөрс

265. Монгол орны хөрс үндсэндээ хоёр ангилалд хуваагддаг:

- Уулын хөрс
- Тал газрын болон уулс хоорондын хөндийн хөрс

266. Эдгээр хоёр ангилал дотроо 36 төрөл байна. Зураг 9 Монгол улс даяарх хөрсний зураглалыг харуулна.



Зураг 9 Монгол орны хөрс

267. Хөрсний элэгдэл нь хөрсний төрөл, налуу, ургамал, топографийн шинж чанар, хур тунадасны хэмжээ зэрэг хэд хэдэн параметрээс хамаарна. Хөрсний тогтворжилт алдагдаж мөн хөрсний элэгдэл нь ургамлын бүрхэвчийг зайлуулах болон олон тооны барилгын үйл ажиллагаанаас болоод үүсч болзошгүй юм. Энэ нь хөрсний үржил шим алдагдах, налуу тогтоцод нь тогтворгүй байдлыг өдөөж болно. Төслийг хэрэгжүүлэхэд газрын бэлтгэл ажил хийснээр тухайн газрын байгалийн урсацыг хааж эсвэл өөрчилсөнөөр тус газрын ус хурах сав газрын хэлбэрийг өөрчлөхөд хүргэж магадгүй юм. Сөрөг нөлөөллийг үр дүнтэйгээр, үр ашигтайгаар бууруулах арга хэмжээ нь зөвхөн нөлөөллийг бууруулах биш мөн одоо байгаа нөхцөл байдлыг сайжруулж болох юм.

268. Борооны болон хайлсан усны урсац нь байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг удирдан зохицуулах чадвар, ялангуяа ус хурах сав газар, хөрсний элэгдэл, тунадасжилтын менежментэд ихээхэн

нөлөөлөл үзүүлж чадна. Тиймээс хөрсийг ихээхэн хэмжээгээр эвдэлж, ус зайлуулах шугам, усны замтай холбоотой үйл ажиллагаа хийж байгаа бол цаг агаарын болзошгүй нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай. Тийм учраас ажил эхлэхээс өмнө, хөрсний элэгдэл болон тунадасжилтын хяналтын бүх шаардагдах механизмууд мөн бэлэн байж байх нөхцлийг хангаж ажиллах нь чухал.

269. Хөрсний элэгдэл үүсгэх боломжтой үйл ажиллагаанд дараахь зүйлс орно.

- Малталт, газар шорооны ажил
- Барилгын ажил, ялангуяа ус хураах, булаг шанд, худаг, цөөрөм, усан сан орчмын хамгаалалтын байгууламж
- Голын эрэг хавийн ажил, үүнд дахин ургамалжуулах ажил
- Бэлчээрийн даац хэтэрсэн, ургамлын менежмент тааруу.

5.5.3 Гүйцэтгэлийн шалгуур

270. Төсөлд зориулан дараах гүйцэтгэлийн шалгуурыг тогтоосон:

- Барилгын болон ашиглалтын үйл ажиллагааны улмаас усан орчин ба/эсвэл гадаргын ба/эсвэл гүний усанд ямар нэгэн тунадасжилт үүсэхгүй байх
- Үйл ажиллагаа явуулж байгаа бүх газарт болон түүнээс гадна усны чанар доройтохгүй байх
- Төслийн талбайд одоогоор байгаа бүх ус ба/эсвэл гүний усны системийн усыг хөрсний элэгдэл, ус хурах сав газар, тунадасжилтын хамгийн сайн хяналтын арга замаар туулан гарсан байх
- Тухайн газартай холбоотой Хөрсний элэгдэл, ус хурах сав газар, тунадасны хяналтын төлөвлөгөөг (EDSCP) үр дүнтэй хэрэгжүүлэх

271. БОНҮНМБХХ-д заасны дагуу дараах менежментийн арга хэмжээг мөрдөж ажилласнаар, өргөн талбайг хамарсан тунадасжилтийн үр дүнд, төслийн барилгын ажил болон ашиглалтын үйл ажиллагаа нь мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй юм.

5.5.4 Хяналт, шинжилгээ

272. Тунадасжилтын хяналтын стандартчилагдсан хяналт, шинжилгээний хөтөлбөрийг төсөлд зориулан боловсруулсан (Хүснэгт 10). Хөтөлбөрийг гарснаас хойш дор хаяж хоёр сар тутамд нягтлан дүгнэж, шинэчлэх шаардлагатай. Хээрийн ажилтан дараах зүйлсийг хийх шаардлагатай:

- долоо хоног тутамд эсвэл 24 цагийн хугацаанд 20мм-ээс дээш давсан хэмжээний хур тунадас орсны дараа талбайн үзлэг хийх,
- Энэхүү БОНҮНМБХХ-тэй эсвэл ямарваа Хөрсний элэгдэл, ус хурах сав газар, тунадасны хяналтын төлөвлөгөөтэй (EDSCP) нийцэхгүй байгаа нөхцлийг баримтжуулах үүднээс тухайн газартай холбоотой хяналтын хуудас/жагсаалтыг боловсруулах,
- Хяналт шалгалт ба/эсвэл усны чанарын шалгалтын үр дүнг мэдээлж, хяналт тавьж чадаагүйтэй холбоотой аливаа асуудлыг хурдан засч, үүнтэй ижил төстэй алдаа давтагдахгүй байхын тулд тухайн газарт нь арга хэмжээ зохион байгуулах.

5.5.5 Тайлагнал

273. Бүх хурдас, тунадасжилт болон хөрсний элэгдлийн хяналтын үр дүн ба/эсвэл ослын мэдээллийг шивж оруулаад, БОНҮНМБХХ-д заасны дагуу тайлагнана. БОАЖЯ болон ХХААХҮЯ материаллаг эсвэл байгаль орчинд ноцтой хохирол учруулсан байж болзошгүй сэжигтэй аливаа тохиолдолд эсвэл хөрсний элэгдэл болон хурдас, тунадасжилтийн хяналттай холбоотой тогтоосон байсан түвшингээс хэтэрсэн тохиолдолд БОАЖЯ ба ХХААХҮЯ-нд нэн даруй мэдэгдэх шаардлагатай.



Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ

Хүснэгт 10 Хөрсний элэгдэл, ус хурах сав газар, хурдас тунадасжилтийн хяналтын арга хэмжээ

Асуудал	Хяналтын үйл ажиллагаа (болон эх үүсвэр)	Арга хэмжээ авах хугацаа	Үүрэг хариуцлага	Хяналт, шинжилгээ болон тайлагнал
E1: Газар шорооны ажлын улмаас хөрсний материал алдагдах ба/эсвэл гадарга дээр ба/эсвэл гүний усны системд тунадасжилт хурдас үүсэх	E1.1: Гадаргуугийн ажил, далан, малтлагын ажил, усны гарц, аадар борооноос үүдэлтэй суваг зэрэгт зориулан Хөрсний элэгдэл, ус хурах сав газар, тунадасны хяналтын төлөвлөгөөг (EDSCP) боловсруулж, хэрэгжүүлэх	Барилгын ажлын үе шатанд	Бүх хүн хүч	Бүртгэл хөтлөх
	E1.2: Хөрсний элэгдэл, тунадас хянах төхөөрөмжийг суурилуулж, шалгаж, шаардлагатай үед нь засварлаж байх нөхцлийг хангаж ажиллах.	Барилгын ажлын үе шатанд	Бүх хүн хүч	Бүртгэл хөтлөх
	E1.3: Бүхий л цаг үед ургамалгүй болгож талбайг цэвэрлэх болон хөрсийг урвуулан ил гаргах аливаа үйл ажиллагааг багасгах үүднээс хуваарь гаргаж, үе шаттайгаар ажиллах.	Барилгын ажлын өмнө болон явцын дунд	Хээрийн/талбайн ажилтан	Бүртгэл хөтлөх
	E1.4: Бүх ил гарсан газрууд болон ус хурах сав газрын сувагт зориулан түр зууран болон байнгын Хөрсний элэгдэл, ус хурах сав газар, тунадасны хяналтын (EDSC) арга хэмжээг боловсруулан уялдуулж, байршуулах. Эдгээр арга хэмжээг барилгын ажлын өмнө хэрэгжүүлэх ёстой бөгөөд ажлын бүхий л явцад тухайн газартаа байна.	Барилгын ажлын өмнө болон явцын дунд	Хээрийн/талбайн ажилтан	Бүртгэл хөтлөх
	E1.5: Хур тунадас багатай болон салхины хурд багатай үед ургамлын бүрхэвчийг хөндөж байгаа ажил болон газар шорооны томоохон ажлыг хэрэгжүүлж байх санал болгох ажлын төлөвлөгөөний хуваарь гаргаж/үе шаттай хэрэгжүүлэх.	Барилгын ажлын өмнө болон явцын дунд	Хээрийн/талбайн ажилтан	Бүртгэл хөтлөх
	E1.6: Ургамалжуулалтын ажилд ашиглахаар бэлдсэн хөрсний давхарга болон өнгөн хөрсний овоолго болон/эсвэл хөрсийг нь хуулсан газрыг эргээд хөдөө аж ахуйн газар болгох.	Барилгын ажлын өмнө болон явцын дунд	Хээрийн/талбайн ажилтан	Бүртгэл хөтлөх



**Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ**

E1.7: Өнгөн хөрсний материалыг овоолох ажлын үргэлжлэх хугацааг багасгахын тулд ажлын хуваарь гаргаж/үе шатыг төлөвлөх.	Барилгын ажлын явцад	Бүх хүн хүч	Бүртгэл хөтлөх
E1.8: Овоолго шорооны байршлыг ус хурах сав газрын суваг, усны зам, эмзэг байршил зэрэг газруудаас хол байршуулах.	Барилгын ажлын өмнө болон явцын дунд	Хээрийн/талбайн ажилтан	Бүртгэл хөтлөх

Асуудал	Хяналтын үйл ажиллагаа (болон эх үүсвэр)	Арга хэмжээ авах хугацаа	Үүрэг хариуцлага	Хяналт, шинжилгээ болон тайлагнал
E1: Газар шорооны ажлын улмаас, хөрсний материал алдагдах болон газрын гадарга ба/эсвэл гүний усны системд хурдас, тунадасжилт үүсэх	E1.9: Гадаргын урсацын хурдыг бууруулж, гадаргын урсац хэт их төвлөрөхөөс сэргийлэхийн тулд, аадар борооны усны менежментийн арга хэмжээг боловсруулах.	Барилгын ажлын өмнө болон явцын дунд	Хээрийн/талбайн ажилтан	Бүртгэл хөтлөх
	E1.10: Гадаргын усны хурдацыг бууруулж, тунадасжилт, хурдсыг зарим талаар шүүх боломжийг шаардлагатай газар нь гаргаж өгөхийн тулд ус хурах сав газрын сувагт хяналтын далан байгуулах.	Барилгын ажлын өмнө болон явцын дунд	Хээрийн/талбайн ажилтан	Бүртгэл хөтлөх
	E1.11: Хөрсний элэгдэл болон хурдас, тунадасжилтыг хянах зорилгоор сүрэл, бордоон хучлагыг ашиглах ёстой бөгөөд үүнийг налуу газарт ашигласан бол (сонгосон газраасаа хамаарна), хур бороо ихтэй үед хурдас, тунадасжилтыг хянах илүү их хашлага барих ажлыг хамруулна.	Барилгын ажлын явцад	Бүх хүн хүч	Бүртгэл хөтлөх
	E1.12: Шаардлагатай бол гол, сувгийн урсгал дотор эсвэл эмзэг/аюултай эд, зүйлсийг тойруулаад далан байгуулах ажил хийгдэх ёстой.	Барилгын ажлын явцад	Бүх хүн хүч	Бүртгэл хөтлөх
	E1.13: Барилгын ажлын явцад шаардлагатай үед усны хурдыг бууруулах үүднээс, ургамал өвс тарьсан хамгаалалтын зурвас байгуулах ёстой.	Барилгын ажлын явцад	Хээрийн/талбайн ажилтан	Бүртгэл хөтлөх
	E1.14: Хурдас, тунадасжилт ихээр нэмэгдэхээс хамгаалах үүднээс лаг шавран хашлага эсвэл үүнтэй төстэй байгууламж байгуулах.	Барилгын ажлын явцад	Гэрээт гүйцэтгэгч	Бүртгэл хөтлөх
	E1.15: Хөрсний элэгдэл болон хурдас, тунадасжилтийг хянах бүх байгууламжид үүссэн хэт илүүдэл хурдас, тунадасыг (ж нь, тунадасны нөөцлүүр, хяналтын далан) барьж тогтоох хангалттай хэмжээний хүчин чадалтай байлгаж байхын тулд зайлуулж байх ёстой.	Барилгын ажлын явцад	Гэрээт гүйцэтгэгч	Бүртгэл хөтлөх



**Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ**

E2: Хөрсний
бохирдол

E2.1: Хэрвээ бохирдлын тохиолдлыг ил болгож эсвэл бохирдол байна гэж сэжиглэж байгаа бол (төсөл хэрэгжсэн ул мөрөөс гадна бол) 1-р Үе шатанд тухайн газарт бохирдлын чиглэлийн анхан шатны мөрдөн шалгах ажлыг зохион байгуулна. Өмнө нь тодорхойлоогүй бохирдол үүсэх юм бол гэрээт гүйцэтгэгч нь ажлаа зогсоож, менежментийн процедурыг идэвхижүүлж, мөн (шаардлагатай бол) зөвлөмж/зөвшөөрлийн бичиг/зөвшөөрлийг авах.

Барилгын үе
шатанд

Бүх хүн хүч

Бүртгэл хөтлөх

Асуудал	Хяналтын үйл ажиллагаа (болон эх үүсвэр)	Арга хэмжээ авах хугацаа	Үүрэг хариуцлага	Хяналт, шинжилгээ болон тайлагнал
E2: Хөрсний бохирдол	E2.2: Төслийн үйл ажиллагааны ул мөрөөс үүссэн бохирдсон хөрс зэрэг (хэрэв шаардлагатай бол) тухайн газраас бохирдсон хөрс/материалыг зайлуулах ба хаяхад зориулан хамгийн шилдэг арга туршлагыг баримталж ажиллах.	Барилгын үе шатанд	Бүх хүн хүч	Бүртгэл хөтлөх
	E2.3: Ус хурах сав газрын хяналтын арга хэмжээ нь, тухайн урсац бохирдсон талбайд (төслийн үйл ажиллагааны ул мөрийн улмаас бохирдсон материал) хүрэлцэхгүй байх нөхцлийг хангаж мөн уг урсацыг гадагшуулах найдвартай талбай руу чиглүүлж, урсгалыг нь өөрчлөх.	Барилгын үе шатанд	Бүх хүн хүч	Бүртгэл хөтлөх
	E2.4: Дагалдах сертификат/баримтжуулалт муутай бөгөөд тухайн газрыг бохирдуулж болзошгүй овоолгыг импортлож оруулахаас зайлсхийх. Талбайг ухах замаар овоолго үүсгэх боломжгүй тохиолдолд, үүнийг геотехникийн үзүүлэлтэд нийцүүлэн туршиж үзэх шаардлагатай.	Барилгын үе шатанд	Бүх хүн хүч	Бүртгэл хөтлөх

5.6 Хог хаягдлын менежмент

5.6.1 Үндсэн суурь үзүүлэлтүүд

274. БОАЯЖ болон ХХАХҮЯ нь хэрэгжүүлэгч байгууллагын хувьд хог хаягдлын зохистой менежментийг хөхиүлэн дэмжиж ирсэн. Хог хаягдлын менежментийн эрэмбэлэх зарчим болон хог хаягдлын зохистой менежментийн дараах зарчмуудыг онцгойлон баримтална. Үүнд:

- хог хаягдал гаргахаас аль болох зайлсхийх (төслийн хүрээнд онцын шаардлагагүй материалыг хэрэглэхээс зайлсхийх)
- хог хаягдлыг дахин ашиглах (материалыг дахин ашиглах, хог хаях явдлыг багасгах)
- хог хаягдлыг дахин боловсруулах (лааз, шилэн лонх зэрэг материалыг дахин боловсруулах);
- Хог хаягдлыг зайлуулах (түргэн мууддаг, бохирдсон хог хаягдлыг хог хадгалах зориулалтын цэгт (landfill) аваачиж булах

275. Барилга болон ашиглалтын үйл ажиллагааны үеэр төрөл бүрийн тунадас, хог хаягдал үүсэх эрсдэлтэй байдаг. Жишээлбэл:

- газар шорооны ажлын үеэр ухаж гаргасан дахин ашиглах боломжгүй хог хаягдал
- Барилгын ажил, өрөмдөх багаж хэрэгсэл ашиглах үед гарах хог хаягдал. Барилгын ажил, өрөмдлөгийн үед янз бүрийн хүнд машин механизм, барилгын тоног төхөөрөмж ашигладаг. Эдгээр машин механизмыг угаах, засварлах, засаж сэлбэх үед шингэн болон хортой хог хаягдал үүсдэг. Барилгын талбайд шатахуун/тос тослох материал асгарах тохиолдолд зохих арга хэмжээг авч бохирдлыг зайлуулах шаардлагатай.
- сав баглаа боодол
- ашигласан тос, машины эд анги. Жишээ нь, тосны шүүлтүүр
- бие засах өрөө гэх мэт ажилчдад зориулсан байгууламжийг ашиглах үед аюултай бус шингэн хог хаягдал үүсдэг
- Хаягдал материал, микро организмын нөлөөгөөр задрах (biodegradable) хог хаягдал болон бусад энгийн хог хаягдал

276. Ажил гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай тохиолдолд хөрс хуулах, ургамлан нөмрөгийг хөндөх ажлын нөлөөллийг аль болох багасгах, нөхөн сэргээх арга аргачлалын талаар барилга болон ашиглалтын үйл ажиллагаанд оролцож буй ажилтнуудад сургалт явуулж мэдлэг чадварыг нь нэмэгдүүлэх шаардлагатай. Ингэснээр төслийн хүрээнд үүсэх хог хаягдлын хор нөлөөг аль болох багасгах боломж үүсдэг.

5.6.2 Гүйцэтгэлийн шалгуур

277. Дараах гүйцэтгэлийн шалгуурыг төслийг бүтээн байгуулахад зориулж тогтоосон болно.

- хог хаягдлын менежментийн эрэмбэлэх зарчмыг (зайлсхийх, багасгах, дахин ашиглах, дахин боловсруулах) хэрэгжүүлэх замаар хог хаягдлыг хамгийн бага түвшинд барьдаг байх.
- талбайн ажилтнуудын үйл ажиллагааны үр дүнд төслийн талбай, ойр орчинд хог хаягдал ажиглагдахгүй байх
- хог хаягдал үүсгэсэн, буруу зохицуулсан талаар ямар нэг гомдол гарч байгаагүй байх
- Хаягдал тос, тослох материалыг талбайгаас зайлуулдаг, эсхүл дахин боловсруулах зорилгоор орон нутгийн тосны компанид илгээдэг байх.

5.6.3 Хяналт, шинжилгээ

278.

Төслийн хүрээнд хог хаягдлын менежментийн хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулсан (Хүснэгт 11) Хөтөлбөрийг баталж хэрэгжүүлж эхэлснээс хойш 2 сар тутамд нягтлан үзэж зохих өөрчлөлтийг тусгана.

5.6.4 Тайлагнал

279. Байгаль орчинд ноцтой нөлөө учруулахуйц ямар нэг сэжигтэй тохиолдолд илэрсэн, эсхүл хог хаягдлын хэмжээ хүлээн зөвшөөрөгдөх хэм хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд хэрэгжүүлэгч байгууллага болох БОАЖЯ, ХХААХҮЯ-нд нэн даруй мэдэгдэнэ.

Хүснэгт 1 Хог хаягдлын менежментийн арга хэмжээ

Асуудал	Хяналтын үйл ажиллагаа (болон эх үүсвэр)	Арга хэмжээ авах хугацаа	Үүрэг хариуцлага	Хяналт, шинжилгээ болон тайлагнал
WT1: Хог хаягдал үйлдвэрлэл, нөөцийн үрэлгэн хэрэглээ	WT1.1: Шууд болон шууд бус хог хаягдал үүсэх нөхцлийг багасгахуйц төслийг бүтээн байгуулахад ашиглах материалыг түлхүү сонгон хэрэглэдэг байх	Барилгын ажил явагдахын өмнө болон явагдах үед	Гүйцэтгэх байгууллага	Тэмдэглэл хөтлөх
	WT1.2: Хог хаягдлын менежмент хариуцсан гадны байгууллагад хариуцуулахаас бусад тохиолдолд хог хаягдлыг зохицуулах ажлыг өдөр тутам гүйцэтгэдэг байх	Барилгын ажил явагдах үед	Хээрийн/талбайн ажилтан	Өдөр бүр, тэмдэглэл хөтлөх
	WT1.3: Барилгын материалыг оновчтой сонгон хэрэглэж дахин боловсруулах бодлого боловсруулж хэрэгжүүлдэг байх.	Барилгын ажил явагдах үед	Хээрийн/талбайн ажилтан	7 хоног бүр, тэмдэглэл хөтлөх
	WT1.4: Бүхий л цаг үед хог хаягдлыг ахуйн хог хаягдал, барилгын хог хаягдал, бохирдсон хаягдал гэхчилэн тусгайлан ангилж ялгадаг байх. Төслийн талбайд төрөл бүрийн хог хаягдлыг түр хадгалах зориулалтын цэгийг бэлтгэсэн байх	Барилгын ажил явагдах үед	Хээрийн/талбайн ажилтан	7 хоног бүр, тэмдэглэл хөтлөх
	WT1.5: Аливаа бохирдсон хог хаягдлыг зориулалтын хогийн байгууламжид аваачиж зайлуулах	Барилгын ажил явагдах үед	Хээрийн/талбайн ажилтан	7 хоног бүр, тэмдэглэл хөтлөх
	WT1.6: Дахин боловсруулж болох хог хаягдлыг (тос, зарим барилгын хог хаягдал) тусад нь ангилж зөв зохистой зайлуулах	Барилгын ажил явагдах үед	Хээрийн/талбайн ажилтан	7 хоног бүр, тэмдэглэл хөтлөх
	WT1.7: Хог хаягдал хадгалах талбайг бүрэн хучиж ан амьтан нэвтрэн орохоос урьдчилан сэргийлдэг байх	Барилгын ажил явагдах үед	Хээрийн/талбайн ажилтан	Өдөр бүр
	WT1.8: Хог хаягдлыг зайлуулах үйл ажиллагааг Монгол улсын төр засгийн шаардлагад нийлүүлж явуулдаг байх	Барилгын ажил явагдах үед	Хээрийн/талбайн ажилтан	7 хоног бүр, тэмдэглэл хөтлөх



**Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ**

WT1.9: Машин, тээврийн хэрэгсэл болон үйлдвэрээс түлш, шатах, тослох материал асгарч гоожих тохиолдолд нэн даруй цэвэрлэж ариутгах арга хэмжээг авдаг байх

Барилгын ажил явагдах үед

Хээрийн/талбайн ажилтан

Өдөр бүр, тэмдэглэл хөтлөх

Асуудал	Хяналтын үйл ажиллагаа (болон эх үүсвэр)	Арга хэмжээ авах хугацаа	Үүрэг хариуцлага	Хяналт, шинжилгээ болон тайлагнал	
WT1: Хог хаягдал үйлдвэрлэл, нөөцийн үрэлгэн хэрэглээ	WT1.10: Томоохон засвар үйлчилгээний ажлыг төслийн талбайгаас аль болох өөр газарт гүйцэтгэдэг байх	Барилгын явагдах үед	ажил	Хээрийн/талбайн ажилтан	тэмдэглэл хөтлөх
	WT1.11: Боломжтой тохиолдолд шатахуун, химийн бодис агуулах, зөөвөрлөх үйл ажиллагааг төвийн шатахуун болон химийн бодис хадгалах зориулалтын байгууламжид (тухайлбал шатахуун түгээх станцад) гүйцэтгэдэг байх	Барилгын явагдах үед	ажил	Хээрийн/талбайн ажилтан	тэмдэглэл хөтлөх
	WT1.12: Шатахуун, химийн бодисыг төслийн талбайд хадгалахыг аль болох хориглож хязгаарладаг байх	Барилгын явагдах үед	ажил	Гүйцэтгэгч байгууллага	тэмдэглэл хөтлөх ямар нэг зөрчил, тохиолдлыг тайлагнах
	WT1.13: Хаягдал тос, шатах тослох материалыг аль болох түргэн шуурхай цуглуулж хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрт хүргэдэг, эсхүл зориулалтын хог хаях газарт аваачиж хаядаг байх	Барилгын явагдах үед	ажил	Хээрийн/талбайн ажилтан	тэмдэглэл хөтлөх
	WT1.14: Аюултай бараа бүтээгдэхүүнийг төслийн талбайд хадгалахдаа Монгол улсын хууль журмыг чанд баримталдаг байх	Барилгын явагдах үед	ажил	Гүйцэтгэгч байгууллага	тэмдэглэл хөтлөх

5.7 Дуу чимээ ба чичиргээн

5.7.1 Үндсэн суурь үзүүлэлтүүд

280. Хот суурин газар, хүнд үйлдвэрлэл сул хөгжсөн тул орчны дуу чимээ харьцангуй бага байдаг.
281. Барилга болон ашиглалтын бүхий л үйл ажиллагааны явцад дуу чимээ гарч орчны тайван амгалан байдлыг алдагдуулах магадлалтай. Зарим чичиргээ үүсгэгч тоног төхөөрөмж ашиглах үед хавь ойрын оршин суугчид, мэдрэмтгий амьдрах орчингуудад чичирхийлэл мэдрэгдэж тавгүйтүүлэх талтай. Төслийн хүрээнд ямар нэг тэсрэх дэлбэрэх ажиллагаа явагдахгүй болно.
282. Хүчтэй машин техник, дуу чимээ ихтэй техник хэрэгслийг ашиглахдаа зөв зохистой менежмент явуулахгүй байх аваас байгаль орчин, оршин суугчдад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.
283. Барилгын ажилд оролцож буй гүйцэтгэгч байгууллагууд нь дуу чимээ ихтэй машин техникийг хянах арга аргачлалын талаар, мөн Монгол улсын хууль тогтоомж, журамд заагдсаны дагуу, эсхүл тийм заалт байхгүй тохиолдолд олон улсын тэргүүн туршлагад зөвлөмж болгосон барилгын өөр процедур, арга аргачлалын талаархи мэдлэг мэдээлэлтэй байх шаардлагатай.

5.7.2 Гүйцэтгэлийн шалгуур

284. Төслүүдийг бүтээн байгуулахад зориулж дараах гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоосон болно.
- Барилга болон ашиглалтын үйл ажиллагааны үеэр гарах дуу чимээ нь дуу чимээнд мэдрэг орчны тав тух, амгалан байдлыг алдагдуулах ёсгүй
 - барилгын үйл ажиллагаатай холбоотой дуу чимээг аль болох багасгахын тулд шаардлагатай арга хэмжээг бүхий л цаг үед авч хэрэгжүүлдэг байх
 - Барилга болон ашиглалтын үйл ажиллагаанаас үүдэлтэй чичирхийллийн улмаас талбайгаас зайдуу байрлах аливаа өмч хөрөнгөд ямар нэг эвдрэл, гэмтэл гарах ёсгүй
 - Ямар нэг гомдлыг хүлээн авснаас хойш 48 цагийн дотор залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байх.

5.7.3 Хяналт, шинжилгээ

285. Төслийн хүрээнд дуу чимээг хязгаарлах, хяналт шинжилгээ хийх стандарт хөтөлбөр боловсруулсан болно (Хүснэгт 12). Хөтөлбөрийг баталж хэрэгжүүлж эхэлснээс хойш 2 сар тутамд багадаа нэг удаа нягтлан үзэж зохих өөрчлөлтийг тусгадаг байна. Хамгийн чухал нь, гүйцэтгэгч байгууллага нь:
- машин техник, тоног төхөөрөмжийг тогтмол засвар үйлчилгээнд хамруулж зөв зохистой ашигладаг байх
 - барилгын дуу чимээ ихтэй үйл ажиллагааг зөвхөн “өдрийн” цагт явуулах үүрэг хүлээнэ.

5.7.4 Тайлагнал

286. Бүх төрлийн дуу чимээнд хяналт тавьсан талаарх мэдээлэл/эсхүл зөрчлийн талаарх мэдээллийг хүснэгт хэлбэрт оруулж байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц, хамрах хүрээнд (EMSF) тусгасны дагуу тайлагнана. Байгаль орчинд сөрөг нөлөө учруулах сэжигтэй тохиолдол илэрсэн, дуу чимээг зохих хэм хэмжээнээс хэтрүүлсэн тохиолдолд БОАЖЯ болон ХХААХҮЯ-д нэн даруй мэдэгдэнэ.

Хүснэгт 2 Дуу чимээ болон чичирхийллийг зохицуулах арга хэмжээ

Асуудал	Хяналтын үйл ажиллагаа (болон эх үүсвэр)	Арга хэмжээ авах хугацаа	Үүрэг хариуцлага	Хяналт, шинжилгээ болон тайлагнал
N1: Дуу чимээний түвшин нэмэгдэх	N1.1: Барилга барих болон ашиглалтын үйл ажиллагааны үеэр тухайлбал бүх төрлийн насос, тоног төхөөрөмж ажиллуулах үед дуу чимээг аль болох хязгаарлах зорилгоор үйлдвэр, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тодорхой дизайны шийдлийг сонгодог байх	Бүх үе шатанд	Гэрээт байгууллага	тэмдэглэл хөтлөх
	N1.2: Талбайд буй үйлдвэр, тоног төхөөрөмжид дуу чимээ багасгагч, тусгаарлагч, зөөлөвч гэх мэтийн дуу чимээ багасгах зориулалт бүхий багаж хэрэгсэл суурилуулж ашиглана.	Барилгын ажил явагдахын өмнө болон явагдах үед	Гэрээт байгууллага	тэмдэглэл хөтлөх
	N1.3: Дуу чимээ ихтэй барилгын ажлыг өглөө 7-оос орой 17.30-ын хооронд <u>бус цагт</u> гүйцэтгэх шаардлага гарах тохиолдолд уг ажлын хэрэгцээ, дуу чимээг аль болох хязгаарлах	Барилга угсралтын үе шатанд	Бүх ажилтан, албан хаагч	Өдөр бүр, тэмдэглэл хөтлөх
	N1.4: Дуу чимээ ихтэй барилгын ажлыг өглөө 7-оос орой 17.30-ын хооронд бус бусад цагт гүйцэтгэх зайлшгүй шаардлага гарах тохиолдолд барилгын ажил явагдахаас өмнө ойр хавийн оршин суугчидтай зөвлөлдөх	Барилга угсралтын үе шатанд	Бүх ажилтан, албан хаагч	Өдөр бүр, тэмдэглэл хөтлөх
	N1.5: Талбайд буй хэт дуу чимээтэй тоног төхөөрөмжийг өөр тоног төхөөрөмжөөр сольсон тохиолдолд орлуулан солих хяналтын арга стратегийг хэрэгжүүлнэ.	Барилга угсралтын үе шатанд	Бүх ажилтан, албан хаагч	Өдөр бүр, тэмдэглэл хөтлөх
	N1.6: Тодорхой оршин суугчдад үзүүлэх үр нөлөөг багасгахын тулд дуу чимээг багасгах түр зуурын тусгаарлагч хавтан байрлуулах	Барилга угсралтын үе шатанд	Хээрийн/талбайн ажилтан	Өдөр бүр, тэмдэглэл хөтлөх
	N1.7: Дуу чимээтэй холбоотой аливаа гомдол, зөрчил, доголдол тус бүрийн талаар барилгын талбай дахь зөрчил, тохиолдлыг тайлагнах журмын дагуу тайлагнаж бүртгэлд дүгнэж бичнэ.	Барилга угсралтын үе шатанд	Хээрийн/талбайн ажилтан	Тэмдэглэл хөтлөх



**Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ**

N1.8: Гүйцэтгэгч байгууллага нь зохих арга хэмжээг хэрэгжүүлэх замаар хэт дуу чимээг аль болох багасгах хэрэгцээ шаардлагын талаар ажилтнууд болон ашиглагчдад сургалт явуулж зохих мэдлэг мэдээллээр хангадаг байх	Барилгын ажил явагдахын өмнө болон явагдах үед	Гүйцэтгэгч байгууллага	Тэмдэглэл хөтлөх
---	--	------------------------	------------------

Асуудал	Хяналтын үйл ажиллагаа (болон эх үүсвэр)	Арга хэмжээ авах хугацаа	Үүрэг хариуцлага	Хяналт, шинжилгээ болон тайлагнал
N2. Барилгын үйл ажиллагаанаас үйлдэлтэй чичирхийлэл	N2.1: Төслийн барилга болон ашиглалтын үйл ажиллагаанаас үүдэлтэй чичирхийлэлд өртөх магадлалтай өмч хөрөнгө, барилга байгууламж, амьдрах орчны байршлыг тодорхойлно.	Барилгын ажил явагдахын өмнө болон явагдах үед	Гүйцэтгэгч байгууллага	Тэмдэглэл хөтлөх
	N2.2: Аливаа дизайныг боловсруулахдаа барилга болон ашиглалтын үйл ажиллагаанаас үүдэлтэй дуу чимээ, чичирхийллийн эсрэг түр зуурын болон байнгын арга хэмжээ авах хэрэгцээ шаардлагыг харгалзан үздэг байх	Барилгын ажил явагдахын өмнө	Гүйцэтгэгч байгууллага	Тэмдэглэл хөтлөх
	N2.3: Чичирхийлэлтэй холбоотой аливаа гомдол, зөрчил, доголдол тус бүрийн талаар барилгын талбай дахь зөрчил, тохиолдлыг тайлагнах журмын дагуу тайлагнаж бүртгэлд дүгнэж бичнэ..	Барилга угсралтын үе шатанд	Хээрийн/талбайн ажилтан	Тэмдэглэл хөтлөх
	N2.4: Барилгын ажлын үеэр барилга болон ашиглалтын үйл ажиллагаанаас үүдэлтэй чичирхийллээс газар доорх үйлчилгээнүүдийн байршлыг тогтоох, хамгаалах стандарт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Барилга угсралтын үе шатанд	Хээрийн/талбайн ажилтан	Тэмдэглэл хөтлөх

5.8 АГААРЫН ЧАНАР

5.8.1 Үндсэн суурь үзүүлэлтүүд

287. Барилгын бүхий л үйл ажиллагаанаас агаарын чанарт сөрөг нөлөө учрах эрсдэлтэй байдаг.
288. Төслийг ихэнхдээ хөдөө орон нутагт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Агаарын чанарын үзүүлэлтийн хувьд хөдөө орон нутагт тоосжилт хамгийн үндсэн асуудал болоод байна. Төсөл хэрэгжсэнээр агаарын чанарт ноцтой сөрөг нөлөө гарахгүй хэмээн тооцсон.
289. Барилга болон ашиглалтын үйл ажиллагаанд оролцож ажилтнууд агаарын чанарт тусах сөрөг нөлөөг аль болох бууруулах арга техникийн талаар болон Монгол улсын хууль тогтоомж эсхүл олон улсын тэргүүн туршлагад зөвлөмж болгосон барилгын өөр бусад процедур, шийдлийн талаар зохих мэдлэг мэдээлэлтэй байх шаардлагатай.

5.8.2 Гүйцэтгэлийн шалгуур

290. Төслийг бүтээн байгуулахад зориулж дараах гүйцэтгэлийн шалгуурыг тогтоож өгсөн болно. Үүнд
- Барилгын ажлын үер тоос шороо босч байгаль орчинд сөрөг нөлөө үүсгэх ёсгүй
 - барилга болон ашиглалтын үйл ажиллагаанаас үүдэлтэй агаарын чанарын сөрөг нөлөөг багасгах үүднээс бүхий л цаг хугацаанд зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
 - Аливаа гомдол гарсан тохиолдолд 48 цагийн дотор залруулах арга хэмжээ авах

5.8.3 Хяналт шинжилгээ

291. Төслийн хүрээнд агаарын чанарт хяналт шинжилгээ хийх стандарт хөтөлбөр боловсруулсан болно. (Хүснэгт 13). Хөтөлбөрийг баталж хэрэгжүүлж эхэлснээс хойш 2 сар тутамд наанадаж 1 удаа нягтлан харж зохих өөрчлөлтийг тусгадаг байна. Хамгийн чухал нь:
- Тоос шороог намжаах шаардлагыг дагаж мөрдөж буй эсэхэд талбайн ажилтны зүгээс өдөр бүр, БОАЖЯ, ХХААХҮЯ болон НҮБХХ-ийн ажилтнууд тогтсон хуваарийн дагуу талбайд үзлэг хийхдээ хяналт тавина.
 - Автомашин, техник тоног төхөөрөмжөөс үүдэлтэй утааг байнга ажиглаж зохих хэмжээнээс хэтэрсэн хэмээн үзвэл хэмжилт хийдэг байна.

5.8.4 Тайлагнах

292. Агаарын чанарт хяналт тавьсан талаарх бүхий л мэдээлэл болон/эсхүл зөрчлийн талаарх мэдээллийг хүснэгт хэлбэрт оруулж байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц, хамрах хүрээнд (EMSF) тусгасны дагуу тайлагнана. Байгаль орчинд сөрөг нөлөө учруулах хэмжээнд агаар бохирдсон, агаарын бохирдол зохих хэм хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд БОАЖЯ болон ХХААХҮЯ-д нэн даруй мэдэгдэнэ.

Хүснэгт 3 Агаарын чанарын менежментийн арга хэмжээ

Асуудал	Хяналтын үйл ажиллагаа (болон эх үүсвэр)	Арга хэмжээ авах хугацаа	Үүрэг хариуцлага	Хяналт, шинжилгээ болон тайлагнал
А.1 Мэдрэмтгий рецепторуудад тоосжилт нэмэгдэх	A1.1: Барилгын дизайн гаргах, барих, ашиглах явцад талбайн бүхий л хэсэгт тоос, тоосжилтыг багасгах зохицуулалтын арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх	Барилгын ажил явагдахын өмнө болон явагдах үед	Бүх ажилтан, албан хаагч	Өдөр бүр, тэмдэглэл хөтлөх
	A1.2: Автозам, бусад зам жим дагуу машины хурдыг хязгаарлах	Барилгын ажил явагдах үед	Хээрийн/талбайн ажилтан	Өдөр бүр
	A1.3: Тоос, шороо ихтэй үйл ажиллагааг явуулахдаа мэдрэмтгий байршлуудад байгаль орчны ямар нэг сөрөг нөлөө учрахгүй байх хэмжээнд зохицуулалт хийх	Барилгын ажил явагдах үед	Хээрийн/талбайн ажилтан	Өдөр бүр, тэмдэглэл хөтлөх
	A1.4: Барилгын үйл ажиллагааг явуулахдаа цаг уурын эрсдэлтэй нөхцөл байдлыг хамгийн бага түвшинд байлгахад анхаарах (цаг уурын мэдээг урьдчилан шалгадаг байх)	Барилгын ажил явагдах үед	Хээрийн/талбайн ажилтан	Өдөр бүр, тэмдэглэл хөтлөх
	A1.5: Ажлын төлөвлөгөө/үе шатыг хуваарилахдаа ургамлан нөмрөг, газрын хөрсийг аль болох хөндөхгүй байхад анхаарах	Барилгын ажил явагдах бүхий л үе шатанд	Гүйцэтгэх байгууллага	Өдөр бүр, тэмдэглэл хөтлөх
	A1.6: Барилгын материал овоолж хураасан талбайг мэдрэмтгий рецепторуудаас аль болох хол зайтай байрлуулах. Аль болох юмаар бүтээж далдлах	Барилгын ажил явагдах үед	Хээрийн/талбайн ажилтан	Өдөр бүр, тэмдэглэл хөтлөх
	A1.7: Тоос шороо дарах ажиллагааг явуулахдаа чанарын шаардлага хангасан хангалттай хэмжээний усны эх үүсвэр ашиглах, усны хязгаарлалттай холбоотой шаардлагыг дагаж биелүүлэх	Барилгын ажил явагдах үед	Хээрийн/талбайн ажилтан	Өдөр бүр, тэмдэглэл хөтлөх
	A1.8: Ургамлын зүйлсийн хамгийн оновчтой амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор ургамлын нөмрөгийг нөхөн сэргээх хуваарь гаргах	Барилгын ажил явагдах үед	Хээрийн/талбайн ажилтан	тэмдэглэл хөтлөх



**Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ**

A1.9: Хатуу хог хаягдлын савыг юмаар бүтээж мэдрэмтгий байршлуудаас аль болох зайтай байрлуулах	Барилгын явагдах үед	ажил	Хээрийн/талбайн тэмдэглэл хөтлөх ажилтан
---	----------------------	------	--

Асуудал	Хяналтын үйл ажиллагаа (болон эх үүсвэр)	Арга хэмжээ авах хугацаа	Үүрэг хариуцлага	Хяналт, шинжилгээ болон тайлагнал	
A2. Автомашин/ машин техникээс ялгарах утаа нэмэгдэх	A2.1 Машин, техник хэсэгслийг ашиглаагүй үедаа унтраалттай байлгах	Барилгын явагдах үед	ажил	Хээрийн/талбайн ажилтан	Өдөр бүр
	A2.2 Зөвхөн барилгын ажилд хэрэглэх машинуудыг талбайд байршуулж ашиглах	Барилгын явагдах үед	ажил	Хээрийн/талбайн ажилтан	тэмдэглэл хөтлөх
	A2.3 Барилгын ажилд ашиглах аливаа тээврийн хэрэгсэл, үйлдвэр, тоног төхөөрөмжийг зохих дизайны стандарт, техникийн нөхцөлийн дагуу ашиглаж, засвар үйлчилгээ хийдэг байх	Барилгын явагдах үед	ажил	Хээрийн/талбайн ажилтан	тэмдэглэл хөтлөх
	A2.4 Талбайн бүх ажилтанд зориулан ажлын байранд ажиллах үеийн байгаль орчны менежментэд тавигдах наад захын шаардлагын талаархи танилцуулах хөтөлбөр боловсруулж сургалт явуулдаг байх	Барилгын явагдахын болон явагдах үед	ажил өмнө	Гүйцэтгэгч байгууллага	тэмдэглэл хөтлөх
	A2.5 Барилгын ажилд ашиглах машин, үйлдвэр, техник тоног төхөөрөмжийг хадгалах талбайг мэдрэмтгий байршлуудаас аль болох зайтай байршуулах	Барилгын явагдах үед	ажил	Хээрийн/талбайн ажилтан	Өдөр бүр, тэмдэглэл хөтлөх
	A2.6 Хөдөлгөөнт үйлдвэрээс ялгарах хорт утааг газраас аль болох газраас хөндий байлгахаар чиглүүлэх	Барилгын явагдах үед	ажил	Хээрийн/талбайн ажилтан	Өдөр бүр
		Барилгын явагдах үед	ажил	Хээрийн/талбайн ажилтан	Өдөр бүр, тэмдэглэл хөтлөх

5.9 Нийгэмд үзүүлэх нөлөөллийн удирдлага, зохион байгуулалт

5.9.1 Үндсэн суурь үзүүлэлтүүд

293. Нийт хүн амын 78 хувийг халх монголчууд эзэлдэг. Хүн амын цөөнхөд Казах, Дөрвөд, Баяд, Буриад, Дарьганга, Захчин, Урианхай, Өөлд, Торгууд зэрэг угсаатны бүлгүүд багтдаг. Эдгээр угсаатны бүлгийн томоохон төлөөлөл болох казакууд нийт хүн амын 4 хувийг бүрдүүлдэг. Цөөн тооны Орос, Хятад хүмүүс Монголд байнга оршин суудаг⁶.

294. Монгол улсын дорнодын тал хээр, баруун зүгийн өндөр уулын бүс нутагт үндэсний цөөнх болсон ястнууд оршин суудаг. Төсөл хэрэгжүүлэх аймгуудын хүн ам олон янзын угсаатны бүлэг, ястнуудаас бүрдэнэ. Тухайлбал:

- Ховд аймаг: Монгол улсын олон ясны өлгий нутаг хэмээгддэг энэ аймгийн хүн амын дөнгөж 28.4 хувийг халхчууд эзэлдэг. Монгол улсад оршин суудаг нийт узбекчүүдийн 73.9%, Мянгадуудын 66%, Захчингуудын 68%, Торгууд нарын 42.1%, Өөлд ястны 41%, урианхай ястны 26.1%, Тува ястны 12.4% нь Ховд аймагт аж төрдөг.
- Дорнод аймаг нь нутгийн хойд хэсгээрээ ОХУ, зүүн болон зүүн өмнөд талаараа БНХАУ-тай хил залгаа оршдог. Хүн амын дийлэнх хэсгийг халх үндэстэн бүрдүүлэх боловч Баян уулын Эрэнцав, Баяндун, Дашбалбар, Цагаан-Овоо суманд Буриад, Барга ястнууд амьдардаг. Гурван-загал, Хөлөнбуйр сумдад үзэмчин ястнууд амьдардаг. Дорнод аймгийн хүн ам Халх, Буриад, Барга, Үзэмчин, Урианхай, Өөлд, Казак зэрэг янз бүрийн угсаатны бүлгээс бүрддэг. Тухайлбал Монгол улсын нийт буриадуудын 41.2%, баргачуудын 74.1%, үзэмчингүүдийн 79.9% энэ аймагт амьдардаг.
- Завхан аймаг: Голчлон халх үндэстнүүд оршин суудаг.
- Сүхбаатар: Энэ аймагт гурван төрлийн угсаатны бүлэг аж төрдөг. Гол төлөв халхчууд, Дарьганга (Сүхбаатар аймгийн өмнөд хэсэгт 30,000 дарьганга хүн амьдардаг нь Монгол улсын нийт Дарьганга ястны 81.2%-ийг эзэлдэг байна) Үзэмчин (хүмүүс Дорнод, Сүхбаатар аймагт 2000 үзэмчин ястан амьдран суудаг.

295. Монгол улсын уламжлалт нүүдлийн мал аж ахуй, малчны зохион байгуулалт олон зууны турш оршиж ирсэн. Тухайлбал:

- Хот айл нь садан төрлийн голдуу 2-3 өрхөөс бүрддэг, заримдаа садан төрлийн холбоогүй айлууд ч хотолж амьдрах нь бий. Хот айлууд нэг өвөлжөөнд хамт өвөлжиж малаа маллан бие биедээ тус дэм болж амьдардаг. Хот айлын хамгийн туршлагатай, эрэгтэй голдуу малчин удирдагчийн үүрэг хүлээсэн байдаг.
- Нэг нутгийнхан буюу 4-40 хот өрх сайн дураараа нэгдмэл зохион байгуулалтад орж бэлчээр нутаг, хадлангийн талбай, ус, байгалийн бусад нөөцөө хамтран эзэмшиж аж төрж ирсэн. Байгаль экологийн онцлогоосоо шалтгаалан нутаг бүр өөрийн гэсэн онцлогтой бөгөөд нутгийн иргэд аль нэг нуга хөндий эсвэл усны эх үүсвэр бараадан бие биеэ түшиж амьдардаг. Гишүүн өрхүүд, өвөг дээдсээс уламжлан айл саахалт болон амьдарч нөөц ашиглах, эзэмших эрхээ уламжлан хадгалж ирсэн. Нэг нутгийнхны дунд хүн бүхэнд хүндлэгдэж хүлээн зөвшөөрөгдсөн удирдагч байх бөгөөд нутгийнхны дунд гарсан ямар нэг зөрчил маргааныг (жишээ нь, газар, усны нөөцтэй холбоотой) шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэж өгдөг.

296. Энэхүү төслийг хамтрагч талуудын дэмжлэгтэйгээр боловсруулсан бөгөөд улс үндэстний хэмжээнд хүртээмжтэй, ашиг тустай байхыг зорьсон болно. Гэсэн хэдий ч барилгын ажилтай уялдуулан бусад төслийн жишгээр сэтгэл хангалуун бус байдал, зөрчил маргаан гарах магадлалтай. Маргаан зөрчил дагуулах асуудлыг аль болох эрт тодорхойлж урьдчилан сэргийлэх, багасгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь маш чухал юм.

297. Төслийн үйл ажиллагааны хүрээнд газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх хэрэгцээ шаардлага гарахгүй боловч барилгын ажлын үеэр газарт түр хугацааны нөлөөлөл учрах магадлалтай.

5.9.2 Хүйс

298. Хөдөө орон нутагт ажиллаж буй нийт эрэгтэйчүүдийн 60% нь, эмэгтэйчүүдийн 14% буюу харьцангуй бага хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг. Нөгөө талаар, ихэнх эмэгтэйчүүд (70%)

⁶ <http://www.everyculture.com/Ma-Ni/Mongolia.html>



GREEN
CLIMATE
FUND

Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ

УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ

мал маллах, хонь мал хариулах, сүү сааль, цагаан идээ бэлтгэх гэх мэтийн цалингүй ажил хийж гэр бүл, үр хүүхдүүдээ харж асардаг.

299. Монгол эмэгтэйчүүд өрхийн түвшинд хуулиар харьцангуй сайн хамгаалагдсан байдаг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс 18 насанд хүрсэн бол гэрлэх эрхтэй болох бөгөөд бүх гэрлэлт сайн дураар, харилцан зөвшилцсөний үндсэн дээр явагддаг. Монгол улсын 1992 оны гэр бүлийн тухай хуулинд эцэг эх, гэр бүл бологч талууд адил тэгш эрхтэй хэмээн заасан байдаг боловч бодит амьдрал дээр гэр бүлээ халамжлах үүргийг эмэгтэйчүүд нуруу дээрээ үүрч явдаг.
300. Эрэгтэй эмэгтэй хүмүүс өв залгамжлах тухайд адил тэгш эрхтэй. Монгол улсын хууль тогтоомжид эмэгтэйчүүд хувийн өмчтэй байхаар хуульчилсан байдаг. Эмэгтэй эмэгтэй хүмүүс аль аль нь газар өмчлөх, газраас бусад төрлийн өмчтэй байх эрхтэй.
301. Монгол улсын хууль тогтоомжид эмэгтэйчүүдийн бие махбодыг аливаа хүчирхийллээс хамгаалах хуулийн хатуу заалт байдаг. Гэвч эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ноцтой хэмжээнд хүрч сүүлийн үед олны анхаарлыг ихээр татах болсон. 2005 онд Монгол улсын Засгийн газраас гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх шинэ хуулийг батлан гаргасан. Засгийн газрын зүгээс олон тооны эмэгтэйчүүдийг (хоргодох) хамгаалах байр байгуулсан. Монгол улс эвлэлдэн нэгдсэн олон улсын гэрээ хэлэлцээр, конвенцынхоо хүрээнд хүлээсэн үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх зорилгоор эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах олон цогц арга хэмжээг авч хэрэгжүүлж ирсэн. Монгол улс нь эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийг соёрхон баталсан.

5.9.3 Соёлын өв

302. Соёлын өв нь биет болон биет бус хэлбэртэй байна. Төслийн хүрээнд соёлын өвийн байршлыг тодорхойлох болон/эсхүл соёлын өвд нөлөөлөх магадлалтай аливаа асуудлыг тодруулах зорилгоор орон нутгийн иргэдтэй зөвлөлдөх шаардлагатай.
303. Жишээлбэл, Монгол улсын зарим нутагт лус савдаг хилэгнэх аюултай хэмээн газар ухах, сөвтээхийг цээрлэдэг уламжлалтай. Энэхүү итгэл үнэмшил нь газрын доорхи усны олон мянган эмзэг нарийн судал өөр хоорондоо сүлбэлдэж оршдог тул газрын хөрсийг хөндөх ёсгүй гэсэн ус зүйн/шинжлэх ухааны дүгнэлттэй яв цав нийцдэг. Тийм учраас хашаа барих зорилгоор газар ухахын оронд өмнө хэрэгжсэн төслүүдийн жишгээр хашааны шонг том чулуугаар түшүүлэн хөндлөн бэхэлж тогтоох, хашааг огцом дээш бус налуу байрлуулснаар мал амьтны хөлд эвдэрч сүйрэх магадлал бага байдаг уламжлалт арга аргачлалыг ашиглахаар төлөвлөсөн болно.

5.9.4 Гүйцэтгэлийн шалгуур

304. Төсөлд дараах гүйцэтгэлийн шалгуурыг тогтоосон болно.
- төслийн бүхий л үе шатанд орон нутгийн иргэдтэй зөвлөлдөж төслийн бүрдэл хэсгүүдийн дизайныг боловсруулахдаа тэдний мэдлэг мэдээлэл, оролцоонд тулгуурласан байх
 - төслийн хамтрагч бүх талын оролцоог зохих түвшинд хангасан байх
 - барилга болон ашиглалтын үйл ажиллагааны үеэр нутгийн иргэдэд учрах аливаа сөрөг нөлөөнөөс зайлсхийх, сөрөг нөлөө гарах тохиолдолд тэдгээрийн хор нөлөөг аль болох багасгах, нөхөн сэргээх, нөхөн төлөх
 - соёлын өвд ямар нэг сөрөг нөлөөлөл учруулахгүй байх
 - нутгийн ард иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалж төслийн үр дүн, ашиг тусыг хүртээх
 - ямар нэг гомдол, маргаан хүлээн авах, шийдвэрлэх арга механизмыг тогтоож шийдвэртэй арга хэмжээ авч хэрэгжүүлдэг байх
 - Урт хугацааны нийгмийн үр өгөөжийг хүртээдэг байх.
305. Орон нутгийн хамтрагч талууд, нутгийн ард иргэдийн зүгээс төслийн хэрэгжилт, хяналт шинжилгээнд голлох үүрэг роль гүйцэтгэдэг.
306. Хамтрагч талуудтай зөвлөлдөх, зөвшилцөх үйл явц байнга үргэлжлэх болно. Ингэснээр хамтрагч талууд төслийн үйл явц, ахиц дэвшил, өөрчлөлтийн талаар байнга мэдээлэл хүлээн авч асуудал гарах үед цаг алдалгүй шийдвэрлэхэд тустай байх болно.
307. БОАЖЯ болон ХХААХҮЯ нь төслийн ашиг шимийг хүртэгч нутгийн иргэд, байгууллагад зөвлөгөө өгөх, мэдлэг түгээх үйлчилгээ үзүүлэх, бараа материал түгээх, техникийн сургалт явуулах, хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг үүрэг хариуцлага хүлээнэ.



**Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ**

5.9.5 Тайлагнал

308. Зөвшилцөх, зөвлөлдөх тохиолдол бүрт тэмдэглэл хөтөлж сар тутам тайлагнана.
309. Хувь этгээд, орон нутгийн бүлэг иргэдээс гомдол гаргах тохиолдол бүрийн талаар БОАЖЯ болон ХХААХҮС-д мэдэгдэл хүргүүлнэ. Гомдол барагдуулах арга механизмыг заавал дагаж мөрдүүлнэ.



**Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ**

Хүснэгт 4: Нийгэмд үзүүлэх нөлөөллийн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ

Асуудал	Хяналтын үйл ажиллагаа (болон эх үүсвэр)	Арга хэмжээ авах хугацаа	Үүрэг хариуцлага	Хяналт, шинжилгээ болон тайлагнал
SM1: Оролцогч талуудын оролцоог хангах	SM 1.1: Газар ашиглалтыг сайжруулах зорилго, ач холбогдлын талаар орон нутгийн иргэдтэй зөвлөлдөх уулзалт хийдэг байх	Барилгын ажил эхлэхээс өмнө	БОАЖЯ	тэмдэглэл хөтлөх
	SM 1.2: Газар ашиглалтыг өөрчлөх тохиолдолд орон нутгийн иргэдтэй зөвлөлдөж дэмжлэг авдаг байх	Барилгын ажил эхлэхээс өмнө	БОАЖЯ	тэмдэглэл хөтлөх
	SM 1.3: Гомдол барагдуулах арга механизмын үйл явцыг дагаж биелүүлэх явдлыг баталгаажуулдаг байх	Барилга болон ашиглалтын бүхий л үе шатанд	БОАЖЯ	тэмдэглэл хөтлөх
SM2: Барилга/ашиглалтын үйл ажиллагааны улмаас олон нийтийн тайван амгалан байдал алдагдах (жишээ нь, дуу чимээ, тоос шороо гэх мэт)	SM 2.1: Аливаа үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө олон нийтийн зөвлөгөөн зохион байгуулдаг байх	Барилгын ажил эхлэхээс өмнө	БОАЖЯ	тэмдэглэл хөтлөх
	SM 2.2: Зохих менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлдэг байх (ESMF-ийн дуу чимээ, агаар, ESCP, хог хаягдлын хэсгийг харна уу)	Барилга болон ашиглалтын үйл ажиллагаа	Талбайн удирдлага, шинжээч БОАЖЯ ба	Өдөр бүр, тэмдэглэл хөтлөх
	SM 2.3: Гомдол барагдуулах арга механизмын үйл явцыг дагаж биелүүлэх явдлыг баталгаажуулах	Бүх үе шатанд	БОАЖЯ	Тэмдэглэл хөтлөх

5.10 Гамшгийн үеийн менежментийн арга хэмжээ

310. Хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчинд (ноцтой) гэмтэл учруулахуйц нөхцөл байдал тохиолдох үед хохирлын цар хүрээг хязгаарлахын тулд гамшгийн хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
311. Гардан хэрэгжүүлэгч байгууллага нь (The delivery organisation) байгууллагын хөдөлмөр хамгаалал, эрүүл мэнд, аюулгүй байдлын талаарх бодлого болон Монгол улсын зохих хууль тогтоомжид заасан шаардлагыг хэрэгжүүлэхдээ төслийн хүрээнд гамшгийн үеийн хариу арга хэмжээг хавсарган хэрэгжүүлнэ.

5.10.1 Гүйцэтгэлийн шалгуур

312. Төслийн бүтээн байгуулах зорилгоор дараах гүйцэтгэлийн шалгуурыг тогтоосон.
- гал түймэр гарч байгаагүй байх;
 - ус хураах байгууламжид ямар нэг эвдрэл, доголдол гарч байгаагүй байх
 - хими, түлш шатахуун хальж асгарсан тохиолдол гараагүй байх
 - Ажлын байранд эсхүл үйлдвэрлэлийн явцад урьдчилан сэргийлж болох осол, аваар эндэгдэл гарч байгаагүй байх
 - бүх нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчинд эрсдэл учруулах эрсдэлтэй нөхцөл байдал үүсэх тохиолдолд зохих арга хэмжээг яаралтай, үр дүнтэй байдлаар авч хэрэгжүүлэх
 - урьдчилан сэргийлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд байгаль орчинд учрах сөрөг нөлөөг аль болох бууруулах

5.10.2 Хяналт шинжилгээ

313. Гамшгийн үеийн хариу арга хэмжээний хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулсан (Хүснэгт 15). Хөтөлбөрийг баталж хэрэгжүүлж эхэлснээс хойш 2 сар тутамд эргэн харж зохих өөрчлөлтийг тусгана. Хамгийн чухал нь хээрийн/талбайн ажилтан өдөр бүр ажиглалт явуулж БОАЖЯ болон ХХААХҮЯ-д тайлагнана. НҮБХХ-ийн ажилтнууд 7 хоногт ядаж 1 удаа ажиглалт явуулж илэрсэн алдаа зөрчлийн талаар EMSF-д мэдэгдэл хүргүүлнэ.

5.10.3 Тайлагнал

314. Гал түймэр, эсхүл хүний эрүүл мэндэд хамаатай, байгаль орчинд ноцтой хохирол учруулахуйц гамшгийн нөхцөл байдал тохиолдвол БОАЖЯ, ХХААХҮЯ болон НҮБХХ-ийн ажилтнуудад нэн даруй мэдэгдэх ёстой.



GREEN
CLIMATE
FUND

Хүснэгт 5 Гамшгийн үеийн менежментийн арга хэмжээ

Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ

Асуудал	Хяналтын үйл ажиллагаа (болон эх үүсвэр)	Арга хэмжээ авах хугацаа	Үүрэг хариуцлага	Хяналт, шинжилгээ болон тайлагнал
E1. Гал түймэр, гамшгийн үеийн менежмент ба урьдчилан сэргийлэх стратеги хэрэгжүүлэх	E1.1: Шатах, дэлбэрэх аюултай шингэн овоолох/агуулах талбайн дизайныг зохих олон улсын стандартын дагуу боловсруулсан байх	Барилгын ажил явагдахын өмнө болон явагдах үед	Гүйцэтгэгч байгууллага	тэмдэглэл хөтлөх
	E1.2: Талбайд гал унтраагч байрлуулах	Барилгын ажил явагдах үед	Гүйцэтгэгч байгууллага	Өдөр бүр, тэмдэглэл хөтлөх
	E1.3: Төслийн талбайд ил задгай гал түлэхийг хориглох	Барилгын ажил явагдах үед	Хээрийн/талбайн ажилтан	Өдөр бүр, тэмдэглэл хөтлөх
	E1.4: Барилгын үйл ажиллагаа эхлэхээс өмнө харилцаа холбооны тоног төхөөрөмж, гамшгийн хариу арга хэмжээний дэг, протоколыг тогтоосон байх	Барилгын ажил явагдах үед	Гүйцэтгэгч байгууллага	тэмдэглэл хөтлөх
	E1.5: Бүх ажилчдыг гамшгийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний талаарх сургалтад хамруулах (ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын сэдвийг багтаасан байх) NDMO-той харилцан зохицож ажиллах	Барилгын ажил явагдах үед	Field Officer	тэмдэглэл хөтлөх
	E1.6: Анхан шатны эмнэлгийн тусламжийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж дутуу нөөцийг сэлбэж гүйцээх	Барилгын ажил явагдах үед	Field Officer	Сар бүр, тэмдэглэл хөтлөх
	E1.7: Хувийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хэрэглээ, зориулалт	Барилгын ажил явагдах үед	All Personnel	Өдөр бүр



6 БОНҮНМБХХ (ESMF)-ийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв

315. БОНҮНМБХХ (ESMF)-г хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг дараах байдлаар тооцоолов.

Зүйлс	Төсөв
БОНҮНМБХХ (ESMF)-г хянаж зохих өөрчлөлтийг тусгаж аудит хийх	\$20,000
БОНҮНМБХХ (ESMF)-н ерөнхий зардлууд	\$20,000
Экологийн хяналт шинжилгээ	\$80,000
Усны чанарын хяналт шинжилгээ	\$120,000
Усны чанарын дээжийн лабораторын дүн шинжилгээ	\$100,000
Тунадасны дээжийн талбайн сорилт	\$30,000
Тунадасны дээжийн лабораторын дүн шинжилгээ	\$40,000
Хөрсний элэгдэл, ус хурах сав газар, тунадасны хяналтын төлөвлөгөө	\$200,000
Хамтрагч талуудын оролцоог хангах	\$100,000
Сургалт	\$100,000
Гомдол барагдуулах механизм	\$50,000
Нийт	\$860,000

Тэмдэглэл – Төсөл хэрэгжүүлэх бүхий л үе шатанд хяналт шинжилгээг шаардлагатай түвшинд авч хэрэгжүүлэх



**Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ**

Хавсралт



Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ

Хавсралт 1

НҮБХХ-ийн SESP

Хавсралт 6а– SESP-г харна уу

Хавсралт 2:

БОНҮНМБХХ (ESMF)-ийн агуулга

БОНҮНМБХХ (ESMF)-г байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний нэг хэсэг байдлаар, аль эсвэл бие даасан баримт бичиг хэлбэрээр боловсруулах боломжтой⁷. БОНҮНМБХХ (ESMF)-н агуулгад дараах хэсгийг зайлшгүй багтаасан байвал зохино.

(1) **Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ:** Аливаа сөрөг нөлөөллийг бууруулах эрэмбэ тогтоох зарчмын дагуу нийгэм, байгаль орчинд учрах сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, боломжгүй тохиолдолд нийгэм, байгаль орчинд нөлөөлөх байдлыг зохих түвшинд хүртэл бууруулах арга хэмжээг энд тодорхойлж өгнө. Тухайлбал, БОНҮНМБХХ (ESMF) нь: (a) нийгэм, байгаль орчинд нөлөөлөх аливаа томоохон сөрөг үр дагаврыг урьдчилан тодорхойлж дүгнэлт өгнө (b) авч хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүрийг-техникийн нарийн мэдээллийн хамт-тухайлбал учрах сөрөг нөлөөний төрөл, шаардагдах нөхцөл (жишээ нь байнгын, нөөц арга хэмжээ авах үеийн); мөн дизайн, тоног төхөөрөмжийн тодорхойлолт, ашиглалтын журам зэргийг нарийвчлан тодорхойлж бичсэн байна. (c) эдгээр арга хэмжээний нийгэм, байгаль орчны үр нөлөөллийн тооцоолол, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлснээс хойшхи үр нөлөө, (d) сөрөг нөлөөллийг бууруулах бусад төлөвлөгөөг (жишээ нь нүүлгэн шилжүүлэх, нутгийн уугуул иргэдэд зориулсан гэх мэт) харгалзан үзсэн, нийцүүлсэн байна.

(2) **Хяналт шинжилгээ:** Хяналт шинжилгээний зорилтуудыг тодорхойлж төрөл хэлбэрийг тодорхойлно. Ингэхдээ БОНҮНМБХХ (ESMF)-д тодорхойлсон байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тогтоогдсон нөлөө, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээтэй уялдуулсан байна. Тухайлбал, БОНҮНМБХХ (ESMF)-н хяналт шинжилгээний хэсэгт (a) хяналт шинжилгээний арга хэмжээний нарийн тодорхойлолт, техникийн нарийн мэдээлэл, үүнд хэмжих параметрууд, хэрэглэх арга, дээж авах байршил, хэмжилтийн давтамж, детект хийх хязгаар (боломжтой тохиолдолд), залруулах арга хэмжээ авах босго нөхцлийн (thresholds) тодорхойлолт (b) хяналт шинжилгээ явуулах тайлагнах журмыг дараах 2 зорилгын хүрээнд тодорхойлж бичсэн байна. үүнд (i) сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг зайлшгүй авч хэрэгжүүлэх нөхцөл байдлыг эрт илрүүлж тогтоох (ii) сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний үйл явц, үр дүнгийн талаарх мэдээллийг бэлтгэх

(3) **Чадавхи бэхжүүлэх, сургалт:** Нийгэм, байгаль орчны төслийн бүрдэл, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг цаг тухайд нь үр дүнтэй хэрэгжүүлэх үйл явцыг дэмжихийн тулд БОНҮНМБХХ (ESMF)-г боловсруулахдаа байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний үр дүн, төслийн /барилгын талбайн үйл ажиллагааг хариуцсан байгууллага, яам агентлагийн ажилтнуудын үүрэг роль, нөөц, чадавхид үндэслэн гаргадаг. Тухайлбал БОНҮНМБХХ (ESMF) –д институтын зохицуулалт, сөрөг нөлөөллийг бууруулах, хяналт шинжилгээний арга хэмжээг (Жишээ нь, үйл ажиллагаа, ашиглалт, хяналт, хэрэгжилтийг сахиулах, хяналт шинжилгээ хийх, хариу арга хэмжээ авах санхүүжүүлэх, тайлагнах, ажилтан албан хаагчдыг сургаж дадлагажуулах гэх мэт) хариуцсан байгууллага, оролцогч талуудыг тодорхойлсон байдаг. Нийгэм байгаль орчны менежментийн чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг шаардлагатай нь тогтоогдвол ажилтнуудыг сургах болон сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх, байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээнд тусгагдсан бусад зөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох бусад нэмэлт арга хэмжээг авч хэрэгжүүлэх (байгууллагын) нэгжийг бий болгох, хариуцсан нэгжийг өргөтгөх зэрэг зөвлөмжийг БОНҮНМБХХ (ESMF)-д тусгасан байдаг.

(4) **Хамтрагч талуудын оролцоог хангах:** Төслийн хүрээнд хамтрагч талуудтай харилцан зөвлөлдөх үйл явцыг утга учиртай, үр дүнтэй, мэдээлэлд тулгуурласан байдлаар явуулахын тулд тусгай төлөвлөгөө боловсруулсан байна. Төлөвлөгөөнд дараах мэдээллийг тусгасан байна. Үүнд: (a) үнэлгээний явцад холбогдох буюу нөлөөлөлд өртсөн хүмүүст мэдээлэл хүргэх, тэднийг оролцуулахад

⁷ Төслийг гэрээт байгууллагууд гүйцэтгэх тохиолдолд энэ нь маш чухал заалт болно. Төлөвлөгөөнд гүйцэтгэгч байгууллагуудад тавигдах шаардлагуудыг нарийн тодорхой тусгаж өгсөн байдаг. Энэ тохиолдолд гүйцэтгэгч байгууллагуудтай хийх гэрээнд ESMF –г гэрээний салшгүй хэсэг болгон тусгаж өгөх бөгөөд зохих хяналт шинжилгээ, заавал биелүүлэх заалтуудыг хавсаргаж өгсөн байх шаардлагатай.



GREEN
CLIMATE
FUND

**Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ**
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ

ашиглах арга хэрэгсэл (b) төслийг хэрэгжүүлэх үеэр хамтрагч талуудын оролцоог утга учиртай, үр дүнтэй байдлаар хангах төлөвлөгөөний дүгнэлт. Үүнд: зөвлөлдөх үйл явцын тэмдэглүүштэй хэсгийг цохон тэмдэглэх байдал, мэдээллийн нээлттэй байдал, төслийн хэрэгжилтийн явцын талаарх байнга тайлагнах шаардлага зэргийг багтаасан байна. (c) төслийн нийгэм, байгаль орчинд нөлөөлөх байдал, гүйцэтгэлийн талаархи хамтрагч талуудын гомдлыг хүлээн авах, барагдуулах үйл явцыг үр дүнтэй явуулах танилцуулга мэдээлэл

(5) Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт (хуваарь, төсөв зардлын тооцоолол): (Сөрөг нөлөөллийг бууруулах, хяналт шинжилгээ явуулах, чадавх бэхжүүлэх, хамтрагч талуудын оролцоог хангах) дээрх дөрвөн төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд БОНҮНМБХХ (ESMF) -д дараах зүйлсийг тусгасан байна. Үүнд (a) төслийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн хуваарь, тухайлбал төслийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний үе шатыг уялдуулж харгалзан үзсэн байна. (b) БОНҮНМБХХ (ESMF)-г хэрэгжүүлэхэд шаардлагатай капитал болон урсгал зардлын тооцоо, санхүүжилтийн эх үүсвэр. Эдгээр тооцоог төслийн нийт зардлын тооцоонд тусгасан байна. Хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаа тус бүрийг нарийвчлан тодорхойлж зохих зардлын хамт төслийн ерөнхий төлөвлөлт, дизайн, төсөв хэрэгжилтэд нягт уялдуулж тусгасан байна.



Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ

Хавсралт 3

Хамтрагч талуудтай зөвлөлдөх тайлан

Хавсралт 7а –Хамтрагч талуудтай зөвлөлдөх тайлан гэсгийг харна уу



Хавсралт 4: Хамтрагч талуудын оролцоог хангах төлөвлөгөө

Хавсралт 7b– Хамтрагч талуудын оролцоог хангах төлөвлөгөөг харна уу.

Хавсралт 5:

Нийгэм ба байгаль орчны нийцлийн нэгж (SECU) болон эсхүл хамтрагч талуудын хариу арга хэмжээ авах механизмд (SRM)-д гомдол гаргах заавар

Хүснэгтийн зорилго

- Хэрэв та энэхүү хүснэгтийг ашиглах бол хариултаа текстээс ялган харуулахын тулд тод хараар тодруулж бичнэ үү.
- Энэхүү хүснэгтийг ашиглахыг бид зөвлөмж болгож байгаа бөгөөд таны хувьд заавал ашиглах албагүй болно. Энэхүү хүснэгт нь гомдол гаргах үед чиглүүлэх үүрэг гүйцэтгэх боломжтой.

Энэхүү хүснэгтийг дараах үйл явцыг хялбаршуулахад хэрэглэх зорилготой.

- (1) Таны зүгээс НҮБХХ нийгэм ба байгаль орчны талаарх бодлого, үүргээ биелүүлэхгүй байгаа бөгөөд үүний улмаас та өөрийгөө хохирч буй хэмээн үзэж байвал энэхүү хүснэгтийг ашиглан гомдлоо өргөн мэдүүлж болно. Таны гомдол хүсэлт НҮБХХ-ийн аудит, хянан шинжлэх хэлтсийн дэргэдэх нийгэм ба байгаль орчны нийцэл хариуцсан нэгжийн (SECU) зүгээс бие даасан хөндлөнгийн хяналт буюу 'нийцлийн хянан шалгалтыг' эхлүүлэх үндэслэл болох боломжтой. Энэхүү хяналт шалгалтын гол зорилго нь НҮБХХ ямар нэг бодлого, үүрэг хариуцлагаа зөрчиж буй эсэхийг тодорхойлох, тэдгээрийг арилгах арга хэмжээг тодорхойлоход чиглэнэ. SECU нь нөхцөл байдлыг фактыг бүрэн тодорхойлохын тулд хяналт, шалгалтын үеэр тантай харилцан ярилцаж хяналт шалгалтын үр дүнгийн талаар танд мэдээлэл хүргэх болно.
- (2) Таны зүгээс НҮБХХ-ийн аль нэг төслийн зүгээс нь нийгэм ба байгаль орчинд нөлөө үзүүлж энэ нь танд сөргөөр нөлөөлж буй хэмээн үзэж байгаа бөгөөд энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд сөрөг нөлөөлөлд өртөж буй орон нутгийн бусад иргэд, хамтрагч талуудыг (Жишээ нь, Засгийн газрын төлөөлөгч, НҮБХХ гэх мэт) нэгтгэх үйл явцыг эхлүүлэх сонирхолтой тохиолдолд “Оролцогч талуудын хариу арга хэмжээ” гэсэн өргөдлийг НҮБХХ-т илгээж болно. Оролцогч талуудын хариу арга хэмжээ хэмээх энэхүү үйл явцыг НҮБХХ-ийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар өөрөө гардан, аль эсвэл НҮБХХ-ийн төв байгууллагаар дамжуулан явуулах боломжтой. Энэхүү хариу үйл явцын хүрээнд НҮБХХ-ийн ажилтнууд нөхцөл байдлыг тодруулах, шийдэл боловсруулах зорилгоор тантай хувьчлан уулзаж ярилцах болно. Шаардлагатай тохиолдолд төслийн бусад хамтрагч талуудыг оролцуулах боломжтой.

Хэрэв та асуудлыг шийдвэрлэх талаар төр засгийн төлөөлөл, тухайн төслийг хариуцсан НҮБХХ-ийн ажилтнуудтай шууд харилцаж яриа хэлэлцээр явуулж амжаагүй тохиолдолд НҮБХХ-ийн оролцогч талуудын хариу арга хэмжээ авах механизмд гомдол гаргахаасаа өмнө тийнхүү үйлдэхийг танд зөвлөж байна.

Нууцлал Хэрэв та Нийцлийн хяналт шалгалтын үйл явцыг сонгосон тохиолдолд нэрээ нууцалж болно. Зөвхөн нийцлийн хяналт шалгалтын багт таны нэрийг мэдээлэх болно. Хэрэв та Оролцогч талуудын хариу арга хэмжээ авах механизмыг сонгох тохиолдолд эхний шатны тандалт үнэлгээний үеэр нэрээ нууцалж болно. Хэрэв таны гомдлыг зохистой хэмээн зохих хариу авах шаардлагатай нь тогтоогдвол НҮБХХ-ийн ажилтнууд хариу арга хэмжээний талаар тантай зөвлөлдөж тодорхой арга хэмжээг санал болгож таны нэрийг нууцлах эсэх, нууцлах тохиолдолд хэрхэн гүйцэтгэх талаар тантай ярилцаж санал солилцох болно.

Зааварчилгаа

Та аливаа гомдол, шаардлага гаргахдаа аль болох дэлгэрэнгүй мэдээлэл өгөх нь зүйтэй. Хэрэв та хүснэгтээ бүрэн гүйцэд бөглөж амжаагүй байхдаа санаандгүй имэйл-ээ явуулсан, эсхүл нэмж мэдээлэл илгээхийг хүсвэл, эдгээр хүсэлтээ тайлбарласан өөр шинэ имэйл явуулахад л болно.

Таны талаарх мэдээлэл

Та . . .



Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ

1. Та НҮБХХ-ийн дэмжлэгтэй хэрэгжиж буй төслийн үйл ажиллагаанд ямар нэг байдлаар өртсөн үү?
Тийм: Үгүй:

Та сонгосон хариултаа “Х”-ээр тэмдэглэнэ үү. Тийм: Үгүй:

2. Төслийн үйл ажиллагаанд өртсөн хувь этгээд эсхүл бүлгийн албан ёсны төлөөлөгч үү Тийм:
Үгүй:

Та сонгосон хариултаа “Х”-ээр тэмдэглэнэ үү. Тийм: Үгүй:

Хэрэв та албан ёсны төлөөлөгч бол төлөөлж буй бүх хүний нэр, мөн тэдгээр хүмүүсээс төлөөлөх эрхийг танд олгосон баримт бичгийг өгнө үү. Энэхүү хүснэгтэд нэг эсвэл хэд хэдэн файлыг хавсаргаж илгээнэ үү.

3. Нэр:
4. Овог:
5. Бусад мэдээлэл:
6. Мэйл хаяг:
7. Цахим шуудангийн хаяг:
8. Утасны дугаар (улсын код):
9. Оршин суух хаяг:
10. Хамгийн ойр орчмын хот, тосгон:
11.
Холбоо барих нэмэлт мэдээлэл:
12. Харьяа улс:

НҮБХХ-д гаргаж буй хүсэлт, гомдол: Нийцлийн хяналт шалгалт ба / эсхүл хамтрагч талуудын хариу арга хэмжээ

Танд 4 сонголт бий:

- Нийцлийн шалгалт явуулах хүсэлт илгээх;
- “Хамтрагч талуудын хариу арга хэмжээ” хүсэлт илгээх;
- Аль алиныг нь явуулах хүсэлт илгээх;
- Энэ хоёр хүсэлтийн аль нь таны нөхцөлд илүү тохиромжтойг баттай мэдэхгүй тул аль аль байгууллагад хариу арга хэмжээ авах хүсэлт гаргах

13. НҮБХХ-ийн зүгээс нийгэм болон/эсхүл байгаль орчны талаарх бодлого, үүрэг хариуцлагаа биелүүлээгүй нь танд эсвэл таны төлөөлж буй иргэдэд сөргөөр нөлөө үзүүлж буйд таны зүгээс санаа зовж гомдол гаргаж байна уу?

Та сонгосон хариултаа “Х”-ээр тэмдэглэнэ үү. Тийм: Үгүй:

14. Нийцлийн хяналт шалгалтын явцад та нэрээ нууцлахыг хүсч байна уу?

Та сонгосон хариултаа “Х”-ээр тэмдэглэнэ үү. Тийм: Үгүй:

Хэрэв та нэрээ нууцлах хүсэлтэй бол шалтгаанаа тодорхой бичнэ үү.

15. НҮБХХ-ийн төслөөс улбаатай нийгэм, байгаль орчинд учрах сөрөг нөлөөлөл, эрсдэлийг шийдвэрлэхийн тулд та бусад хамтрагч талуудтай жишээ нь Засгийн газар, НҮБХХ гэх мэт хамтарч ажиллах хүсэлтэй юу?

Та хариултаа “Х-ээр тэмдэглэнэ үү. Тийм: үгүй:

16. Та анхан шатны тандалт үнэлгээний үеэр нэрээ нууцалсан хэвээр байлгахыг хүсч байна уу?

Та сонгосон хариултаа “Х”-ээр тэмдэглэнэ үү. Тийм: үгүй:

Хэрэв нууцлах бол шалтгаанаа бичнэ үү.



Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ

17. Оролцогч талуудын хариу арга хэмжээ гэсэн өргөдлийн дагуу таны зүгээс НҮБХХ-ийн төв байгууллагаар шалгуулах хүсэлт гаргаагүй тохиолдолд НҮБХХ-ийн суурин төлөөлөгчийн газар өөрөө хяналт шалгалтыг явуулах болно. Таны зүгээс НҮБХХ-ийн төв байгууллагаар шалгуулах хүсэлтэй юу?

Та сонгосон хариултаа “Х”-ээр тэмдэглэнэ үү. Тийм: үгүй:

Хэрэв тийм гэсэн бол шалтгаанаа бичнэ үү.

18. Та нийцлийн хяналт шалгалт, оролцогч талуудын хариу арга хэмжээ гэсэн хоёр шалгалтын аль алиныг хүсч байна уу?

Та сонгосон хариултаа “Х”-ээр тэмдэглэнэ үү. Тийм: үгүй:

19. Та хоёр шалгалтын аль хэлбэрийг сонгохоо баттай сайн мэдэхгүй байна уу?

Та сонгосон хариултаа “Х”-ээр тэмдэглэнэ үү. Тийм: үгүй:

Таны санааг зовоож буй, гомдол гаргахад хүргэж буй төслийн талаарх мэдээлэл, таны гол санаа тавьж буй асуудал

20. Та НҮБХХ-ийн ямар төслийн талаар гомдол гаргаж байгаа вэ? (Хэрэв мэдэж байгаа бол):

21. Төслийн нэр (Хэрэв мэдэж байгаа бол):

22. Төслийн талаарх гомдол, санаа зовоож байгаа асуудлын талаар товч бичнэ үү. Таны зүгээс НҮБХХ нийгэм, байгаль орчны талаарх бодлого, амлалт үүргээ зөрчиж байна хэмээн үзэж байгаа бол тэрхүү бодлого, амлалт үүргийг тодорхойлно уу. (зайлшгүй шаардлагатай биш) Байгаль орчин, нийгэмд хэдийнэ хохирол учруулсан эсвэл хохирол учруулж болзошгүй байгаа нөлөөллийн төрлийн талаар тодорхойлж бичнэ үү. Бичих зай талбай шаардлагатай бол нэмэлтээр баримтууд хавсаргаж болно. Та өөрийн сонгосон аль ч хэлээр бичиж болно.

-
-
-
-

23. Та энэхүү асуудлын талаар Засгийн газрын төлөөлөл, төсөл хариуцсан НҮБХХ-ийн ажилтнуудтай уулзаж ярилцсан уу? ТББ-ын төлөөлөлтэй уулзсан уу?

Хариултаа “Х”-ээр тэмдэглэнэ үү. Тийм: үгүй:

Хэрэв тийм бол уулзаж ярилцсан хүмүүсийнхээ нэрийг бичнэ үү.

Энэхүү асуудлын хүрээнд холбоо барьсан ажилтнуудын нэрс

Нэр	Овог	Албан тушаал / Харьяа байгууллага	Уулзсан өдөр огноо	Тэдний/Хувь өгсөн хариу	этгээдийн
-----	------	--------------------------------------	-----------------------	----------------------------	-----------

24. Энэхүү төслийн хүрээнд сөрөг нөлөөнд өртсөн, өөр хувь хүн, бүлэг хүмүүс бий юу?

Та сонгосон хариултаа “Х”-ээр тэмдэглэнэ үү. Тийм: Үгүй:

25. Таны хүсэлт / өргөдлийг дэмжиж буй бусад хувь хүн, бүлэг хүмүүсийн нэр болон / эсхүл бусад товч мэдээллийг өгнө үү



**Хавсралт 6б – Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийг
удирдан, зохицуулах (менежментийн) бүтэц, хамрах хүрээ**
УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖИЛТИЙН САНАЛ

Нэр

Овог

Албан тушаал / Харъяа Холбоо барих мэдээлэл
байгууллага

Та SECU болон SRM-д илэрхийлэх, илгээхийг хүсч буй ямар нэг баримт бичиг байвал емэйлд хавсаргана уу. Хэрэв нэг имэйлд багтахсааргүй бол олон имэйл явуулах бүрэн боломжтой.

Гомдол, хүсэлт илгээх, дэмжлэг

Та гомдол, хүсэлтээ илгээхийг хүсвэл, эсвэл танд ямар нэг дэмжлэг шаардлагатай бол project.concerns@undp.org хаягаар хүсэлтээ илгээнэ үү.